

Батлав. Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Ж.Даш-Яйчил

Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

Иргэний Нисэхийн Ерөнхий Газрын,  
Иргэний Нисэхийн Үндэсний Төвийн дарга

"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал



Э.Төрбаяр

Китанака Такэфуми

---

Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байрлах  
"Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал,  
шатахууны агуулах"-ын  
Байгаль орчны менежементийн төлөвлөгөөний  
биелэлтийн тайлан - 2023 он

---

Хянасан:

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын  
газрын мэргэжилтэн

П.Шинэцэцэг

Боловсруулсан:

"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн Олон нийттэй харилцах,  
тогтвортой хөгжлийн хэлтсийн дарга

*Elkhseikhon B.*

Б.Энхсайхан

Иргэний нисэхийн ерөнхий газар,  
Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа  
Шинэ нисэх буудлын Шатахуун хангамжийн албаны  
ерөнхий инженер

*T. Batmunga*

Г.Баттулга

Улаанбаатар хот  
2023 он



**НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ ХХК**



**ИНЕГ, ИНУТ-ИЙН “ЧХОУНБ” ДАХЬ  
ШАТАХУУН ХАНГАЛТЫН АЛБА**

**ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ  
“УЛААНБААТАР ХОТЫН ОЛОН УЛСЫН ШИНЭ НИСЭХ БУУДАЛ,  
ШАТАХУУНЫ АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

## НЭГ. “ОЛОН УЛСЫН ШИНЭ НИСЭХ БУУДАЛ, ШАТАХУУНЫ АГУУЛАХ”-ЫН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 ТӨСЛИЙН ТУХАЙ

#### 1.1.1 Төслийн үндэслэл

**Төсөл хэрэгжих үндэслэл.** Япон улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Хөшгийн хөндийд Олон Улсын шинэ нисэх буудал барих албан ёсны хүсэлтийг Монгол Улсын Засгийн газар 2006 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Япон Улсын Засгийн газарт тавьсаны үр дүнд “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл”-ийг хэрэгжүүлэхээр Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох “MON-P8” хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийг 2008 оны 05 дугаар сарын 01-нд байгуулж, мөн сарын 29-нд УИХ-аар баталсан. Япон Улсын Засгийн газраас хөнгөлөлттэй зээлийг олгохыг шийдвэрлэж, Хөшигийн хөндийн Олон Улсын нисэх онгоцны буудал барих төсөл Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын нэрийн дор хэрэгжсэн.

**Төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл.** Япон Улсын зөвлөх үйлчилгээ үзүүлэх “АЗУСА СЭККЭЙ/ОРИЕНТАЛ КОНСАЛТИНГ” компаниудын хамтарсан түншлэл нь урьдчилсан зураг төслийн хүрээнд шинэ нисэх буудлын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, Зам, тээвэр барилга хот байгуулалт (ЗТБХБ)-ын сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн үндсэн барилга байгууламжийн их загвар зургийн зөвшөөрөл авсан бөгөөд ерөнхий төлөвлөгөөг 2010 онд батлуулсан. Энэхүү ерөнхий төлөвлөгөө нь 2007, 2010 онуудад захиалгаар мэргэжлийн байгууллагуудын гүйцэтгэсэн инженер-геологийн судалгаанд үндэслэсэн байдаг.

**Төслийн гүйцэтгэгчид.** Хөшигийн хөндийн Олон улсын нисэх онгоцны буудал барих төслийн ерөнхий гүйцэтгэгчээр Япон улсын “Мицубиши/Чиёода” компанийн түншлэл ажилласан. Ерөнхий туслан гүйцэтгэгч компаниар БНСУ-ын “Самсунг С&Т” корпораци сонгогдож, Монгол улсад “Эс Си Ти И Си Эм” ХХК-ийг байгуулан, 2013 оны 06 дугаар сараас нисэх онгоцны буудал барих ажлыг эхлүүлсэн. Шинэ нисэх буудлын барилгыг 2017 онд улсын комисс хүлээн авсан бөгөөд мөн оноосоо эхлэн ИНЕГ-т хүлээлгэн өгөх ажлыг үе шаттай хэрэгжүүлсэн.

#### 1.1.2 Төслийн зорилго

**Үндэслэл:** Хуучин Буянт-Ухаа дахь “Чингис хаан” Олон улсын нисэх буудалд учирч байсан хүндрэлүүдийг бүрэн шийдвэрлэхийн тулд шинэ нисэх буудал барих шаардлага тулгарсан. Үүнд: 1) Уулын саадаар хязгаарлагдсан тул хоёр талаасаа хөөрч буух зурвас, нэмэлт зурвас төлөвлөх зай талбайгүй; 2) Аэродромын хөөрч буух зурвас “Олон улсын иргэний агаарын тээврийн шаардлага болох 1%-ийн налуутай байх ёстой” гэсэн шаардлагад тэнцэхгүй; 3) Өмнө болон баруун өмнө зүгээс том оврын онгоц буух боломж байхгүй; 4) Улаанбаатар хотын утаанаас хамаарч өвлийн улиралд нислэг саатдаг; 5) Зорчигчийн терминалын хүчин чадал хүрэлцэхгүй болсон;

**Зорилго:** Шинэ нисэх буудал барьж, ашиглалтад оруулснаар дээрх хүндрэлүүдийг арилгах, нислэгийн аюулгүй ажиллагааны хангалтыг дээшлүүлэх, агаарын тээвэрлэлтийг тогтворжуулах, эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих.



Хаяг, улсын бүртгэл:

- ✓ Улсын бүртгэлийн дугаар: 9013001003
- ✓ Регистрийн дугаар: 2628546
- ✓ Хаяг: Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа
- ✓ Утас: 976-11-282067
- ✓ Мэйл хаяг: [info@mcaa.gov.mn](mailto:info@mcaa.gov.mn)
- ✓ Вэб хуудас: <https://www.mcaa.gov.mn/>

### 1.2.2 Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК

Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК (НУБИЭ ХХК) нь Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 261 дүгээр тогтоолоор Монгол улсын 49 хувь, Япон улсын 51 хувийн оролцоотойгоор 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдөр байгуулагдсан.

Тус компанийн 49 хувийг Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 150 дугаар тогтоолоор байгуулагдсан “Хөшигийн Хөндийн Нисэх Онгоцны Буудал” ТӨХХК эзэмшдэг бөгөөд 51 хувийг Японы Мицүбиши корпораци, Нарита Олон улсын нисэх буудал, ЖАТКО (Japan Airport Terminal Co., Ltd), ЖАЛУКС (JALUX Ltd.) компаниудын хөрөнгө оруулалттай тусгай зориулалтын компани болох “Жапан Эйрпорт Менежмент” ХХК эзэмшдэг.

Хаяг, улсын бүртгэл:

- ✓ Улсын бүртгэлийн дугаар: 000168199
- ✓ Регистрийн дугаар: 3874095
- ✓ Хаяг: Төв, Сэргэлэн, 4 дүгээр баг, Эрдэнэ-Уул, /41090/ Тахилт толгой
- ✓ Утас: 7128 7360, 7128 7385
- ✓ Мэйл хаяг: [info@nubia-llc.mn](mailto:info@nubia-llc.mn)
- ✓ Вэб хуудас: <https://www.nubia-llc.mn/>

НУБИЭ ХХК-ийн үндсэн үйл ажиллагаа нь концессын гэрээгээр хүлээн авсан барилга байгууламж, систем, тоног төхөөрөмжийг ашиглан зорчигчид болон ачаа тээш, шууданг аюулгүй, тав тухтай тээвэрлэхэд бэлдэх, нислэг үйлдвэрлэлийг дэд бүтцээр хангах юм.

Компанийн философи, бодлого: Бид, нисэх буудлын аюулгүй, тав тухтай байдлыг нэн тэргүүнд тавьж, Монгол Улсын агаарын үүд хаалга болох нисэх буудлын үйл ажиллагаа, чадамжийг сайжруулж, үйлчлүүлэгчиддээ чанартай үйлчилгээг үзүүлснээр нисэх буудлын үнэ цэнийг дээшлүүлж, Монгол улсын хөгжилд хувь нэмэр оруулахыг зорино.

Монгол, Японы хамтын ажиллагааны шинэ билэг тэмдэг, Монгол Улсын агаарын үүд хаалга болон баригдсан Шинэ нисэх буудлын үйл ажиллагаагаар дамжуулан, дэлхийн өнцөг булан бүрээс Монгол улсыг зорин ирэх зочид, Монгол улсын иргэдийн үйлчлүүлэх дуртай нисэх буудал болгохын төлөө ажиллана.



Гадаад дотоодын хотуудыг агаараар холбон, онгоцны буудлаар үйлчлүүлж буй бүх зорчигч, үйлчлүүлэгчдийн сэтгэл хангалуун, тав тухтай байх орчин нөхцлийг бүрдүүлж, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахын төлөө ажиллана.

### 1.2.3 Газар олголт ба ашиглалт

Олон улсын шинэ нисэх буудал барих газрын байршил, нисэх буудлын хил заагийг Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн “Тусгай хэрэгцээний газарт хамааруулах тухай” 140 дүгээр тогтоолоор анх тогтоосон бөгөөд 2016 оны 154 дүгээр тогтоолоор хилийн заагийг өөрчлөн тогтоосон.

Хүснэгт 1. Газар олголтын шийдвэр, гэрчилгээжүүлэлт

№	Хэнд	Зориулалт	Шийдвэр, дугаар	Нийт талбай
1	Иргэний Нисэхийн Ерөнхий газар	Олон улсын нисэх буудал	Төв аймгийн Сэргэлэн сумын ЗД-ын 2020.05.06-ны А/269 дүгээр захирамж Улсын бүртгэлийн дугаар: 1419000027	1017 га
2	Улсын тусгай хэрэгцээ		ЗГ-ын 2016 оны 154 дүгээр тогтоол	12084.9 га
3	Зам, тээврийн хөгжлийн яам	Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх	ЗГ-ын 2016 оны 154 дүгээр тогтоол Гэрчилгээний дугаар: 000000004	2400 га



Төв аймгийн Сэргэлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 65 дугаар тогтоолоор Аэродромын аюулгүйн бүсийг тогтоосон.

Зураг 2. Нисэх буудлын аюулгүйн бүсийн зураг

Төв аймгийн Сэргэлэн сумын засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/244 тоот захирамжаар Аэродромын хяналтын цэгээс 3 км радиус дотор малтай айл буухыг хориглосон.

#### 1.2.4 Төслийн хүчин чадал

“Чингис хаан” Олон улсын шинэ нисэх буудал нь олон улсын стандартыг хангасан 30 гаруй барилга байгууламжтай иж бүрэн цогцолбор юм. Эдгээр барилга байгууламжуудыг төсөл хэрэгжүүлэгч ИНЕГ болон НУБИЭ ХХК-иуд өөрсдийн үйл ажиллагааны чиглэл тус бүрийн дагуу хариуцан ажиллаж байна.

#### 1.2.5 Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК, ИНЕГ-ын Иргэний нисэхийн үндэсний төвийн Шатахуун хангамжийн албаны тусгай зөвшөөрлүүд

##### 2 Тусгай зөвшөөрлүүд

Зөвшөөрөл, дүгнэлт	ИНЕГ, Иргэний нисэхийн үндэсний төвийн Шатахуун хангамжийн алба	Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК
1. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл Дугаар Хүчинтэй хугацаа Талбай	<ul style="list-style-type: none"> <li>- Агаарын хөлгийг шатах тослох материалаар хангах үйлчилгээний байгууллагын гэрчилгээ Дугаар МСАА.144.008/20 Хүчинтэй хугацаа 2024/05/24</li> <li>- Ашигт малтмал газрын тосны газар бүртгэлийн гэрчилгээ Дугаар 081 Хугацаагүй</li> <li>- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл Дугаар: 685</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрчим Хүчний Яам “Ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл” Дугаар 2045/23, Хүчинтэй хугацаа 5 жил, “Цахилгаан түгээх тусгай зөвшөөрөл” Дугаар 04/2021, Хүчинтэй хугацаа 3 жил, “Цахилгаанаар зохицуулалттай хангах Тусгай зөвшөөрөл” Дугаар 05/2021, Хүчинтэй хугацаа 3 жил,</li> <li>- Төв аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл “Дулаан үйлдвэрлэх Тусгай зөвшөөрөл” Дугаар 04/2020, Хүчинтэй хугацаа 5 жил, “Дулаан түгээх Тусгай зөвшөөрөл” Дугаар 05/2020, Хүчинтэй хугацаа 5 жил, “Дулаанаар зохицуулалттай хангах Тусгай зөвшөөрөл” Дугаар 06/2020, Хүчинтэй хугацаа 5 жил,</li> <li>- Боловсрол шинжлэх ухааны яам, “Цацрагийн үүсгүүр ашиглах, хадгалах тусгай зөвшөөрөл”, Гэрчилгээний дугаар 2023/02-128, Хүчинтэй хугацаа 5 жил.</li> <li>- Боловсрол шинжлэх ухааны яам, “Цацрагийн үүсгүүр ашиглах, хадгалах тусгай зөвшөөрөл”, Гэрчилгээний дугаар 2023/02-12, Хүчинтэй хугацаа 5 жил,</li> <li>- Харилцаа холбооны зохицуулах хороо “Радио давтамж ашиглах эрхийн бичиг” Дугаар 20511646, Хүчинтэй хугацаа 2 жил,</li> <li>- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл “Нийтийн аж ахуйн үйлчилгээ эрхлэх Тусгай зөвшөөрөл” Дугаар 00445, Хүчинтэй хугацаа 5 жил</li> </ul>
2. Тусгай зөвшөөрөл Дугаар Хүчинтэй хугацаа		Химийн хорт болон аюултай бодис ашиглах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл Дугаар 0001788, Хүчинтэй хугацаа 2 жил
3. Химийн бодис хадгалах ажлын байрны дүгнэлт		Төв аймгийн мэргэжлийн хяналтын газар “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 10 дугаар зүйлд заасан химийн бодис хадгалах агуулахад тавигдах үндсэн шаардлага, Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахтай, Ерөнхий шаардлага MNS 6458:2014 стандартын шаардлагад нийцсэн тухай дүгнэлттэй. Дугаар 19-04-002/131
4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	ИНҮТ ЧХОУНБ Шатахуун хангамжийн алба 2021 оны 06 сарын 30, Дугаар 2021018	- Зорчигч үйлчилгээний барилга – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006849, Хүчинтэй хугацаа 2 жил

		<ul style="list-style-type: none"> <li>- Газрын үйлчилгээний байгууламж – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006847, Хүчинтэй хугацаа 2 жил</li> <li>- Гал унтраах, авран хамгаалах албаны байгууламж – 2022 оны 08 сарын 16, дугаар 0006848, Хүчинтэй хугацаа 2 жил</li> <li>- Цахилгаан түгээх дэд өртөө – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006852, Хүчинтэй хугацаа 2 жил</li> <li>- Захиргааны барилга 2022 оны 08 сарын 16, дугаар 0006850, Хүчинтэй хугацаа 2 жил</li> <li>- Дулаан гараж – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006851, Хүчинтэй хугацаа 2 жил</li> <li>- Аэродромын байгууламж – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006846, Хүчинтэй хугацаа 2 жил</li> <li>- Дулааны станц – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006845, Хүчинтэй хугацаа 2 жил</li> <li>- Цэвэр усны байгууламж – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006843, Хүчинтэй хугацаа 2 жил</li> <li>- Бохир ус цэвэршүүлэх байгууламж – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006844, Хүчинтэй хугацаа 2 жил</li> <li>- Ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилга – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006853, Хүчинтэй хугацаа 2 жил</li> </ul>
--	--	---

## 2.2 НИСЭХ БУУДАЛД “НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ” ХХК-ИЙН ХАРИУЦСАН БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД

### 1.3.1 Аэродром

Том оврын агаарын хөлөг хөөрч, буух хоёр талын оролт, гаралттай, 3600 м урттай 45 м өргөнтэй зурвас, явгалах замтай. Аэродром нь ИКАО-ийн Хавсралт 14-ийн дагуу аэродромын лавлагаа код нь 4E буюу A330/B777 ангилалд тохирно. Энэ нь олон улсын

Зураг 3. Хөөрч, буух зурвас



нисэх буудлын хамгийн бага шаардлага, нисэх буудлын ашиглалтын аюулгүй байдлыг дээшлүүлэх I ангиллын нарийвчлалд нийцэх юм.

Агаарын хөлгүүд хоёр чиглэлд хөөрдөг, буудаг байх салхины болон геологийн тооцоололтойгоор байгуулагдсан.

### 1.3.2 Ачаа, шуудангийн үйлчилгээний барилга

Олон улсын болон орон нутгийн нислэгээр тээвэрлэгдэж ирсэн, тээвэрлэгдэж явах бүх төрлийн ачаа, шууданг нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангаж ачиж буулгах, тээвэрлэлтэд бэлтгэх, хүлээн авах болон хадгалах цогц үйлчилгээг Олон Улсын Иргэний нисэхийн байгууллага /ICAO/, Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооноос /IATA/ гаргасан стандарт, заавар, дүрмийн дагуу чанарын өндөр түвшинд үзүүлж байна.



**Зураг 4. Ачаа, шуудангийн үйлчилгээний барилга**

Ачаа, шуудангийн үйлчилгээний барилгын хүчин чадал: 1) Байгууламжийн ашигтай

талбай 3750 м<sup>2</sup>; 2) Жилд 11900 тонн карго ачаа, шуудан нэвтрүүлэх; 3) Аюултай ачааны агуулах эскпор импорт тус бүрт 28 м<sup>2</sup> талбайтай; 4) Үнэт ачааны агуулах эскпор импорт тус бүрт 28 м<sup>2</sup> талбайтай; 5) Хөргөлттэй агуулах 12 м<sup>2</sup>; 6) Хөлдөөгчтэй агуулах 44 м<sup>2</sup>; 7) Өндөр хүчин чадалтай 3 сэрээт өргөгчтэй;

### 1.3.3 Зорчигч үйлчилгээний барилга

Барилгажилтийн нийт талбай 53726м<sup>2</sup> ба үүний 37000м<sup>2</sup> нь үйлчилгээний зориулалттай.



**Зураг 5. Зорчигч үйлчилгээний барилга**

Жилд 2,3 сая зорчигчдод үйлчлэх хүчин чадалтай. Олон улсын зорчигчдын агаарын хөлөгт суух 5, орон нутгийн зорчигчдын

агаарын хөлөгт суух 1 хоолойтой, олон улсын бүртгэлийн 16, орон нутгийн бүртгэлийн 8 цэгтэй. Нисэх буудлын барилгын фасад нь өндөр чанарын давхар шилэн хийцтэй тул гадна агаарын өндөр хэм дотор орон зайн агаарын хэмд нөлөөлөхгүй байхаар хийгдсэн. Шилэн дээвэртэй тул нэг ба хоёрдугаар давхарын танхимуудыг байгалийн гэрэлтүүлэгээр гэрэлтүүлдэг.

### 1.3.4 Аврах, гал унтраах албаны барилга, машин техник

ИКАО-гийн 14-р хавсралт, Нисэх буудлын үйлчилгээний удирдамжийн 1 дүгээр хэсэгт заасны дагуу, 9 дүгээр категорийн нисэх буудлын хувьд гал түймрийн үед шаардагдах усны хамгийн бага хэмжээ нь 24300 литр байх бол хөөсөн уусмалын хувьд шүршилтийн хамгийн бага зэрэг нь (тухайн уусмалын үйлчлэлийн төвшин



**Зураг 6. Аврах, гал унтраах барилга, машин техник**

В байх нөхцөлд) 9000 литр/мин байна. Иймд хамгийн багадаа 8500 литр усны багтаамжтай, эсвэл

минутанд 3000 литр уусмал шүрших шүршилтийн зэрэг бүхий 3 ширхэг аврах буюу гал түймэртэй тэмцэх машин техникийг нисэх буудлын хувьд төлөвлөсөн.

“Гал унтраах багийнхан нь дохиолол хүлээн авснаас хойш харагдах орчны хүрээнд орших, замын нөхцөл сайтай зурвасын дурын хэсэгт 2 минутын дотор, агаарын хөлгүүдийн хөдөлгөөний талбай дахь бусад дурын цэгт 3 минутаас бага хугацаанд амжиж хүрэх ёстой” гэсэн ИКАО-гийн удирдамжийн шаардлагын дагуу гал унтраах анги нь зурвасын дунд хэсэгт ойрхон, агаарын хөлөг зурвас руу гарах зориулалт бүхий явгалах замаар дамжин зурваст хамгийн богино хугацаанд хүрэх боломжтой газар аврах, гал унтраах барилга байрлаж байна.

### 1.3.5 Цэвэр ус хангамжийн байгууламж



Зураг 7. Цэвэр усны байгууламж

Ундны усны эх үүсвэрийн гурван гүний худгаас ус олборлож, цэвэр ус хангамжийн байгууламжид байрлах түүхий ус хүлээн авах санд хүлээн авч,  $800\text{м}^3$  хүчин чадалтай филтэрэн системээр усыг цэвэршүүлж, ус хадгалах  $2\text{х}400\text{м}^3$  санд нөөцөлдөг. Дөрвөн өргөлтийн насосоор дамжуулан MNS900:2018 стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар нисэх буудлын бүс дэх бүх барилга байгууламжуудыг 24 цагийн турш тасралтгүй хангадаг.

### 1.3.6 Дулааны станц



Зураг 8. Дулааны станц

Дулааны станц нисэх буудлын барилгаас 4 км зайд байрладаг. Нийт 38 автомашины зогсоолтой. 2016 оноос дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Тус бүр нь 14МВт-ын хүчин чадал бүхий 3 зуухтай, нийт 42МВт суурилагдсан хүчин чадалтай. Үүнээс 2 зуух нь халаалтын улиралд байнгын ажиллагаанд, 1 зуух нь бэлтгэл байдалд буюу нөөцөд байхаар төлөвлөгдсөн. Нисэх буудлын барилга, байгууламжуудын халаалт, агаар сэлгэлтийн системийн халаалтын хэрэгцээг хангах зорилгоор тус бүр нь 14 мегаватт дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай, 150-170 градус параметртэй халуун ус гаргах 3 халаалтын зуухтай. Дулааны станц жилд ойролцоогоор 25,000 орчим тн хатуу нүүрсээр галлаж, 99,8 мян.м<sup>3</sup> ус зарцуулж, 80,000 орчим МВт дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай.

### 1.3.7 Цахилгаан хангамж



Зураг 9. Цахилгааны үндсэн дэд өртөөний барилга

Шинэ нисэх буудал нь 110/10кВ-ын “Хөшигт” дэд станцаас цахилгаан эрчим хүчээр хангагддаг. 110/35/10кВ-ын Налайх дэд станцаас 119 дүгээр агаарын шугамаар, 220/110/35кВ-ын Сонгино дэд станцаас 121, 122-р агаарын шугамаар, 110/10кВ-ын Бөхөг дэд станцаас 139, 140 агаарын шугам гэсэн 3 талын тэжээлтэй. Үндсэн, салбар дэд өртөөнүүд эрчим хүчний системээс хүчдэлгүй болсон тохиолдолд 50-2250кВ чадал бүхий дизель генераторуудаар барилгуудыг эрчим хүчээр хангана.

### 1.3.8 Цэвэрлэх байгууламж



Зураг 10. Цэвэрлэх байгууламж

Цэвэрлэх байгууламж нь Чех улсын “Хаанза” ХХК-ийн хоногт  $800\text{м}^3$  ус цэвэрлэх хүчин чадалтай бүрэн автомат удирдлагын системтэй. 2,2 км урт шугамтай, 2 өргөх станц, бохир усны 6 цооногтой. Цэвэрлэх байгууламжид ирж буй бохир ус нь “Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, төвшинд тавих үндсэн шаардлага” MNS 4288:1995

стандартын шаардлага хангасан бохирдолтой усыг хүлээн авна. “Нийтийн аж ахуйн ажил үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөлтэй.

### 1.3.9 Авто зогсоол, дулаан зогсоол



**Зураг 11. Авто зогсоол, дулаан зогсоол**

Авто зогсоолын багтаамжийг агаарын хөлгийн хөдөлгөөний оргил цаг, нислэгийн

урьдчилан тооцоолсон цагт үндэслэн тооцсон. Тус бүр 13 зогсоолтой 5 хос эгнээгээр халааслан нийт 6 халаасны зогсоолд 832 автомашин, такси зогсох боломжтой.

24 цагийн харуул хамгаалалт, камераар бүрэн тоноглогдсон 201 автомашины багтаамжтай 2 давхар дулаан зогсоолтой. Дулаан зогсоолын барилга нисэх буудлын барилгаас 400 метр зайд байрлаж байна.

## 1.4 НИСЭХ БУУДАЛД ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРИУЦСАН БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД

### 1.4.1 Шатахуун хангалтын алба

Шатахуун хангалтын албаны барилга байгууламж, тоног төхөөрөмжүүдийн мэдээлэл:

1) Шатахуун хадгалах босоо цилиндр 2000м<sup>3</sup>-ийн 4 ширхэг ган сав; 2) Насосны станц; 3) Трансформатор, дизель цахилгаан үүсгүүрийн байр; 4) Галын усан сан 25м<sup>3</sup> савтай; 5) Тунадас хадгалах хэвтээ 10м<sup>3</sup> -ын 2 ширхэг далд байрлалтай сав; 6) Түлш суллах хэвтээ цилиндр 50м<sup>3</sup>-ийн 1 ширхэг сав; 7) Агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах хэвтээ цилиндр 20м<sup>3</sup>- 1 савтай; 8) Харуулын байр; 9) Галын усан сан; 10) Хэвтээ сав парк; 11) Цэнэглэх талбай; 12) Шатахуун буулгах төхөөрөмж, ачих төхөөрөмж; 13) Ууршуулах талбай; 14) Цэвэрлэх байгууламж; 15) Галын гидрант; 16) Автомашины болон явган хүний зам талбай; 17) Сав парк өргөтгөлийн талбай;

**Шатахуун хадгалах сав:** Шатахууны агуулах нь 2 га талбайтай, ТС хадгалах Т-201, Т-202, Т-203, Т-204 маркийн 2000м<sup>3</sup>-ийн 4 ширхэг савтай. Түлш суллах хэвтээ цилиндр D-503 маркийн 50м<sup>3</sup>-ийн 1 ширхэг сав, агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах D-603 маркийн хэвтээ цилиндр 20м<sup>3</sup>-ийн багтаамжтай 1 савтайгаар 2017 онд ашиглалтад орсон



**Зураг 12. Шатахууны агуулахын байгууламж. Агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах 20м<sup>3</sup>-ийн хэвтээ цилиндр ган сав**

**Т-201, Т-202, Т-203, Т-204 тус бүр 2000м<sup>3</sup>-ын босоо цилиндр ган савыг 2016**

**Зураг 13. ТС-1 хадгалах 2000м<sup>3</sup>-ын босоо цилиндр ган сав**



онд листийн аргаар угсарч, савыг суллаж ёроолын бохирдлыг цэвэрлэж савны туршилт, сорилтыг хийсэн. Савыг усаар дүүргэж даралт өгч битүүмжлэл болон ачааллыг шалгасан бөгөөд савны тоног төхөөрөмжийн гагнуурын хэсгийг тусгай хөөсрүүлэгч уусмал ашиглан

шалгаж сорилт туршилтыг хийсэн. Савны тойргийн дагуу 6м тутамд хазайлт, суултыг тодорхойлсон ба шалгалтаар сайн дүнтэй гарч, ашиглах боломжтой гэсэн дүгнэлт өгсөн. 2000 м<sup>3</sup> босоо цилиндр ган савны үндсэн тоног төхөөрөмжүүдэд нягт, температур хэмжигч төхөөрөмж, цахилгаан автомат хаалт, амьсгалах хавхлага, хамгаалах хавхлага, шатахууны төвшин хэмжигч, температур хэмжигч, хэмжилтийн люк, дээж авах 3 хавхлага, хөөс, усаар бүтээгдэхүүний гадаргууг шүршин цацах шугам хоолой, орлого, зарлагын хоолой, автомат болон механик хаалтууд, цэвэрлэгээний люк, гэрлийн люк зэрэг орно. Орчин үеийн автомат хэмжилтийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон ба савны дүүргэлт, шатахууны температур, нягтыг автоматаар хэмжих хөвүүрт камертай. Савны төвшинг 3 төвшингээс хэмжих тоноглол, галын ус, хөөсний камер, дээж авах битүүмжлэлтэй тоног төхөөрөмжтэйгээрээ давуу талтай.

**Түлш суллах хэвтээ цилиндр D-503 маркийн 50м<sup>3</sup> багтаамжтай сав:** Уг савны гэмтэл, аваар ослын үед сав суллах хэвтээ цилиндр түлш суллах D-503 маркийн 50м<sup>3</sup>-ийн 1 сав байна. Түлш суллах хэвтээ сав нь аюулгүй үйл ажиллагааг хангасан хаалт, оч баригч, үл буцаах хавхлага, хэмжилтийн люк, амьсгалах клапан, автомат төвшин хэмжигч, орлого, зарлагын шугам хоолой, оч баригч, автомат хаалт зэрэг тоног төхөөрөмжүүдээс бүрдэнэ. Агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах D-603 маркийн хэвтээ цилиндр 20м<sup>3</sup>-ийн



**Зураг 14. Түлш суллах хэвтээ цилиндр T-503 маркийн 50м<sup>3</sup>-ийн сав**

багтаамжтай 1 сав байна. Дизель түлш хадгалах сав нь ил байрлалтай ба

бүтээгдэхүүний шүүрэлт гоожилтоос хамгаалж газар талбайг бетондсон. Гал гарсан тохиолдолд галын хөдөлгөөнт хэрэгсэлтэй, ус болон хөөсөөр унтраахаар тоног төхөөрөмж, шүүрэлт гоожилтыг шингээж авах эсгий, элс агуулсан тоног төхөөрөмжийг ойролцоо байрлуулсан.

**Насосны станц:** Түлшний агуулах нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулахын барилга, байгууламжийн гал тэсвэржилтийн зэргээр III зэрэглэлд хамаарна. III зэрэглэлийн агуулахын хувьд БНБД 21-03-04 насос станцын барилга дотор дизель цахилгаан үүсгүүрийг байрлуулахыг зөвшөөрдөг. Энэ тохиолдолд нэг төрлийн хэрэгцээнээс илүүгүй багтаамж бүхий түлшний савыг барилгын цул ханын гадна талд, эсхүл шатдаггүй материалаар хийсэн байгууламжид



**Зураг 15. Шатахууны агуулахын насосны станц**

суурилуулна. Түлшний агуулах нь 2017 онд ашиглалтад орсон гидрант насос P-301, P-302, P-303, P-304 маркийн 227м<sup>3</sup>/цаг хүчин чадалтай 4 ширхэг, сав хоорондын D-503 маркийн 50м<sup>3</sup>/цаг 1 ширхэг насостай. БНБД 21-03-04 агуулахын галын аюулгүйн байршлын стандартын 7.4 дүгээр заалтын дагуу тус агуулахын насосны станцын барилгын насосны тэсрэлтээс хамгаалагдсан цахилгаан хөдөлгүүр болон дотоод шаталтат хөдөлгүүрийн өрөө нь насосны өрөөнөөс 1 төрлийн галаас хамгаалах цул ханаар тусгаарлагдан хийгдсэн байна.

**Галын усан сан:** ТС түлш хадгалах 2000 метр кубын багтаамжтай савнууд нь сав хөргөх

**Зураг 16. Галын усан сан, Сав хөргөх, усан хөшиг үүсгэх тоног төхөөрөмжийг байрлуулсан байдал**



суурин төхөөрөмжөөр тоноглогдсон. Савны дээд бүсэд байрлах, тодорхой хэсгүүдэд хуваагдсан, ус шүрших цагираг, цагиргийг галын ус

дамжуулах хоолойтой холбогдсон босоо болон хэвтээ хуурай хоолойнууд, гар ажиллагаатай хаалтуудаас бүрддэг. Систем нь гал түймэр гарсан тохиолдолд савны байрлалаас хамааруулан савны гадаргууг бүтнээр, хагасыг болон дөрөвний нэгийг хөргөх боломжтой. Галын усан сан нь 500м<sup>3</sup>/цаг далд байрласан галын усан сантай, гүний усаар хангагддаг. БНбД21-03-04 агуулахын галын аюулгүйн норм дүрмийн 8.6 дугаар заалтын дагуу 1000-3000м<sup>3</sup>-ын багтаамжтай шатахуун хадгалах савнуудад хөөсний генератор суурилуулж галын техник хэрэгсэл холбох зориулалтын хэрэгсэл бүхий төгсгөлийг нь далангийн гадна гаргасан хоолойд холбосон.

**Шатахуун ачих буулгах байгууламж:** БНбД21-03-04 ын 5.7, 5.8 зэрэг заалтын дагуу ачиж буулгах хэсгийн талбай нь ус үл нэвтрэх хатуу гадаргуутай, 0.2м-ээс багагүй өндөр хашлагаар битүү хүрээлэгдсэн, шингэнийг бохирын суваг, цуглуулга урсгах зориулалтаар 2 хувиас багагүй налуутайгаар хийгдсэн. Ачих буулгах байгууламжийн тавцангийн шатнуудыг тавцангийн 2 төгсгөл, шулуун хэсэгт хоорондоо 100м-ээс илүүгүй зайд байрлуулна. Шатны өргөн нь нь 0.7м-ээс багагүй, 1:1-ээс илүүгүй өгсүүр зэрэг заалтыг шаардлага хангасан байна. Тус агуулах нь Z-106 маркийн 2300 л/мин, Z-101 маркийн 1900 л/мин, Z-102 маркийн 1900 л/мин, Z-103 маркийн 2300л/мин ачих, буулгах хүчин чадалтай 4ш төхөөрөмжөөс бүрдэнэ. Агаарын хөлгийг сумлах ажиллагаа нь




зорчигч үйлчилгээний барилгын агаарын хөлгийн 6 зогсоол дээр

**Зураг 17. Шатахуун ачих буулгах байгууламж**


байрлах арван дөрвөн ширхэг гидрантын хавхлагаас түлш түгээх зориулалтын диспенсэр авто машинаар хийгдэнэ. Нэг худаг нь нэг минутад 1,000 галлон буюу 3,780 литр хүртэл шахах техникийн хүчин чадалтай. Гурван агаарын хөлөгт нэгэн зэрэг сумалгаа хийх боломжтой



ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт дүн (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>						
1.	Дулааны станцын үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл	Бохирдуулагч хийн ялгаралтад хяналт тавьж шаардлагатай тохиолдолд бууруулах арга хэмжээ авах. Дулааны станцын яндангийн дагуу агаарын чанарын шинжилгээ хийлгэнэ (Агаарын чанарын шинжилгээний төлөвлөгөөг орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөнөөс харна уу).	Дулааны станцын яндангаас 400 м дотор	Тогтмол хэрэгжиж буй (халаалтын улиралд)	-	Дулааны станцын нүүрсийг “Цэцэнс Майнинг Энд Энержи” ХХК- “Худалдах, худалдан авах” гэрээгээр нийлүүлж байна. Нүүрсний стандартад тогтмол хяналт тавин ажиллаж байна. Зуухны үйл ажиллагаа хэвийн.
		Утааны яндангийн уутат шүүлтүүрийн хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангаж ажиллах, тогтоосон хугацаанд солих		Тогтмол хэрэгжиж буй (халаалтын улиралд)	14,000,000	Халаалтын улирал эхлэхээс өмнө дулааны станцын зуухны бэлэн байдал, утааны яндангийн уутат шүүлтүүрийн хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд 3 зуухны нийт 50 ширхэг уутат шүүлтүүрийг шинэчилж, хуучин шүүлтүүрүүдийг 2-3 удаа шалгаж цэвэрлэсэн
2.	Дулааны станцын цахилгаан тархалтаар бохирдох үнсний орчин	Дулааны станцын нүүрс хадгалах талбайг битүүмжлэх	Дулааны станцын 100 м дотор	Бүрэн хэрэгжсэн	141,284,417	 <p>Нүүрс хадгалалтын битүүмж алдагдсанаас үүсэх орчны бохирдлоос урьдчилан сэргийлж, 143м урт, 1,5м өндөр, 0,2м зузаан ханатай бетон хашааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, нүүрс хадгалах хашааг шинэчилсэн.</p>

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт дүн (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>						
3.	Дулааны станцад нийлүүлдэг нүүрсний чанар алдагдсанаас үүсэх агаарын бохирдол	Итгэмжлэгдсэн лабораториор нүүрсний шинжилгээ хийлгүүлэх, нүүрсний чанарын горимд хяналт тавих. Нүүрс дулааны станцын стандартад нийцэхгүй тохиолдолд нүүрсийг солих арга хэмжээ авах.	Нисэх буудлын орчинд	Бүрэн хэрэгжсэн	-	Нүүрсний шаталтаас шалтгаалж, агаарын бохирдол үүсэхээс сэргийлж, дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нийлүүлэгдэж байгаа нүүрсний чанарыг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж байна. (Нүүрсний шинжилгээний хариуг хавсаргав, "НУБИЭ" ХХК-ийн Хавсралт 1/1 дүгээр хуудас)
4.	Хөрс, ургамалан бүрхэвчийн элэгдэл, эвдрэл бохирдол	Төлөвлөлтийн дагуу цаашид барилга байгууламж баригдахгүй болон үйл ажиллагаанд өртөөгүй талбайг доройтуулахгүйгээр хамгаалах. Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдолт үүсэхээс урьдчилан сэргийлэх, тогтмол хяналт тавих. Нисэх буудлын орчинд төрийн болон бусад байгууллагууд шинээр барилга байгууламж баригдах тохиолдолд (НУБИЭ ХХК барилга барихгүй) хуулсан газрын шимт хөрсийг дахин ашиглах, барилгажилт дууссаны дараа техникийн нөхөн сэргээлт хийх, зүлэгжүүлэх ажилд хяналт, шаардлага тавих	Барилгажих талбай болон эвдрэл доройтолд өртсөн, бохирдол үүсэх эх үүсвэрүүд	Тогтмол хэрэгжиж буй	-	2023 онд дараах 2 байгууллагад техникийн нөхцөл олгосон. Үүнд:  -"Эрчим сүлжээ" ХХК. Цахилгаан авто машины 2 ширхэг цэнэглэгч Нисэх буудлын автозогсоолд баригдаж дууссан. Хөрсний бохирдол, эвдрэл гэмтэл үүсээгүй.  -"Мон Аэр Тур" ХХК. Газар ашиглалтын төлөвлөгөөний 25Б талбарт, 7107 мкв талбайд баригдаж буй "Шуудан илгээмж, карго үйлчилгээ"-ний 2 давхар барилга, баригдаж байгаа. Хог хаягдал, хөрсний эвдрэл гэмтэл болон бохирдолд хяналт тавин ажиллаж байна.


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт дүн (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>						
5.	Төслийн усны хэрэглээнээс газар доорх усны нөөцийн хомсдол үүсэх	Харьяалагдах сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх	Нисэх буудлын хүрээнд	Тогтмол хэрэгжиж буй	3,971,482	Туул голын сав газрын захиргааны 2023 оны 3-р сарын 14-ний өдрийн №40 дугаартай “Ус ашиглах дүгнэлт”, 2023 оны 3-р сарын 31-ны өдрийн А/16 тоот “Ус ашиглах зөвшөөрөл”-ийг тус тус үндэслэж, Туул голын сав газрын захиргаатай “Ус ашиглах гэрээ” байгуулан ажиллаж байна. (Ус ашиглуулах дүгнэлт, Ус ашиглах зөвшөөрөл, Ус ашиглах гэрээг хавсаргав, “НУБИЭ” ХХК-ийн Хавсралт 1/ 2-10)
		Усны тоолуур баталгаажуулах	Ус хангамжийн эх үүсвэр бүрт	Бүрэн хэрэгжсэн	270,000	Ундны усны эх үүсвэрийн WMAP-80 загварын 80мм голчтой 3 ширхэг тоолуурыг 2023 оны 8-р сарын 17-ны өдөр стандарт хэмжилзүйн газраар баталгаажуулсан. (Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээг хавсаргав, “НУБИЭ” ХХК-ийн Хавсралт 1/ 11-12)
6.	Төслийн усны хэрэглээнээс газар доорх усны нөөцийн хомсдол үүсэх	Усны чанар, нөөцийн мониторинг: -Горимын үзүүлэлт хэмжих багажийн судалгаа -Техникийн шаардлагыг тодорхойлох, судалгаа хийх	Ус хангамжийн эх үүсвэр бүрт	Бүрэн хэрэгжсэн	-	Газар доорх усны түвшин хэмжих багажийн судалгаа хийж, үнийн санал авсан. Техникийн шаардлагыг тодорхойлж, зардлыг 2024 оны төсөвт батлуулсан.
7.	Ус бохирдож улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Усны эх үүсвэрийг хамгаалсан хашаа, тэмдэгжүүлэлтийг эвдэрсэн тохиолдолд засаж сайжруулах, хяналт тавих	Ус хангамжийн эх үүсвэр бүрт	Бүрэн хэрэгжсэн	460,000	Усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэхийг хориглосон тэмдэглэгээг эх үүсвэрийн 3 цэгт шинээр байршуулсан.



№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт дүн (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>						
						
8.	Хур бороо, үерийн усаар төслийн талбай дахь хог хаягдал, шатах тослох материалын үлдэгдэл угаагдан хөрсөнд нэвчиж газрын доорх усны чанар, бүтцэд өөрчлөлт оруулж бохирдуулах	Шатах тослох материал алдагдаж болзошгүй эх үүсвэрүүдэд асгарч алдагдсан тохиолдолд шаардагдах хэрэгсэл, материалыг бэлэн байлгах. Машин техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, хог хаягдлын хадгалалтад тогтмол хяналт тавих.	Авто зогсоол, засварын газар хогийн цэгийн орчим	Бүрэн хэрэгжсэн	-	<p>Ундны эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд 24 цагийн ээлжийн ажилтан өдөр бүр үзлэг шалгалт хийдэг бөгөөд 2023 онд зөрчил илрээгүй.</p> <p>Усны эх үүсвэрийн (гүний худгийн) эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн дэглэмийн ойр орчимд хог хаягдал, шатах тослох материал үүсэх, асгарч алдагдсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээ авах, хамгаалалтын хашаа, тэмдэгжүүлэлтийн бүрэн бүтэн байдлыг ус хангамжийн ээлжийн ажилчид өдөрт 1 удаа үзлэг шалгалт хийж, 24 цагийн турш камерын хяналт тавьж байна.</p> <p>Хяналтаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гэмтэл, доголдол илрээгүй,</li> <li>- Гүний усны чанарт нөлөөлөлх бохирдуулагч эх үүсвэргүй,</li> <li>- Хүчдэл хэвийн,</li> <li>- Халаагч тений ажиллагаа хэвийн,</li> <li>- Хашаа, хамгаалалт бүрэн бүтэн</li> </ul> <p>(Ээлжийн ажилтаны хяналтын хуудсыг хавсаргав, “НУБИЭ” ХХК-ийн Хавсралт 1/ 13-15)</p>

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт дүн (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>						
9.	Бохир ус асгарч хүрээлэн буй орчныг бохирдуулах, хөрсөнд нэвчиж газрын доорх усны чанар, найрлагад өөрчлөлт оруулж бохирдуулах	Цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж, шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж, аюулгүй ажиллагааг хангах. Бохир усны шугам хоолой, худгийн үзлэг шалгалтыг өдөр тутам хийж гүйцэтгэх, шугам хоолойн дуран оношилгоо, угаалга лайдлага цэвэрлэгээ хийх	Цэвэрлэх байгууламж, бохирын худгууд, шугам Хоолой	Бүрэн хэрэгжсэн	-	<p>НУБИЭ ХХК-ийн эзэмшлийн бохир усны шугам хоолойд өдөр тутмын үзлэг, үйлчилгээг хийж байна. 2023 оны 5 дугаар сард 1,9 км шугам, 61 худгийн дуран оношилгоо хийсэн. 2023 оны 10 дугаар сард бохир усны 1,9 км шугам, 222 мкв бохир ус хүлээн авах санг угааж, лайдаж цэвэрлэсэн.</p> 
10.	Хүрээлэн буй орчинд агаар болон хөрсний бохирдол үүсгэх	Цэвэрлэх байгууламжаас гарах лагийг бордоо болгох туршилт, судалгааны ажил хийх /талбай болон лабораторийн аргаар/ МУИС-ийн Хүрээлэн буй орчны инженерчлэл, цэвэр технологийн лабораторитой байгуулсан санамж бичгийн хүрээнд	Нисэх буудлын цэвэрлэх байгууламж	Бүрэн хэрэгжсэн	5,000,000	<p>2023 оны 2-4 дүгээр сард Цэвэрлэх байгууламжийн лагаас бордоо гарган авах туршилтын ажил хийгдсэн. Уг бордоогоор Цэвэрлэх байгууламжийн орчимд зүлэг тарьж туршсан.</p> 


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт дүн (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>						
						
11.	Хүрээлэн буй орчны бохирдол, хүн мал амьтанд сөрөг нөлөө үзүүлэх	Хаягдал усны зөвшөөрөл дүгнэлт гаргуулах. Цэвэрлэгдсэн усыг эргүүлэн ашиглах	Нисэх буудлын орчимд, Бөхөгийн гол, Зуунмод голд нийлэх цэг	Бүрэн хэрэгжсэн	-	<p>Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хуулийн дагуу МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраар Хаягдал усны дүгнэлт гаргуулсан. Уг дүгнэлтэд үндэслэж Туул голын сав газрын захиргааны 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр 22/03 тоот “Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл”-ийг сунгуулсан.</p> <p>2023 онд нисэх буудлын хэмжээнд цэвэрлэх байгууламжаас гарсан 2245метркуб цэвэрлэгдсэн бохир усыг дараах байдлаар дахин ашигласан. Үүнд: 1) аэродромын зам талбайн цэвэрлэгээ, 2) онгоцны бохир тээвэрлэгч машины ёмкостын цэвэрлэгээ, 3) цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, 4) цэвэрлэх байгууламжийн ариун цэврийн өрөөний суултуурын усанд.</p> <p>(Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөлийг хавсаргав, “НУБИЭ” ХХК-ийн Хавсралт 1/ 16-17)</p>


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт дүн (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>						
12.	Хүрээлэн буй орчны бохирдол, нуур үүсч усны шувуу цуглах, улмаар нислэг үйлдвэрлэлд аюул үүсэх эрсдэл	Цэвэрлэгдсэн усны гаргалгааны сувгийн уклон тохируулж, салаалсан сувгийг нэгтгэн нэг сувгаар урсгах, хайрга дэвсэх	Цэвэрлэгдсэн усны гаргалгааны хэсгээс Боорчийн даланруу нийлүүлэх хэсэгт	Төлөвлөж буй	-	Боорчийн далан үерийн усанд идэгдсэний улмаас тус ажил хойшлогдсон. Цэвэрлэгдсэн усны гаргалгааны хэсгээс Боорчи даланруу нийлүүлэхгүйгээр шууд голруу нийлүүлэхээр шийдвэрлэрлэж, холбогдох зардлыг 2024 оны төсөвт батлуулсан.
<b>НУБИЭ ХХК</b> <b>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний Биелэлтийн нийт дүн (төг)</b>					<b>164,985,899₮</b>	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжүүлж байгаа, төлөвлөж байгаа	Нийт дүн (төг)	Биелэлт
<b>2. ИНЕГ, ИНУТ-ийн “ЧХОУНБ” дахь ШАТАХУУН ХАНГАЛТЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>						
1.	Шатахууны агуулахаас үүсэх агаарын бохирдол	Техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны хяналт	Шатахууны агуулахын орчим	Сар бүр	-	<p>Шатахууны агуулахын сав түүний тоноглолын битүүмжлэл өндөр түвшинд хангагдсан учир шатахууны ууршилтгүй, сар бүр JIG-2 стандартын дагуу үзлэг шалгалтыг гүйцэтгэж, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.</p> <p>Шатахууны агуулахын сав түүний тоноглолын битүүмжлэл өндөр түвшинд хангагдсан учир шатахууны ууршилтгүй, улирал бүр JIG-2 стандартын дагуу үзлэг шалгалтыг гүйцэтгэж, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.</p> <p>(Тоног төхөөрөмжийн сар тутмын үзлэгийн хуудсыг хавсаргав. ИНЕГ, ИНУТ-ийн “ЧХОУНБ дахь ШХА” Хавсралтууд 1-4 дугаар хуудас)</p>
2.	Цэнэглэх үеийн агаарын бохирдол	Зураг авалтаар гарсан дүнд үндэслэн шатахууны агуулахыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглох	Шатахууны агуулахын орчим	Жил бүр	-	 <p>Чингис хаан Олон улсын нисэх буудал дахь Шатахуун хангалтын албаны Агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх тоног төхөөрөмж нь битүүмжлэл сайтай</p>


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжүүлж байгаа, төлөвлөж байгаа	Нийт дүн (төг)	Биелэлт
<b>2. ИНЕГ, ИНУТ-ийн “ЧХОУНБ” дахь ШАТАХУУН ХАНГАЛТЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>						
						<p>сүүлийн үеийн технологи ашигладаг учир шатахууны ууршилтгүй сумлагааг гүйцэтгэж, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.</p>   <p>Агаарын хөлөг шатахуунаар цэнэглэх сумлагч автомашинд шатахуун ачих тоног төхөөрөмж нь доогуур ачилтийн хоолойтой, торхны дээд люкний битүүмжлэл сайн учир шатахууны ууршилтгүй ачилтыг гүйцэтгэж, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.</p>

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжүүлж байгаа, төлөвлөж байгаа	Нийт дүн (төг)	Биелэлт
<b>2. ИНЕГ, ИНҮТ-ийн “ЧХОУНБ” дахь ШАТАХУУН ХАНГАЛТЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>						
3.	Түлшний шаталтаас хийгээр агаар бохирдох үүсэх	Тээврийн хэрэгслүүдийн ашиглалтын үеийн засвар үйлчилгээг тогтмол хийх, шатах тослох материалын чанарын үзлэгийг хийж, холбогдох арга хэмжээг авах	Шатахууны агуулахын орчим	Тогтмол	-	<p>Тээврийн хэрэгслүүдийн ашиглалтын үеийн засвар үйлчилгээг тухай бүр гүйцэтгэж, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.</p> <p>(Жишээ болгон шатахуун хангалтын албаны 42-61УАВ диспенсер автомашины үзлэг, үйлчилгээний тэмдэглэлийн дэвтэр, 1184УН сумлагч автомашины техник ашиглалтын паспортыг хавсаргав. ИНЕГ, ИНҮТ-ийн “ЧХОУНБ дахь ШХА Хавсралтууд 5-8 дугаар хуудас)</p>


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжүүлж байгаа, төлөвлөж байгаа	Нийт дүн (төг)	Биелэлт
<b>2. ИНЕГ, ИНУТ-ийн “ЧХОУНБ” дахь ШАТАХУУН ХАНГАЛТЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>						
4.	Газрын тосны бүтээгдэхүүний агуулахаар хөрс бохирдох	Шатахууны агуулахад хийсэн зураг авалтын үр дүн, зөвлөмжийг дагаж ажиллах	Шатахууны агуулахын орчим	Тогтмол	-	 <p>Газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдсон ус цуглуулах системийн байгууламжтай учир шатахуун асгарсан тохиолдолд хөрс, гүний усанд нэвчихгүйгээр зориулалтын худгууд, хоолойгоор дамжин тос ялгах сеператорт газрын тосны бүтээгдэхүүн ялгаран үлдэж, ууршуулах талбай руу шүүгдсэн ус орж ууршдаг. Шатахуун асгарсан тохиолдол гараагүй, технологийн үйл ажиллагааг чанд мөрдөн ажиллаж байна.</p>
5.	Газрын тосны бүтээгдэхүүний асгаралт	<p>5.1. Осол эрсдэлийн дүрмийн дагуух бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</p> <p>5.2. Нефть бүтээгдэхүүний асгаралтын дараа хөрсөөр дамжин гүний усны бохирдол үүссэн эсэхийг тодорхойлон холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	Шатахууны агуулахын орчим	2023 онд	-	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжүүлж байгаа, төлөвлөж байгаа	Нийт дүн (төг)	Биелэлт
<b>2. ИНЕГ, ИНУТ-ийн “ЧХОУНБ” дахь ШАТАХУУН ХАНГАЛТЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>						
						 <p>Газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдсон ус цуглуулах системийн байгууламжтай учир шатахуун асгарсан тохиолдолд хөрс, гүний усанд нэвчихгүйгээр зориулалтын худгууд, хоолойгоор дамжин тос ялгах сеператорт газрын тосны бүтээгдэхүүн ялгаран үлдэж, ууршуулах талбай руу шүүгдсэн ус орж ууршдаг. Шатахуун асгарсан тохиолдол гараагүй, технологийн үйл ажиллагааг чанд мөрдөн ажиллаж байна.</p>
6.	Газрын тосны бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж ургамалжилтад нөлөө үзүүлэх, бохирдуулах, бохирдсон ургамлыг идсэн мал амьтан хордох	Хөрс болон усан орчинд газрын тосны бүтээгдэхүүн алдагдсан тохиолдолд тухайн бодисыг цаашид тархахаас нь сэргийлж, шингээн авах шаардлагатай. Тайланд өгсөн зөмлөмжийн дагуу ажиллах, шаардлагатай материалыг бэлэн байлгах	Шатахууны агуулахын ойролцоо, ялангуяа агуулахаас шатахуун цэнэглэх, буулгах талбай орчимд	Шатах, тослох материал алдагдах бүрт	-	Газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдсон ус цуглуулах системийн байгууламжтай учир шатахуун асгарсан тохиолдолд хөрс, гүний усанд нэвчихгүйгээр зориулалтын худгууд, хоолойгоор дамжин тос ялгах сеператорт газрын тосны бүтээгдэхүүн ялгаран үлдэж, ууршуулах талбай руу шүүгдсэн ус орж ууршдаг. Шатахуун асгарсан тохиолдол гараагүй, технологийн үйл ажиллагааг чанд мөрдөн ажиллаж байна.
<b>Шатахууны агуулахын үйл ажиллагааны сөрөг нөлөөг бууруулах үйл ажиллагааны нийт зардал (төг)</b>					-	-

ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн Зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт зардал (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>						
1.	Нисэх буудлын орчныг зүлэгжүүлэх	Зүлэгжүүлэх талбайн хөрс бэлтгэх, олон наст зүлэг тарих	Нисэх буудлын автомашины зогсоолын урд хэсэг	Бүрэн хэрэгжсэн	298,800,000	<p>“Бат Өндөр Хайрхан” ХХК-тай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан, нисэх буудлын автозогсоолын орчмын нийт 15,284 мкв талбайн өнгөн хөрсийг бүрэн шинэчилж, зүлэгжүүлсэн.</p> 
2.	Одоо байгаа тарьсан мод, зүлэгний арчилгаа хамгаалалт	Нисэх буудал орчим тарьсан мод, зүлэгний арчилгаа, усалгаа, тайралт, хамгаалалтыг хийх, хяналт тавих	Нисэх буудлын нийт ногоон байгууламжийн хүрээнд	Бүрэн хэрэгжсэн	-	<p>Тарьсан модыг услах, бордох, тайралт хийх ажлыг “Аполло Бьюлдинг Сервис Монголия” ХХК-тай хамтран гүйцэтгэв. Нисэх буудлын автомашины зогсоол орчимд тарьсан зүлэгний усалгаа, тайралтыг “Бат Өндөр Хайрхан” ХХК хариуцан гүйцэтгэв.</p>

3.	Мод тарих	Компанийн ажилтнуудыг хамруулсан мод тарих ажлыг зохион байгуулах	Төв аймгийн Сэргэлэн суманд	Бүрэн хэрэгжсэн	3,000,000	<p>“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын “Алтантүлхүүр” цэцэрлэгийн хашаанд 50 ширхэг улиас мод, Нэгдсэн эмнэлэгийн хашаанд 130 ширхэг улиас мод, 2 ширхэг шилмүүст мод тарьсан. Усалгаа, арчилгааг тухайн байгууллагад хариуцуулсан.</p> 
4.	Автомашины ил зогсоолд цахилгаан автомашины цэнэглэгч станц суурилуулах, цахилгаан автомашины тусгай зогсоолтой болох	Гүйцэтгэгч компанид техникийн нөхцөл олгох. Ажлын зураг батлах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих	Нисэх буудлын автомашины зогсоолд	Бүрэн хэрэгжсэн	-	<p>“Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилго”-ыг дэмжих хүрээнд “Эрчим Сүлжээ” ХХК-тай хамтран нисэх буудлын автомашины зогсоолд 60кВт-ын хүчин чадалтай 2 ширхэг цахилгаан автомашин түргэн цэнэглэгч станц байршуулж, ашиглалтад оруулсан.</p> 
5.	“Сүү өргөх цэг” байгуулах судалгаа хийх	Сүү өргөх талбай сонгох, зураг төсөл боловсруулах, батлуулах	Нисэх буудлын автомашины зогсоол орчим	Бүрэн хэрэгжсэн	-	<p>“Сүү өргөх цэг”-ийн байршлыг тодорхойлж, нисэх буудлын автомашины зогсоолын зүүн хойд талд нийт 840 мкв талбайн зураг төсөл гаргасан. “Фалкон Дриллинг” ХХК-тай хамтран 950мкв талбайг зорчигч, үйлчлүүлэгчдэд зориулан тохижуулсан.</p>


					
<p><b>НУБИЭ ХХК</b> Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтийн нийт дүн (төг)</p>					<p><b>301,800,000₮</b></p>

**ДӨРӨВ. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**



№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт зардал (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>						
1.	Нисэх буудлын үйл ажиллагаагаар түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дүрсгалт зүйл илэрвэл барилгын ажлаа зогсоож энэ тухай, сум, аймгийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх	Нисэх буудлын ойр очимд	-	-	Одоогийн байдлаар нисэх буудлын үйл ажиллагаанаас хамаарч түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө тогтоогдоогүй.
<b>НУБИЭ ХХК</b> <b>Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн нийт дүн (төг)</b>				-		



**ТАВ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Осол эрсдэлээс хамгаалах ажлын ихэнх нь нисэх буудлын үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой. Шувуу, зэрлэг ан амьтдын ослоос урьдчилан сэргийлэх ажилд холбогдох зардлын зарим хэсэг нь хариуцсан газрын үйл ажиллагааны зардлын хүрээнд, зарим хэсэг нь БОМТ-ний төсвийн хүрээнд шийдвэрлэгдэнэ.


№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт зардал (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>						
1.	Цаг уурын нөхцлөөс үүсэх гэнэтийн осол	Урьдчилан сэргийлэх Мэдээ болон дохиолол Холбооны найдвартай байдлуудыг байнга хангах	НУБИЭ ХХК-ийн бүх ажилтнуудад хамаарна. Бүх түвшний ажилтнуудын ажил үүргийн хуваариар тодорхойлогдсон байна	Тогтмол хэрэгжиж буй	-	Нисэхийн цаг уурын төвөөс өдөр тутмын цаг уурын урьдчилсан мэдээллийг тогтмол авдаг. Нислэг үйлдвэрлэл хариуцсан нэгжүүд тус мэдээлэлд үндэслэн ажлын зохион байгуулалтыг хийж байна. Осол, галын дохиоллын үзлэг шалгалтыг тогтмолжуулсан. Шаардлагатай засвар үйлчилгээг тухай бүрт нь хийж байна.
2.	Нисэх буудлын “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ”-г мэргэжлийн байгууллагаар шинэчлэн хийлгэх, дүгнэлтийг сунгуулах	Нисэх буудал болон түүний барилга байгууламжид байгалийн гамшиг болон хүний үйл ажиллагаатай холбоотой аливаа аюул, өртөнгө, эмзэг, байдлыг тодорхойлж, гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийх, мөн гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөмж боловсруулах	НУБИЭ ХХК-ийн бүх ажилтнуудад хамаарна. Бүх төвшний ажилтнуудын ажил үүргийн хуваариар тодорхойлогдсон байна	Бүрэн хэрэгжсэн	25,000,000	 <p>2023 оны 06 сарын 23-ны өдөр “Монголын галын инженер техникчдийн холбоо”-той 184/23 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж, Гал түймэр, газар хөдлөлт, үер, хүн малын гоц халдварт өвчин болон цаг агаарын онц ноцтой үзэгдлүүдийн эрсдэлийн үнэлгээ буюу 2023-2025 оны “НУБИЭ” ХХК-ийн “Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ”-г хийсэн. Тус үнэлгээнд үндэслэн</p>


						байгууллагын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г боловсруулж байна.
3.	Хөдөлмөрийн сахилга бат алдсанаас үүсэх осол	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дотоод хяналт, байгууллагын дотоод дүрэм журам мөрдөж, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх	ИНЕГ болон НУБИЭ ХХК-ийн бүх ажилтнуудад хамаарна	Тогтмол хэрэгжиж буй	-	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аюул, эрсдэл, болзошгүй үйлдвэрлэлийн осол, осолд дөхсөн тохиолдлоос урьдчилан сэргийлэхээр ХАБЭА-н удирдлагын тогтолцооны заавар, ХАБЭА-н гурван шатны хяналтын журмыг хэрэгжүүлэх, хэвшүүлэх, хяналт тавих ажил тогтмол хийгдэж байна. ХАБЭА-н гурван шатны хяналтын 1-р шатыг ажилтан, шууд удирдлагын хамтаар 1584 удаа хийж 36 үл нийцлийг илрүүлж, 100% арилгасан. ХАБЭА-н гурван шатны хяналтын 2-р шатны хяналтыг хэлтсийн дарга, менежер, ХАБЭА хариуцсан ажилтны хамтаар 111 удаа хийж 15 үл нийцлийг илрүүлж, 100% арилгасан. ХАБЭА-н гурван шатны хяналтын 3-р шатны үзлэгийг 38 удаа хийж 6 үл нийцлийг илрүүлж, 100% арилгасан..</p> <p>ХАБЭА-н удирдлагын тогтолцооны заавар түүнтэй холбогдох журмуудын хэрэгжилтийг хэрхэн хангах, болзошгүй аюул, эрсдэл, ослоос урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг НУБИЭ ХХК-ийн 6 газрын 522 ажилтанд 20 удаагийн давтамжтайгаар нийт 1200 минут зохион байгуулсан.</p> <p>ХАБЭА-н хууль эрхзүйн ойлголт, болзошгүй аюул, эрсдэл, үйлдвэрлэлийн осол, осолд дөхсөн тохиолдлоос урьдчилсан сэргийлэх, ХАБЭА-н хуулиар олгогдсон эрх, үүрэг, хариуцлагын талаарх сургалтыг хамтын ажиллагаатай Гаалийн ерөнхий газар, “Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК, “Апполо Бьюлдинг Сервис Монголиа” ХХК-ийн 200 гаруй ажилтанд 3 удаагийн давтамжтайгаар 180 минут зохион байгуулсан.</p>


<p>4.</p>	<p>ЗТСайдын 2016 оны 48-р тушаалаар баталсан “Агаарын хөлөг шувуу мал, амьтадтай мөргөлдөх аюулаас Сэргийлэх хөтөлбөр”-ийг үндэслэн Төв Аймгийн тамгийн газартай хамтран Ажиллах “Агаарын хөлөг Шувуу мал Амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөл”-ийн хүрээнд болзошгүй аюул,эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлэх</p>	<p>-Нисэх буудал орчмын өндөрлөг цэгүүд болон ойртолтын бүсэд үүссэн шувууны үүрийг буулгах. Шинээр үүр засах нөхцөлийг бууруулах. -Нисэх буудал орчимд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд шувуу, мал амьтны бөөгнөрлөөс үүдэлтэй аюул эрсдэлийн тухай тогтмол анхааруулга, мэдээлэл өгөх. Нисэх буудлын орчинд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс гарч буй хогийг ангилалтайгаар, тогтмол хуваарийн дагуу ачих ажилд хяналт, шаардлага тавьж ажиллах. -Нисэх буудал орчмын шувуу, хөхтөн амьтдын өмнөх судалгаатай харьцуулсан судалгаа, эрсдэлийн үнэлгээ хийх, аюулыг бууруулах арга хэмжээг нарийвчлан тодорхойлох. -Зэрлэг амьтан хамгаалах хөтөлбөр боловсруулах.</p>	<p>НУБИЭ ХХК-ийн Аэродромын хэлтэс, Төв аймгийн ЗДТГ, Сэргэлэн сумын ЗДТГ, Алтанбулаг сумын ЗДТГ, Зуунмод сумын ЗДТГ</p>	<p>Тогтмол хэрэгжиж буй</p>	<p>-</p>	<p>Сар тутам тогтмол үзлэг шалгалт хийж өндөрлөг цэгүүдэд шувуу үүрлэсэн байдлыг бүртгэдэг бөгөөд 2023 онд агаарын хөлгийн хоолойн доороос улаан хошуут жунгаа шувууны 7 үүрийг буулгасан.</p>  <p>Нисэх буудал орчмын Аж ахуйн нэгж, хуулийн этгээд, хувь хүн, айл өрхүүдэд шувууны аюулын талаар мэдээлэл хүргэж, Сэргэлэн сумын Засаг даргын А/244 тоот захирамж /нисэх буудлын ойр орчимд малтай айл буухыг хориглосон/-ийг 8 айлд танилцуулж, шаардлага хүргүүлсэн.</p> <p>Шувуу, хөхтөн амьтны харьцуулсан судалгааны дүнгээр нисэх буудлын орчимд 129 зүйлийн шувууд бүртгэгдсэн. Судалгааны мэдээлэлд үндэслэн үзлэг, хяналтыг эрчимжүүлж, шувууны аюулаас сэргийлэх зорилгоор босоо тор, мануухай, үрлэн сумтай буу зэрэг шинэ арга техникийг нэвтрүүлсэн. Нисэх буудал орчмын шувуудыг таних гарын авлага боловсруулсан.</p> 
-----------	--	--	--	-----------------------------	----------	---

						 <p>Байгальд ээлтэй аргаар нисэх буудал орчмын шувуудыг хянах, мониторинг хийх зорилгоор махчин шувуу (шонхор) ашиглах аргыг туршиж байна.</p>  <p>AGHAARIN KHELUG SHUVU, MAL, AMYANTAI MORGOLDKH AIOULAS SARGIYLKH YIL AJILLAGAAND SURGASAN MAKHIN SHUVUUSHIGGLAХ ARGYГ TURSHIX TУХАЙ</p> <p>TESTING THE METHODS OF USING TRAINED BIRD OF PREY IN OPERATIONS TO PREVENT AIRCRAFT COLLISIONS WITH BIRDS, LIVESTOCK AND ANIMALS</p> <p>INTRODUCTION</p>
--	--	--	--	--	--	---

5.	Аэродромын аюулгүй ажиллагааг хангах	Олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичгийг үндэслэн тодорхойлсон аюулгүй ажиллагааны бодлого, зорилтуудын хүрээнд Аэродромын аюулгүй ажиллагааг иргэний нисэхийн салбарын байгууллага, нэгжүүдийн хамтын ажиллагаанд тулгуурлан аюулыг илрүүлэх, түүний болзошгүй эрсдэлийг удирдах	Нисэх буудлын удирдлага болон аюулгүй ажиллагааны менежерийн хүрээнд	Тогтмол хэрэгжиж буй	-	Олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичгийг үндэслэн боловсруулсан “Нисэх буудлын ерөнхий заавар”-ын 4.1.4 “Эрсдэлийн удирдлага”-ыг үндэслэн Аюулгүй ажиллагааны хэлтсээс аюулыг тодорхойлж, эрсдэлийн үнэлгээ хийж, болзошгүй эрсдэлийг удирдаж ажилласан. Үүнд: - Зөвшөөрөлгүй нисгэгчгүй агаарын хөлөг /дрон/-ийн аюулын болзошгүй эрсдэлийг үнэлж, “Эрсдэлийг удирдах төлөвлөгөө” боловсруулж, хэрэгжүүлж байна. - Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд гарсан үл нийцлийг бүртгэлжүүлж, аюул, эрсдэлтэй нөхцөл байдлыг тодорхойлсон. - 7 хоногт 1 удаа “Үл нийцлийн залруулгын хэлэлцүүлэг” хурлыг зохион байгуулдаг. - Нийт 74 үл нийцэлд залруулга хийсэн.
6.	Гал түймрийн болзошгүй аюул	Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг инженер техникийн болон галын мэргэжлийн алба хаагчдаас бүрдсэн баг томилон Нисэх буудлын барилга байгууламжуудад зохион байгуулах.	Нисэх буудалд үйл ажиллагаа явуулж буй бүх газрууд, тэдний ажилтан албан хаагчид, Төв аймгийн онцгой байдлын газар	Тогтмол хэрэгжиж буй	-	Гал түймрийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нисэх буудал дахь барилга байгууламжуудын гал түймрээс хамгаалах техник, тоног төхөөрөмжүүд, гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, галын самбар, ослын үед дүрвэн гарах гарц, схем зураг зэргийн хангалт, ашиглалт, тоног төхөөрөмжийн хэвийн байдалд 2023 оны 06-р сарын 05-08-ны өдрүүдэд галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн. Үзлэгийн үеэр залруулах боломжтой ажлуудыг тухай бүрт нь шийдвэрлэсэн. Ажлын тайланг 6 дугаар сарын 15-ны өдрийн “Үл нийцлийн залруулгын хэлэлцүүлэг”-т танилцуулж, хэлэлцүүлсэн. Тогтмол үзлэг хийж, зөрчил илэрсэн тухай бүрт зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан. 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр гал болон цахилгааны аюулгүй байдалд төлөвлөгөөт бус үзлэг хийж, илэрсэн зөрчлийг арилгах чиглэл, зөвлөмж өгсөн.

		MNS 5566:2020 стандартын дагуу байрлуулсан гал унтраах анхан шатны багаж хэрэгсэлд нөхөн хангалт, засвар үйлчилгээ хийх.	Нисэх буудалд үйл ажиллагаа явуулж буй бүх газрууд, тэдний ажилтан албан хаагчид, Төв аймгийн онцгой байдлын газар	Тогтмол хэрэгжиж буй	10,062,300	<p>Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэг шалгалт зохион байгуулж, цэнэггүй, ашиглалтын шаардлага хангахгүй гал унтраагууруудыг татан авч цэнэглүүлж, байршуулсан. Нэмэлтээр 50 ширхэг 8кг-ын шинэ гал унтраагуур, 200 ширхэг гал унтраагуурын фосфортой тэмдэглэгээг худалдан авч, шаардлагатай байршлуудад нэгжийн галын сайн дурын бүлгэмтэй хамтран байршуулсан. 2013 оноос өмнө үйлдвэрлэгдсэн 22 ширхэг бортгыг "Гал импекс" ХХК-аар актлуулсан. Компанийн хэмжээнд 842 гал унтраагуур, 40 галын сарааг байршуулж, бэлэн байдлыг ханган ажилласан..</p> 
		- Аэродромын галын зэрэглэлийн хангалт - Гал унтраах сургалт, үзүүлэх сургууль, дадлагажих үйл ажиллагаа	Нисэх буудалд үйл ажиллагаа явуулж буй бүх газрууд, тэдний ажилтан албан хаагчид, Төв аймгийн онцгой байдлын газар		-	Газрын үйлчилгээний газар, Аэродром, Дулааны станцын гал унтраах шуурхай төлөвлөгөөг батлуулан, дасгал сургуулилалтыг Аврах гал унтраах хэлтсийн ээлжийн бие бүрэлдэхүүн, Газрын үйлчилгээний газрын галын сайн дурын бүлгэмтэй хамтран хийсэн.

						
<b>НУБИЭ ХХК</b>						
<b>Осол, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн нийт дүн (төг)</b>						<b>35,062,300₮</b>

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж байгаа, төлөвлөж байгаа	Нийт зардал (төг)	Биелэлт
<b>2. ИНЕГ, ИНУТ-ийн Шатахуун хангалтын алба</b>						
1.	Шатахууны агуулахын ашиглалтын үед үүсч болох эрсдэл	Шатахуун ачих, буулгах талбайд асгарсан тохиолдолд зориулалтын сувгаар ууршуулах талбайд орно	Шатахууны байгууламж	Тухайн тохиолдолд	-	 <p>Газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдсон ус цуглуулах системийн байгууламжтай учир шатахуун асгарсан тохиолдолд хөрс, гүний усанд нэвчихгүйгээр зориулалтын худгууд, хоолойгоор дамжин тос ялгах сеператорт газрын тосны бүтээгдэхүүн ялгаран үлдэж, ууршуулах талбай руу шүүгдсэн ус орж ууршдаг. Шатахуун асгарсан тохиолдол гараагүй, технологийн үйл ажиллагааг чанд мөрдөн ажиллаж байна.</p>

2.	Хөдөлмөрийн сахилга бат алдсанаас үүсэх осол	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар, зааварчилгааг ажлын байрны онцлогт тохируулан, тогтмол өгч, тус тусын зааварчилгааны дэвтэр хөтөлж, баримтжуулдаг.</p> <p>Байгууллагын дотоод аудит шалгалтыг гүйцэтгэж, илэрсэн үл тохирол, зөвлөмжүүдийг залруулах арга хэмжээг авч ажилладаг.</p> <p>Албаны “Үйл ажиллагааны заавар”-т хөдөлмөрийн сахилга бат алдсанаас үүсэх осол болон ослоос хэрхэн урьдчилан сэргийлж ажиллах тухай нэмэлт, өөрчлөлтийг оруулсан.</p>	Шатахууны байгууламж	1-12 сард	-	Хөдөлмөрийн сахилга бат алдсанаас үүссэн осол бүртгэгдээгүй.
3.	Гал түймрийн болзошгүй аюул	<p>Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх</p> <p>Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн худалдан авалт, хангалт</p> <p>Гал унтраах сургалт, үзүүлэх сургууль, дадлагажих үйл ажиллагаа</p>	Шатахууны байгууламж	Жилд 1 удаа	-	<p>2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан “Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө”-нд 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр тодотгол хийн, Төв аймгийн ОБГ-аар хянуулж, албаны даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.</p> <p>2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан “ЧХОУНБ дахь ШХА-ны гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-нд 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр “Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө” Бүлэг 4-ыг нэмэлтээр оруулж, тодотгол хийн, Төв аймгийн ОБГ-аар хянуулж, албаны даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.</p> <p>Галын дохиоллын систем, гал унтраах автомат төхөөрөмж, гал унтраагууруудын 2023 оны 1-12 дугаар саруудын үзлэг шалгалтыг гүйцэтгэж, “Галын дохиоллын систем, автомат тоног төхөөрөмж, гал унтраагууруудын сар тутмын үзлэг шалгалтын хуудас”-нд бүртгэж, баримтжуулсан. (“Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”, “Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг” хавсаргав, “ИНЕГ, ИНҮТ-ийн ЧХОУНБ</p>

дахь Шатахуун хангалтын алба” Хавсралтууд 9-10 дугаар хуудас)



2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн "НУБИЭ" ХХК-ийн барилга байгууламжуудад галын аюулаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт бус үзлэг хийх ажлын удирдамжийн дагуу 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Чингис




хаан олон улсын нисэх буудал дахь Шатахуун хангалтын албаны байгууламжид гал түймрээс хамгаалах техник тоног төхөөрөмжийн хэвийн байдал, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн ашиглалт, цахилгааны болон галын аюулын эрсдэлийг илрүүлж гал түймрийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлж, аюулгүй байдлыг хангаж ажиллах чиглэлтэйгээр үзлэгийг хийж гүйцэтгүүлсэн.






						Галын аюулгүй байдлын тухай хуулийн 7.1, 17.1.1, 17.2.4 дэх хэсэг, мөн албаны Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөний 3.2.2, 3.2.3 дахь заалтын дагуу 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Төв аймгийн ОБГ-тай хамтран гал түймэр, гамшгийн аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох танхим болон дадлагын сургалтыг зохион байгуулж, баримтжуулсан.
4.	Тоног төхөөрөмжийн ажиллагаа алдагдах	Шатахууны агуулах, дохиолол холбооны системийн найдвартай ажиллагаанд үзлэг шалгалт хийж, холбогдох албан дүгнэлтүүдийг гаргуулж байх	-Утаа мэдрэгч  -Шилэн кабелийн шугам  -Камерын хяналтын систем	Жилд 1 удаа	-	Шатахууны агуулахын дохиолол холбооны системийн найдвартай ажиллагаанд үзлэг шалгалтыг хийж, холбогдох албан дүгнэлтүүдийг гаргаж, баталгаажуулан, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.
ИНЕГ, ИНҮТ-ийн Шатахуун хангалтын албаны Осол, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх зардал (төг)						-

**ЗУРГАА. НУБИЭ ХХК-ИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**




№	Төрөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт зардал (төг)	Хэрэгжилт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>						
<b>1</b>	<b>Дахивар</b>					
1.1	Хуванцар сав, гялгар уут	Хог хаягдлын тээвэрлэлтийн компанитай гэрээгээр хамтран ажиллах,	Нисэх буудлын дотор болон гадна орчинд	Тогтмол хэрэгжиж буй	(холбогдох зардал 2.1 хүснэгт-Энгийн хог хаягдлын зардалтай хамт орсон болно)	Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх чиглэлээр 2023 оны 1-5 дугаар сарын хооронд “Грийн Го Ми” ХХК-тай, 2023 оны 5-12 дугаар сард “Элемент Мэдикал” ХХК-тай аутсорсингоор хамтран ажиллаж байна. 2023 онд нийт 137.8 тонн дахивар хог хаягдал ачуулж, тээвэрлүүлсэн. (Гэрээ, 12 дугаар сарын тайланг хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 2/ 18-43)
1.2	Шил, лааз					
1.3	Цаас, цаасан хайрцаг					
<b>2</b>	<b>Энгийн хог хаягдал</b>					
2.1	Бусад (ангилагдахгүй тамхины, ариун цэврийн өрөөний хог хаягдал)	Хог хаягдлын тээвэрлэлтийн компанитай гэрээгээр хамтран ажиллах,	Нисэх буудлын дотор болон гадна орчинд	Тогтмол хэрэгжиж буй	121,375,660	2023 онд нийт 971.4 тонн энгийн хог хаягдлыг ачуулж, тээвэрлүүлсэн. Ачсан хог хаягдлыг Элемент Мэдикал ХХК-ийн Налайх дүүрэгт байрлах хог хаягдла булшлах зөвшөөрөл бүхий газарт булж, устгаж байна.
<b>3</b>	<b>Хүнсний хог хаягдал</b>					



3.1	Хүнсний нойтон хог хаягдал (Жимс ногооны хальс, хоолны үлдэгдэл)	Хог хаягдлын тээвэрлэлтийн компанитай гэрээгээр хамтран ажиллах, Хүнсний хог хаягдлыг үүссэн газарт нь шүүрэлт үүсэхгүй хогийн уутанд 1-ээс дээш хоног хадгалахгүй, үүссэн газраас шууд ачилт хийнэ	Нисэх буудал болон захиргааны барилга дахь хоолны газрууд, кофе шоп, ажилчдын хоолны өрөө	Тогтмол хэрэгжиж буй	40,155,480	2023 онд нийт 525 тонн хүнсний нойтон болон шингэн хог хаягдлыг ачуулж, тээвэрлүүлсэн. Хүнсний нойтон болон шингэн хог хаягдал нь нисэх буудлын зорчигч терминалын байрилгын хоолны үйл ажиллагаа эрхэлдэг түрээслэгч 9-10 аж ахуйн нэгжүүдээс гардаг. Хүнсний нойтон болон шингэн хог хаягдлыг үүссэн газарт нь шүүрэлт үүсэхгүй хогийн уутанд, хаягдал тосыг хуванцар саванд хуримтлуулж, өдөрт нэг удаа цагийн хуваарийн дагуу ачилт, тээвэрлэлтийг хийж байна.
3.2	Хүнсний шингэн хог хаягдал					
4	<b>Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны аюултай хог хаягдал</b>					
4.1	Тос масло	Хог хаягдлын тээвэрлэлтийн компанитай гэрээгээр хамтран ажиллах,	Газрын тусгай үйлчилгээ, аэродром, цахилгаан, цэвэр ус, цэвэрлэх байгууламж, дулааны станц	Тогтмол хэрэгжиж буй	2,644,592	Нийт 5 удаагийн рейсээр 5 тонн ашигласан техникийн тос масло, 1,200 кг хаягдал техникийн сэлбэг ачиж, тээвэрлүүлсэн. Нийт 2,8 тонн хаягдал техникийн тосыг “Хай Би Ойл” ХХК-ийн дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн. Тухайн байгууллага нь хаягдал тос үйлдвэрийн аргаар боловсруулан дулааны үүсгүүрт ашигладаг Мазут М-100 маркийн өтгөрүүлсэн тос үйлдвэрлэдэг.
4.2	Авто машины хаягдал сэлбэг					

4.3	Дулааны станц үнс	Хог хаягдлын тээвэрлэлтийн компанитай гэрээгээр хамтран ажиллах, Үнсийг өөрийн байгууламж дахь үнс хадгалах савнаас шууд тээвэрлэх	дулааны станц	Тогтмол хэрэгжиж буй	29,283,072	Нисэх буудал үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн байгууллагыг дэмжиж ажиллах зорилгоор нисэх буудлын дулааны станцын үнсийг ачих, тээвэрлэх, зориулалтын талбайд булшлах ажлыг “Төв аймгийн Хот тохижуулах газар”-тай 151/23 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан Гүйцэтгүүлж байна.  2023 онд нийт 1,322 м3 үнс ачиж, тээвэрлүүлсэн.  (Гэрээг хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 2/ 44-50)
5	<b>Эмнэлгийн болон аюултай хог хаягдал</b>					
5.1	Эмнэлгийн хог хаягдал	Аюултай хог хаягдлын менежментийн компанитай гэрээгээр хамтран ажиллах, Үүссэн газраас нь шууд ачилт тээвэрлэлт хийх. Лагийг өөрийн байгууламж дахь лаг хадгалах савнаас шууд тээвэрлэх.	Нисэх буудлын эмнэлэгийн тусламжийн төв, үйлчилгээний танхим, түрээслэгч байгууллагуудын талбай, оффисийн талбай	Тогтмол хэрэгжиж буй	9,945,000	“Элемент” ХХК тай 150/23 дугаартай 2 жилийн хугацаатай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж, аюултай болон эмнэлгийн хог хаягдлын ачилт, тээвэрлэлт, ариутгал, устгалын ажлыг гүйцэтгүүлж байна. Аюултай хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт бусад хог хаягдалтай нийлүүлэхгүй үүссэн цэгээс шууд тээвэрлэж 100-120 градус цельсийн уурын автоклавын тусламжтайгаар халдваргүйжүүлэн буталж, ландфиллын аргаар устгаж байна. Нийт 51 удаагийн рейсээр 406,9 кг халдвартай эмнэлэгийн хог хаягдлыг тээвэрлэж, ариутган устгалд оруулсан. Устгалын актыг тухай бүрт нь авч байна. (Гэрээ, устгалын актыг хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 2/ 51-64)
5.2	Лаг	Аюултай хог хаягдлын менежментийн компанитай гэрээгээр хамтран ажиллах, Үүссэн газраас нь шууд ачилт тээвэрлэлт хийх.		Тогтмол хэрэгжиж буй	8,500,000	“Элемент” ХХК тай 150/23 дугаартай 2 жилийн хугацаатай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж, цэвэрлэх байгууламжаас гарсан лаг, механик хог хаягдлын ачилт, тээвэрлэлт, устгалын ажлыг гүйцэтгүүлж байна. Лагийг зориулалтын шатаах зууханд цельсийн 800 градуст шатааж, хаягдал үнсийг зөвшөөрөл бүхий хог хаягдал булах талбайд булшилсан.

		Лагийг өөрийн байгууламж дахь лаг хадгалах савнаас шууд тээвэрлэх.	Цэвэрлэх байгууламж			Нийт 10 удаагийн рейсээр 30 тонн лагийг тээвэрлүүлж, ландфилдэж устгалд оруулсан. Устгалын актыг тухай бүрт нь авч байна.   
5.3	Механик хаягдал	Аюултай хог хаягдлын менежментийн компанитай гэрээгээр хамтран ажиллах, Үүссэн газраас нь шууд ачилт тээвэрлэлт хийх. Лагийг өөрийн байгууламж дахь лаг хадгалах савнаас шууд тээвэрлэх.	Цэвэрлэх байгууламж	Тогтмол хэрэгжиж буй	7,200,000	Нийт 27,9 тонн механик хог хаягдлыг “Элемент” ХХК-аар тээвэрлүүлж, ландфилдэж устгалд оруулсан. Устгалын акт-г тухай бүрт нь авч байна.
5.4	Шатамхай болон зэвсэгийн чанартай хог хаягдал	Шатамхай болон зэвсэгийн чанартай хог хаягдлыг үүссэн газраас нь шууд тээвэрлэлт хийж, устгах.	Нисэх буудлын хилийн хяналтын бүс	Тогтмол хэрэгжиж буй	1,428,900	Нисэх буудлын үзлэгийн цэгээс хураагдсан нийт 406.9 кг шатамхай болон зэвсгийн чанартай аюултай хог хаягдлыг “Элемент” ХХК-аар үүссэн цэгээс нь шууд тээвэрлүүлж, устгалд оруулсан. Устгалын актыг тухай бүрт авч байна.

5.5	Лабораторийн аюултай хог хаягдал	Холимог хүчлийн хаягдал Лабораторийн хог хаягдлыг зориулалтын хогийн саванд үүссэн газар нь хадгалж, хуваарийн дагуу тээвэрлэх, хоргүйжүүлэх, устгах	Лаборатори	Тогтмол хэрэгжиж буй	1,119,504	Нисэх буудлын цэвэр усны лабораторийн нийт 93.6 литр хүчил, шүлтийн холимог аюултай хог хаягдлыг “Элемент” ХХК-аар үүссэн цэгээс нь шууд тээвэрлүүлж, устгалд оруулсан. Устгалын актыг тухай бүрт нь авч байна.
6.	<b>Мэрэгч, шавж устгал</b>					
6.1	Мэрэгч, шавж устгал	Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээгээр хамтран ажиллах	Захиргааны барилга 1786 мкв , Дулаан` `ы станц 655 мкв, Цахилгаан 170 мкв, Газрын тусгай үйлчилгээ 4252 мкв, Ачаа, шуудангийн үйлчилгээний барилга 3115 мкв болон аэродромын талбай	5-р сард, 8-р сард	34,227,800	Мэрэгч, шавж устгал, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг “Улаанбаатар Ариутгал” ХХК-тай 117/23 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж, гүйцэтгүүлсэн. 2023 оны 5 дугаар сар болон 8 дугаар сард нисэх буудлын нийт 10 барилга байгууламжийн 22,713 мкв талбай, хориотой бүсийн нийт 600 га талбайд ариутгал, шавж, мэрэгч устгалыг хийлгэсэн. (Гэрээ, тайланг хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 2/ 65-91)
7.	<b>Хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, дахин ашиглах. Сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах</b>					
7.1	Карго терминалын барилгаас гарч буй цаасан (картон хайрцаг) хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Цаас дахин боловсруулах үйлдвэрийн судалгааг хог хаягдлын менежментийн компанитай хамтран хийх. Дахин боловсруулсан цаасаар нэрийн хуудас гэх мэт	Карго терминалын нэгдсэн хогийн цэг	Төлөвлөж буй	-	Карго терминалын барилгын гаднах төвлөрсөн хогийн цэгт цаасан (картон хайрцаг) хог хаягдлыг ангилж хаях хогийн савтай. Картон цаас дахин боловсруулах үйлдвэрийн судалгаа хийж, “Сайнцаас” ХХК-тай хамтран ажиллахаар шийдвэрлэсэн.

		бүтээгдэхүүн үйлдвэрлүүлэх боломжийг судлах				
7.2	Хуванцар, шил, лааз, ашигласан техникийн тос, хоол хүнсний хаягдал болон хүнсний хаягдал тосыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Хуванцар, шил, лааз, ашигласан техникийн тос, хоол хүнсний хаягдал болон хүнсний хаягдал тосыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх судалгааг хог хаягдлын менежментийн компанитай хамтран хийх	Нисэх буудлын үйл ажиллагааны хүрээнд	Тогтмол хэрэгжиж буй	-	<p>Хог хаягдлын 3R зарчмын хүрээнд Нисэх буудлын автомашин, техникийн үйлчилгээнээс гарсан нийт 2,8 тонн хаягдал техникийн тосыг үүссэн цэгээс нь тээвэрлэн “Хай Би Ойл” ХХК-ийн хаягдал дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэн ажиллаж байна. Тухайн байгууллага нь хаягдал тос үйлдвэрийн аргаар боловсруулан Мазут М-100 маркийн халаалтын зууханд ашигладаг өтгөрүүлсэн тос үйлдвэрлэдэг</p>   <p>Хүнсний ашигласан тосыг “Канаан Ланд” ХХК-ийн дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн. Тус компани 2023 онд нийт 46 ширхэг эдийн саван, 500 грамм нунтаг саван, үйлдвэрлэж ирүүлсэн. Уг саванг цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэглэсэн.</p> 

7.4	Хог хаягдлын менежментийн сургалт, нөлөөллийн ажил	Хог хаягдлын менежментийг хамтран хэрэгжүүлж буй гэрээт компанитай хамтран нисэх буудлын үйл ажиллагаанд оролцогч бүх талуудад сургалт зохион байгуулна. Мэдээлэл бэлтгэж хүргүүлнэ.	Нисэх буудлын нийт түрээслэгч байгууллагууд болон цэвэрлэгээ үйлчилгээний ажилчдын хүрээнд	5 дугаар сард, 9 дүгээр сард	-	<p>Хог хаягдлын менежментийн ажлын хүрээнд хог хаягдлын менежментийн хууль эрх зүйн орчин, хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хог хаягдлыг дахин ашиглах ач холбогдол, эдийн засгийн өгөөжийн талаар мэдлэг олгох сургалтыг 2 удаагийн давтамжтайгаар нийт нисэх буудлын түрээслэгч байгууллагууд болон цэвэрлэгээ үйлчилгээний ажилчдын дунд амжилттай зохион байгуулсан. "Хог хаягдлын менежментийн журам" брошур бэлтгэж, нисэх буудлын орчинд үйл жиллагаа эрхэлж буй бүх байгууллагуудад хүргэсэн.</p>  
НУБИЭ ХХК-ийн Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт дүн (төг)					255,880,008₮	

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж байгаа, төлөвлөж байгаа	Нийт зардал (төг)	Биелэлт
<b>2.ИНЕГ, ИНҮТ-ийн Шатахуун хангалтын алба</b>						
1.	Ахуйн хог хаягдал	-Төвлөрсөн хогийн савыг тэмдэгжүүлэх -Мэдээлэл сурталчилгаа хийх -Хог хаягдал зайлуулах гэрээг эрх бүхий этгээдтэй хийх	Шатахууны агуулахын орчим	Тухайн тохиолдолд	Хог ачилт 2 886 800₮  Бохир соруулалт  3 170 000₮	2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газартай байгуулсан “Хог хаягдал ачиж, тээвэрлэх ажил гүйцэтгэх гэрээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулсаны дагуу 2023 оны 1-12 дугаар саруудад нийт 252м3 хог хаягдлыг ачуулж, 339 тн бохир соруулсан. (“Хог хаях ачиж, тээвэрлэх ажил гүйцэтгэх” гэрээг хавсаргав. ИНЕГ, ИНҮТ-ийн ШХА Хавсралтууд 11-16 дугаар хуудас)
2.	Аюултай	-Аюултай хог хаягдал устгах эрх зөвшөөрлийг авах -Мэдээлэл хийх, тэмдэгжүүлэх	Шатахууны агуулахын орчим	1-12 сард	Ариутгал 1 600 000₮	

2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн “Цацу”



ХХК-тэй байгуулсан “Үйлчилгээ үзүүлэх гэрээ”  
ИНУТ-41/2023-ний дагуу байгууламжийн  
захиргааны байр болон агуулахын нийт 800 м2  
талбайд 2023 оны 3, 4-р улирлын шавьж, мэрэгч  
устгал, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийж  
гүйцэтгүүлсэн.



						 <p>2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн “Ногоон титэм” ХХК-тэй байгуулсан ИНУТ58/2023 дугаар “Лабораторийн шинжилгээний үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу 2023 оны 09 дүгээр 26-ны өдөр агаар, хөрсний шинжилгээ хийлгэсэн.</p> <p>-</p>
ИНЕГ, ИНУТ-ийн Шатахуун хангалтын албаны Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх нийт зардал /төг/					7 656 800 ₮	

ДОЛОО. НУБИЭ ХХК-ИЙН ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн Байршил	Хугацаа	Давтамж	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт зардал (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>							
<b>1. АГААРЫН ЧАНАР</b>							
1.	Агаарын чанарын үзүүлэлт: NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , O <sub>3</sub> , H <sub>2</sub> S, CO <sub>2</sub> , CO, тоосжилт  /органик биш бохирдуулагч/	Нисэх зурвасын баруун төгсгөл орчим агаарын хөлөг хөөрөх үед  Нисэх зурвасын баруун төгсгөл орчим агаарын хөлөг буух үед  Нисэх зурвасын зүүн төгсгөл орчим агаарын хөлөг хөөрөх үед  Нисэх зурвасын зүүн төгсгөл орчим агаарын хөлөг буух үед  Перрон талбай орчим  Нисэх буудлын автомашины зогсоол  Дулааны станцын бамбар утааны дагуу 400 метр	8 цэг 7 сар, 10 сар	2 удаа	Бүрэн хэрэгжсэн	8,670,000	Агаарын чанарын үзүүлэлтүүдийг (NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , O <sub>3</sub> , H <sub>2</sub> S, CO <sub>2</sub> , CO) 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдөр болон 10 дугаар сарын 26-ны өдөр “Ногоон титэм” ХХК-иар гүйцэтгүүлсэн. Шинжилгээний дүн “MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”, “MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага” стандартад нийцсэн.  Тоосжилтын шинжилгээг 2023 оны 09 дүгээр сарын 19 болон 10 дугаар сарын 27-ны өдөр “Хэлт энд Сэфти Солюшинс” ХХК-иар гүйцэтгүүлсэн. Шинжилгээний дүн нь нийт тоосны бохирдлын түвшин MNS 4585:2016 стандартад заасан 20 минутын хүлцэх хэмжээ (500 мкг/м <sup>3</sup> )-ээс хэтрээгүй, стандартад нийцсэн.  (Шинжилгээний хариуг хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 3/ 92-121)

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн Байршил	Хугацаа	Давтамж	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт зардал (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>							
		Дулааны станцын бамбар утааны дагуу 4000 метр					
2.	Орчны агаар дахь ДОН-ийн шинжилгээ хийх (VOCз)	Түлшний агуулах орчим (салхины доод талд 100 м)  Зорчигч үйлчилгээний терминалын орчимд	2 цэг, 7-р сар, 10-р сар	2 удаа	Бүрэн хэрэгжсэн	1,120,000	Орчны агаар дахь дэгдэмхий органик нэгдлийн шинжилгээг “Ногоон титэм” ХХК-иар 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдөр болон 10 дугаар сарын 26-ны өдөр гүйцэтгүүлсэн. Шинжилгээний дүн нь “MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, Хөдөлмөрийн эрүүл ахуй, Ажлын байрны орчин, Эрүүл ахуйн шаардлага”-ын стандартад нийцэж байна. (Шинжилгээний хариуг хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 3/ 114-121)
3.	Дуу чимээний суурь хэмжилт	Нисэх зурваст агаарын хөлөг хөөрөх үед f Нисэх зурваст агаарын хөлөг буух үед Нисэх зурваст агаарын хөлөг хөөрч, буугаагүй үед Нисэх буудлын автомашины зогсоол Нисэх буудлын дулааны станц Төслийн талбайн хил (зүүн тал)	7 цэг, 7-р сар, 10-р сар	2 удаа	Бүрэн хэрэгжсэн	3,031,600	Дуу чимээний хэмжилтийг “Хэлт энд Сэфти Солюшинс” ХХК-иар 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр болон 10 дугаар сарын 27-ны өдөр гүйцэтгүүлсэн. (Шинжилгээний хариуг хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 3/ 92-107)

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн Байршил	Хугацаа	Давтамж	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт зардал (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>							
		Төслийн талбайн хил (баруун тал)					
4,	Хаягдал утааны хэмжилт хийлгэх (O2, CO2, CO, SO2, NOx, тоос/дэгдэмхий үнс/)	Дуулааны станц зуух 1	10-р сард	1 удаа	Бүрэн хэрэгжсэн	170,000	<p>Дулааны станцын хаягдал утааны хэмжилтийг “Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар”-аар 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр гүйцэтгүүлсэн. Шинжилгээний дүнгээр Нүүрс хүчлийн дутуу исэл (CO) зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс илүү гарсан. Үүнтэй холбоотойгоор нүүрс ханган нийлүүлэгч байгууллагад Нүүрсний чанарыг сайжруулах талаар шаардлага удаа дараа тавьсан ба 2024 оны 1 дүгээр сард гэрээг хоёр талуудын зөвшөөрөлтэйгөөр цуцалж “Кузмен тайж” ХХК-тай гэрээ шинээр байгуулан ажиллаж байна.</p> <p>(Шинжилгээний хариу, албан бичиг хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 3/ 122-123)</p>
		Дулааны станц зуух 2					
<b>Нийт дүн (төг)</b>							
<b>2. ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УСНЫ ЧАНАР</b>							
1.	Усны химийн болон физикийн үзүүлэлтүүд	3 гүний худаг , Түүхий усны танк, Цэвэрлшүүлсэн усны танк, Зорчигч үйлчилгээний барилгын ерөнхий оролтын шугам, Гаралтын	Сар бүрийн дээж авах төлөвлөгөөний дагуу	Сар бүрийн дээж авах төлөвлөгөөний дагуу	Тогтмол хэрэгжиж байгаа	Усны химийн итгэмжлэгдсэн лаборатори (өөрийн лабораторид) сорилт	Усны химийн итгэмжлэгдсэн лаборатори нь сар бүрийн “Дээж авах, шинжилгээ хийх төлөвлөгөө”-ний дагуу ундны усанд итгэмжлэлийн хүрээний үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийж байна. Тус лаборатори нь төлөвлөгөөний дагуу 3 гүний худаг,


№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн Байршил	Хугацаа	Давтамж	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт зардал (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>							
		шугам, Онгоцонд ус өгөх цэг, Онгоцны ус зөөх машин				шинжилгээ хийж байна.	Онгоцонд ус өгөх цэг, Онгоцны ус зөөх машин гэх мэт нийт 9 цэгээс нийт 166 ундны усны дээжинд стандартын дагуу сорилт шинжилгээ хийхэд “MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүйн байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага. Чанар, аюулгүй байдлын үнэлгээ” стандартын шаардлагыг хангаж байна (Шинжилгээний хариуг хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 3/ 124-141)
2.	Ундны усны бичил амь судлалын үзүүлэлт	3 гүний худаг , Түүхий усны танк, Цэвэрлшүүлсэн усны танк, Зорчигч үйлчилгээний барилгын ерөнхий оролтын шугам, Гаралтын шугам, Онгоцонд ус өгөх цэг, Онгоцны ус зөөх машин	Сар бүр	Сард 8 удаа	Тогтмол хэрэгжиж байгаа	2,160,000	Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн Хэлтсийн Итгэмжлэгдсэн лабораторитай байгуулсан гэрээний дагуу 7 хоногт 2 нийт 94 дээжинд микробиологийн шинжилгээ хийлгэхэд үр дүн MNS 0900:2018 стандартын шаардлагын хангаж байна (Шинжилгээний хариуг хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 3/ 142-145)
3.	Хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораториор ундны усны хими, физикийн үзүүлэлт болон хүнд элементүүдийн шинжилгээ	Түүхий усны танк, Цэвэршүүлсэн усны танк, Онгоцонд ус өгөх цэг, Онгоцны ус зөөх машин	Улирал бүр, (1 удаад 4 дээж)	4 удаа	Тогтмол хэрэгжиж байгаа	Лаборатори хоорондын харьцуулалтын гэрээний дагуу/ үнэ төлбөргүй/	Усны химийн итгэмжлэгдсэн лабораторийн гадаад хяналтын сорилт шинжилгээ хийх төлөвлөгөөний дагуу “Хан лаб” ХХК болон Усны газрын лабораторид гадаад хяналтын 10 дээж хүргүүлэн усны хими, физикийн болон хүнд элементүүдийн сорилт шинжилгээ хийлгэхэд, үр дүн стандартын шаардлагыг хангаж байна. (Шинжилгээний хариуг хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 3/ 146-147)

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн Байршил	Хугацаа	Давтамж	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт зардал (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>							
4.	Бохир усны шинжилгээ - Бичил амь судлалаын үзүүлэлт	Цэвэрлэх байгууламжруу орох ус	Сард 1 удаа	12 удаа	Тогтмол хэрэгжиж байгаа	435,600	Ирж буй усны чанарт хяналт тавьж хүрээлэн буй орчинд нийлүүлэгдэх усны MNS494352015 стандартын шаардлага хангасан усыг байгальд нийлүүлсэн. (Шинжилгээний хариуг хавсаргав, "НУБИЭ" ХХК Хавсралт 3/ 148)
5.	Цэвэрлэгдсэн бохир усны шинжилгээ - Бичил амь судлалын үзүүлэлт	Цэвэрлэх байгууламжаас гарах ус Хүрээлэн буй орчинд нийлүүлэгдэж буй ус	Сард 1 удаа 1 цэг Хагас жилд 1 удаа 1 цэг	12 удаа 2 удаа	Тогтмол хэрэгжиж байгаа	435,600	
6.	Бохир усны химийн шинжилгээ – рН, Аммоний, Нитрит, Нитрат, Чөлөөт хлор, Умбуур бодис, Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч, Хром(У1), Фосфор болон хүнд металлийн агууламжийн үзүүлэлтээр	Цэвэрлэх байгууламжруу орох ус	Сард 1 удаа 1 цэг	12 удаа	Тогтмол хэрэгжиж байгаа	1,515,360	Ирж буй усны чанарт хяналт тавьж хүрээлэн буй орчинд нийлүүлэгдэх усны MNS494352015 стандартын шаардлага хангасан усыг байгальд нийлүүлсэн. (Шинжилгээний хариуг хавсаргав, "НУБИЭ" ХХК Хавсралт 3/ 148)

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн Байршил	Хугацаа	Давтамж	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт зардал (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>							
7.	Цэвэрлэгдсэн бохир усны химийн шинжилгээ - рН, Аммони, Нитрит, Нитрат, Чөлөөт хлор, Умбуур бодис, Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч, Хром(У1), Фосфор болон бусад хүнд металлийн агууламжийн үзүүлэлтээр	Бохир ус цэвэрлэх байгууламж	Сард 1 удаа, 1 цэг	12 удаа	Тогтмол хэрэгжиж байгаа	2,257,420	Ирж буй усны чанарт хяналт тавьж хүрээлэн буй орчинд нийлүүлэгдэх усны MNS494352015 стандартын шаардлага хангасан усыг байгальд нийлүүлсэн. (Шинжилгээний хариуг хавсаргав, "НУБИЭ" ХХК Хавсралт 3/ 148)
		Хүрээлэн буй орчинд нийлүүлэгдэж буй ус	Хагас жилд 1 удаа 1 цэг	2 удаа			
8.	Цэвэрлэх байгууламжийн лагийн шинжилгээ	Цэвэрлэх байгууламж	Улиралд 1 удаа	4 удаа	Бүрэн хэрэгжсэн	5,000,000	Цэвэрлэх байгууламжаас гарах лагийг бордоо болгож, хүрээлэн буй орчинд нийлүүлэгдэх аюултай болон энгийн хог хаягдлыг хэмжээг бууруулсан. Уг бордоог Цэвэрлэх байгууламжийн орчинд зүлэг тарих, мод бордох зэрэг ногоон байгууламж байгуулахад ашигласан.
<b>Нийт дүн (төг)</b>							
<b>3.ХӨРС, ХӨРСӨН БҮРХЭВЧ SOIL QUALITY</b>							

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн Байршил	Хугацаа	Давтамж	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт зардал (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>							
1	Хөрсөн дэх хүнд металлуудын агууламжийг тодорхойлох /Кальци, магни, натри, кали, хөнгөнцагаан, бари, кадми, кобаль, зэс, хром, төмөр, мангани, молибдени, хартугалга, стронци, цайр, ванади, никель, хүнцэл/	-Дулааны станцын нүүрс, үнсний талбайн баруун урд талд /зонхилох салхины чиглэл/ 10 м зайд 1ш -Авто засвар, үйлчилгээний барилга орчим 1ш -Цахилгааны дэд өртөө 1ш	7 сар 3 цэг	1 удаа	Бүрэн хэрэгжсэн	212,020	Хөрсөн дэх хүнд металлуудын шинжилгээг 2023 оны 08 дугаар сарын 16-нд “Хан лаб” ХХК-иар гүйцэтгүүлсэн. Шинжилгээний дүнг нь “MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартад нийцэж байна. (Шинжилгээний хариуг хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 3/ 148)
2.	Нянгийн шинжилгээ/ Нянгийн ерөнхий тоо, гэдэсний бүлгийн нянгийн тоо, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян, E.Coli халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тоо	-Захиргаа удирдлагын барилга -Карго терминалын барилгын төвлөрсөн хогийн цэгийн зонхилох салхины чиглэлийн /баруун/ талаас	7 сар, 2 цэг	1 удаа	Бүрэн хэрэгжсэн	239,200	“Хан лаб” ХХК-иар 2023 оны 08 дугаар сарын 16-нд Нисэх буудлын хогийн нэгдсэн 2 цэгээс хөрсний нянгийн шинжилгээ хийсэн. Шинжилгээний дүнгээр хөрс бохирдолгүй, “MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх” стандартад нийцэж байна. (Шинжилгээний хариуг хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 3/ 149)

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн Байршил	Хугацаа	Давтамж	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт зардал (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>							
3.	Цөмийн цацрагийн шинжилгээ	-Дулааны станцын шлакаас гарч буй үнс -Дулааны станцын фильтрээс гарч буй үнс	10-11 сард 2 цэг	1 удаа	Бүрэн хэрэгжсэн	70,000	“Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори”-ор 2023-2024 оны дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлсний дараа 2023 оны 11 сарын 13-ны өдөр шинжилгээ хийлгүүлсэн. Хариугаар: Үнс 1 - 1178 Радийн эквивалент Бк/кг Үнс 2 - 622 Радийн эквивалент Бк/кг (Шинжилгээний хариуг хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 3/ 150-151)
<b>Нийт дүн (төг)</b>							
<b>4.ШУВУУ, ХӨХТӨН АМЬТДЫН СУДАЛГАА</b>							



1,	Аэродромын талбай орчмын шувууны болон хөхтөн амьтдын мониторинг судалгаа хийх	Шувууны, хөхтөн амьтдын мониторинг судалгааг хавар, намрын нүүдэл, үржлийн болон өвөлжиж буй үед аэродромын талбай болон 15 км радиуст гүйцэтгэх. Хээрийн судалгааны ажиглалтыг аэродромын талбайн гадна болон дотор талбайд гүйцэтгэх	Сард 1	12 удаа	Тогтмол хэрэгжиж буй	25,954,356	<p>“Биологийн нөөцийг хамгаалах төв” ТББ-тай “Аэродромын талбай, нисэх буудал орчмын шувуу, хөхтөн амьтдын мониторинг судалгаа” хийх гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Шувуу, зэрлэг амьтны хяналтын мэргэжилтэн сард 1-2 удаа нисэх буудлын ойр орчмын 15 км радиус газарт үзлэг хийж, шувуудыг ажиглах, бүртгэх, үргээх арга хэмжээ авч байна.</p> 
----	--	--	--------	---------	----------------------	------------	---


№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн Байршил	Хугацаа	Давтамж	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт зардал (төг)	Биелэлт
<b>1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК</b>							
<b>Нийт дүн (төг)</b>							
<b>НУБИЭ ХХК</b>							
<b>Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлтийн нийт дүн (төг)</b>			<b>51,271,156₮</b>				




№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал (төг)	Тайлбар	Биелэлт
<b>2.ИНЕГ, ИНҮТ-ийн Шатахуун хангалтын алба</b>								
<b>1. АГААРЫН ЧАНАР</b>								
1.	Орчны агаар дахь ДОН-ийн шинжилгээ хийх / VOCs/	-Шатахууны агуулах орчим салхины доод талд 100м -Шатахууны агуулахаас салхины доод талд 1000м	Жилд	1	-	560 000	-	2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр ИНҮТ58/2023 дугаар “Лабораторийн шинжилгээний үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу “Ногоон титэм” ХХК-ээр агаарт дэгдэмхий органик нэгдэл, хөрсөнд агрохими, хүнд метал, микробиологи тодорхойлох шинжилгээг хийлгэж, тайлан дүгнэлтийг авсан.  (Шинжилгээний хариуг хавсаргав. ИНЕГ, ИНҮТ-ийн ШХА Хавсралтууд 17-22 дугаар хуудас)
<b>2. ХӨРС, ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>								
1.	Агрохими	-Эвдрэлд өртөөгүй талбайгаас /Байгалийн фон цэг төслийн талбайн гадна, дотор талд 2 үе 4 ш дээж авах/ -Нөхөн сэргээсэн талбайгаас Нийт 5 ш дээж авах	Хагас жил тутам	2	65 000	130 000	Хөрснөөс шинжилгээнд авсан дээжийг бохирдол орохооргүй цэвэр уут саванд хийж, хөрсний чийг, температурыг алдагдуулахааргүй хамгаалсан нөхцөлд тээвэрлэн хадгалж 24 цагийн дотор	2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр ИНҮТ58/2023 дугаар “Лабораторийн шинжилгээний үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу “Ногоон титэм” ХХК-ээр агаарт дэгдэмхий органик нэгдэл, хөрсөнд агрохими, хүнд метал, микробиологи тодорхойлох шинжилгээг хийлгэж, тайлан дүгнэлтийг авсан.  (Шинжилгээний хариуг хавсаргав. ИНЕГ, ИНҮТ-ийн ШХА Хавсралтууд 23-24 дугаар хуудас )



№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал (төг)	Тайлбар	Биелэлт
<b>2.ИНЕГ, ИНУТ-ийн Шатахуун хангалтын алба</b>								
							лабораторид хүргэж шинжилгээнд өгнө.	
2.	Хөрсөн дэх хүнд металлуудын агууламжийг тодорхойлох /Кальци, магни, натри, кали, хөнгөнцагаан, бари, кадми, кобаль, зэс, хром, төмөр, мангани, молибдени, хартугалга, стронци, цайр, ванади, никель, хүнцэл/	Шатахууны агуулахын талбайн баруун хэсгээс	Хагас жил тутам	2	130 000	260 000		2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр ИНУТ58/2023 дугаар “Лабораторийн шинжилгээний үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу “Ногоон титэм” ХХК-ээр агаарт дэгдэмхий органик нэгдэл, хөрсөнд агрохими, хүнд метал, микробиологи тодорхойлох шинжилгээг хийлгэж, тайлан дүгнэлтийг авсан.
3.	Нянгийн шинжилгээ /Нянгийн ерөнхий тоо, гэдэсний бүлгийн нянгийн тоо, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян, E.coli халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тоо/	Шатахууны агуулахын төвлөрсөн хогийн цэгийн зонхилох салхины чиглэлийн /баруун/ талаас	Хагас жил тутам	2	200 000	400 000	Нянгийн шинжилгээ тодорхойлох дээжийг хадгалахгүйгээр авсан өдөрт нь багтаан шинжилгээнд оруулна.	2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр ИНУТ58/2023 дугаар “Лабораторийн шинжилгээний үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу “Ногоон титэм” ХХК-ээр агаарт дэгдэмхий органик нэгдэл, хөрсөнд агрохими, хүнд метал, микробиологи тодорхойлох шинжилгээг хийлгэж, тайлан дүгнэлтийг авсан.
<b>Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал (төг)</b>						<b>1 804 000 ₮</b>		


**НАЙМ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТ**


№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь	Нийт зардал (төг)	Биелэлт
1.	Байгаль орчны менежмент, хог хаягдлын менежментийн талаар ажилтнуудад сургалт зохион байгуулах	5, 10 сард	200,000	<p>Хог хаягдлын менежментийн ажлын хүрээнд хог хаягдлын менежментийн хууль эрх зүйн орчин, хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хог хаягдлыг дахин ашиглах ач холбогдол, эдийн засгийн өгөөжийн талаар мэдлэг олгох талаар сургалтыг нисэх буудлын нийт түрээслэгч аж ахуйн нэгжийн ажилчид болон цэвэрлэгээ үйлчилгээний ажилчдад 2 удаа зохион байгуулсан.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <p>2023 оны 12 сарын 06-ний өдөр “НУБИЭ” ХХК-ийн холбогдох ажилтнуудад “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, батлах, тайлагнах журмуудыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлуудын талаарх сургалтыг зохион байгуулсан.</p>

				
2.	Байгаль орчны менежмент, хог хаягдлын менежментийн чиглэлээр олон улсын туршлага судлах	1-12 сард	-	<p>Дараах баримт, материалуудыг уншиж, судалсан:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Нарита ОУНБ Корпораци, Ногоон Нисэх Буудал 2020.</li> <li>-Нисэх буудлын зөвлөл Олон улсын Ази Номхон далайн бүс нутаг, Ногоон нисэх буудлууд 2023. Нэг удаагийн хуванцарыг хэрэглээнээс халах.</li> <li>-Инженер, менежмент, хэрэглээний шинжлэх ухааны хамгийн сүүлийн үеийн технологийн олон улсын сэтгүүл, Ногоон нисэх буудал- Бохирдлыг зогсоох шийдэл 2019.</li> <li>-Ногоон нисэх онгоцны буудлын загвар: Нийгэм, байгаль орчны удирдлагын системд суурилсан санал. Sustainable Cities and Society 59-р боть, 2020 оны 8-р сар, 102160</li> </ul>
3.	Компанийн байгаль орчин, хог хаягдлын менежментийн чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөлт, хөтөлбөр, журмын хэрэгжилтэд хяналт тавих	1-12 сард	-	<p>НУБИЭ ХХК нь зорчигч үйлчлүүлэгчдийг аюулгүй, эрүүл цэвэр орчинд үйлчлүүлэх нөхцлийг бүрдүүлэх, нислэгийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, хог хаягдлыг багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах “3R” зарчмыг баримтлан ажиллаж байна.</p> <p>“Хог хаягдлын менежментийн журам” боловсруулж, батлуулсан.</p>

			<div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <p>Хог хаягдлыг хэрхэн ангилан ялгаж хаях талаар мэдээллийг компанийн дотоод сүлжээгээр ажилтнуудад хүргэсэн. Хогын уутыг хог хаягдлын ангилан ялгах савны тэмдэг тэмдэглэгээтэй адил өнгөтэй болгосон. Ингэснээрээ төвлөрсөн хогийн цэгт ангилсан хог хаяндал холилдохгүй байх нөхцлийг бүрдүүлж байна.</p> <div style="text-align: center;">  </div>
4.	Байгаль орчны талаарх өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах	1-12 сард	<p>”Байгаль орчинтой холбоотой өргөдөл, гомдол шийдвэрлэх журам” боловсруулж, батлуулсан.</p> <p>2023 онд нисэх буудлын үйл ажиллагаанаас байгаль орчинд ямар нэгэн хор хөнөөл учруулсан эсэх талаар санал, гомдол ирээгүй.</p>

				 
5.	Аэродромын хяналтын цэгээс 15 км радиус дотор мод үржүүлэг, цэцэрлэгт хүрээлэн байгуулахгүй байх эсэхэд хяналт, шаардлага тавих	1-12 сард	-	Аэродромын хяналтын цэгээс 15 км радиус дотор мод үржүүлэг, цэцэрлэгт хүрээлэн байгуулагдаагүй.
6.	Аэродромын хяналтын цэгээс 15 км радиус дотор ил задгай ус, хог хаягдал ялгаруулах болон мал нядалгааны объект байгуулахгүй байх эсэхэд хяналт, шаардлага тавих	1-12 сард	-	Аэродромын хяналтын цэгээс 15 км радиус дотор ил задгай ус, хог хаягдал ялгаруулах болон мал нядалгааны объект байгуулагдаагүй.
7.	Ундны усны зүй зохистой хэрэглэх санамж, анхааруулга, мэдээ мэдээллийг түгээх, хэрэгжүүлэх	7 сар, 10 сар	-	Байгууллагын олон нийтийн сүлжээнд усны зохистой хэрэглээний талаар видео бичлэгийг байршуулсан.

				<p>НУБИЭ ХХК нь хоногт 800м3 цэвэр усыг олборлох, бохир усыг татан зайлуулж цэвэрлэх хүчин чадал бүхий байгууламжуудын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэн явуулж байна.</p> <p>"ЗҮЙ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ ХЭВШҮҮЛЬ" уриан дор та бүхэндээ тус 2 байгууламжийн үйл ажиллагаа, цэвэр, бохир усны үйлчилгээ хэрхэн хэрэглэгчдэд хүрдэг талаархи танилцуулгыг хүргүүлж байна.</p> <p>NUBIA LLC operates plants with the capacity to extract 800m3 of pure water per day and remove and treat sewage within the framework of a special license.</p> <p>Under the motto "APPLY USE PROPERLY", we present to you a presentation about the operation of the two plants and how clean and sewage water services are delivered to consumers.</p> 
8.	Байгууллагын нийт ажилтнууд болон, байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажилладаг байгууллагуудад усны зүй зохистой хэрэглээг таниулах	7 сар, 10 сар	-	<p>НУБИЭ ХХК-ийн ажилчид болон бусад хамтран ажилладаг албан газрын төлөөлөөс ус хангамж, ариутгах татуургын сэтгэл ханамжийн судалгааг авч ажилласан. Энэхүү судалгааны зорилго нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлж цаашид үйл ажиллагаагаа сайжруулах судалгааны үр дүнд үндэслэн хэрэглэгчдийнхээ сэтгэл ханамжийг дээшлүүлж шаардлагатай мэдээллээр хангахад оршино.</p> <p>Байгууллагын нийт ажилтнуудад nubia имэйл болон уагмег дотоод сүлжээг ашиглан цэвэр усыг хэрэглэгчидэд хэрхэн хүргэдэг мөн бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх үйлчилгээг хэрхэн хүргэдэг талаархи видео хичээлийг түгээсэн.</p>

				
<p>НУБИЭ ХХК Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт нийт дүн (төг)</p>				<p>200,000₮</p>

**ЕС. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Нийт зардал (төг)	Тайлбар	Биелэлт
1.	Нисэх буудлын хэмжээнд БОМТ-ийг таниулах, мэдээлэх, хэрэгжилтийг хянаж ажиллах	-		Байгаль орчны менежментийн чиг үүргийг хэрэгжүүлж буй Нисэх буудлын Төлөвлөлтийн хэлтэс орчны хяналт шинжилгээний ажлуудыг зохион байгуулж, шинжилгээг мэргэжлийн байгуулагаар хийлгэсэн. Уг хэлтсээс БОМТ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.
2.	Сэргэлэн сумын иргэд, 4 дүгээр багийн ИНХ болон Нисэх буудлын орчны оршин суугчдад БОМТ-ийн хэрэгжилтийг тайлагнах	500,000		Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын тамгын газар, Засаг даргад БОМТ-2023 оны биелэлтийн тайланг 2024 оны 01 дүгээр сарын 22-нд танилцуулахаар бэлтгэсэн.
3.	Төв аймгийн БОАЖГазарт БОМТ-ийн хэрэгжилтийг тайлагнах	-		Компанийн удирдлагуудад болон Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын тамгын газар, Засаг даргад БОМТ-2023 оны биелэлтийн тайланг танилцуулж, зөвлөмж авсаны дараа Төв аймгийн БОАЖГазарт тайлагнаж, үнэлүүлнэ.
4.	Дараа жилийн БОМТ-ийг боловсруулах	-		2024 оны БОМТ-ийг төлөвлөж байна..
<b>Нийт зардал</b>				<b>500,000₮</b>

**АРАВ. БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗАРДАЛ**

**10.1 НУБИЭ ХХК-ийн БОМТ хэрэгжүүлсэн нийт зардал**

№	БОМТ-ний хүрээнд хийх ажлын багц	Нийт зардал (төг)	Нийт дүнд эзлэх хувь
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	164,985,899	20,4
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	301,800,000	37,3
3	Түүх соёлын өвийг хамгаалах	-	-
4	Осол эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө	35,062,300	4,3
5	Хог хаягдлын менежментийг зохион байгуулах. Ариутгал, халдваргүйжүүлэлт	255,880,008	31,6
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	51,271,156	6,3
7	Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	200,000	0,03
8	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх	500,000	0,07
<b>Нийт зардал /төг/</b>		<b>809,699,363</b>	<b>100</b>

**10.2 ИНЕГ, ИНУТ-ийн ШХА-ны БОМТ хэрэгжүүлсэн нийт зардал**

№	БОМТ-ний хүрээнд хийх ажлын багц	Нийт зардал /төг/	Нийт дүнд эзлэх хувь
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	-	-
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-	-
3	Түүх соёлын өвийг хамгаалах	-	-
4	Осол эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө	-	-
5	Хог хаягдлын менежментийг зохион байгуулах Ариутгал, халдваргүйжүүлэлт	<b>7 656 800</b>	74,4
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1 804 000	25,6
7	Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	-	-
8	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх	-	-
<b>Нийт зардал /төг/</b>		<b>9 460 800</b>	<b>100</b>

**10.3. БОМТ хэрэгжүүлсэн нийт зардал**

№	Байгууллагын нэр	Биелэлтийн зардал /төг/	Нийт /төг/
1	Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК	<b>809,699,363</b>	<b>819,160,163</b>
2	ИНЕГ, ИНУТ-ийн ЧХОУНБ дахь Шатахуун хангалтын алба	<b>9 460 800</b>	





“НУБИЭ” ХХК

Хавсралт - 1

• *Other waste shall be transported by vehicles with compactors,*
- 4.5 Гүйцэтгэгчийн ажилтнуудын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл, автомашин нь байгууллагын нэр, лого, таних тэмдэгтэй байна.  
*The Contractor's employees' labor protection clothing, tools, and cars must have the name, logo, and identification of the organization.*
- 4.6 Хог хаягдлыг энэхүү гэрээний 4.4-т заасан автомашинаар тээвэрлэх ба хог ачиж тээвэрлэх явцад асгарсан хог хаягдлыг цэвэрлэж, ариутгаж, тухайн орчны цэвэр байдлыг хангасан байна.  
*Garbage shall be transported by vehicles specified in Article 4.4 of this Contract, and waste spilled during the loading and transportation shall be cleaned and sterilized, and the environment shall be kept clean.*
- 4.7 Гүйцэтгэгч нь дахивар хог хаягдлыг хамтран ажилладаг гэрээт дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүргэж ажиллана.  
*The Contractor shall deliver the sorted waste to recycling plants.*

- 4.8 Гүйцэтгэгч нь ажилтнуудаа *Инэн ялангуяа жолооч, ачигч* Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, үйлчилгээний болон харилцааны соёл, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулсан байна.  
*Employees of Contractor (especially drivers and loaders) shall be trained in occupational safety, health, customer service, and communication skills.*
- 4.9 Гэрээнд зааснаас бусад тохиолдолд захиалагчийн эзэмшил, ашиглалт, өмчлөлийн эд зүйлийг ачиж тээвэрлэхгүй байх, хохирол учруулахгүй байх.  
*Not to load or transport the items owned, used by the Customer except as agreed in the Contract, and not to cause damage.*
- 4.10 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хог хаягдлын ангилал, хэмжээ, тус бүрээргаргаж, байгууллагын тамга тэмдэгээр баталгаажуулан сард 1 удаа Захилагчид мэйлээр болон эх хувиар нь ирүүлнэ.  
*The work implementation report of the waste management plan shall be issued for each category and amount of waste, certified by the organization's stamp, and submitted to the Customer once a month by e-mail and by original hard copy.*
- 4.11 Захиалагчаас үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах  
*Require the Customer to pay service fee within the time specified in the Contract*
- 4.12 Захиалагчаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах  
*Require the Customer to fulfill its contractual obligations*

#### ТАВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА FIVE. LIABILITIES OF PARTIES

- 5.1 Гүйцэтгэгч нь үүргээ гэрээний хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгээр тооцон хоног тутам 0,3 хувийн алдангийг Захиалагчид төлөх үүрэгтэй. Энэ нь гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.  
*If the Contractor fails to perform its contractual obligations within the contract period, it shall be obliged to pay a penalty of 0.3 percent per day to the Customer based on the amount of unperformed service fee for each day until completion of such unperformed service. This shall not be a ground for exemption from performance of contractual obligations.*
- 5.2 Захиалагч ажлын тайлан, нэхэмжлэхийг хүлээн авч, хөлсийг ажлын 5 хоногт багтаан төлөөгүй бол хугацаа хэтэрсэн өдрөөс хойш хоног тутамд 0,3 хувийн алданги тооцож, Гүйцэтгэгчид төлнө.  
*If the Customer receives the work report and invoice and does not pay the fee within 5 working days, a penalty of 0.3 percent will be charged on unpaid amount for each day after the overdue date and paid to the Contractor.*
- 5.3 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бол нөгөө тал нь гэрээг нэг талын санаачлагаар цуцалж, учирсан хохирол, зардлаа төлөхийг буруутай талаас шаардах эрхтэй.  
*If one of the Parties violates its obligations under the Contract, the other Party has the right to terminate the Contract on the initiative of one of the Parties and claim any damages and expenses caused by the violation to the defaulting Party .*

#### ЗУРГАА. ТУСЛАН ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ SIX. CONTRACTING A CONTRACTING CONTRACT

- 6.1 Гүйцэтгэгч нь Захиалагчтай урьдчилж зөвшилцсөн тохиолдолд гэрээнд заасан ажлын зарим хэсгийг гүйцэтгүүлэх зорилгоор туслан гүйцэтгэгч сонгож түүнтэй гэрээ байгуулж болно. Гэрээний нэг хувийг захиалагчид хүргүүлэх

*The Contractor may appoint subcontractor to enable the implementation of the work specified in the Contract based on the prior approval by the Customer. The Contractor shall submit the copy of the contract to the Customer.*

- 6.2 Гүйцэтгэгч нь гэрээний зарим хэсгийг гүйцэтгүүлэхээр туслан гүйцэтгэгч сонгосон тохиолдолд туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын чанар, үр дүнг Захиалагчийн өмнө бүрэн хариуцна.

*If the Contractor appoints subcontractor to perform certain parts of the Contract, the Contractor shall be fully responsible to the Customer for the quality and results of the work performed by the subcontractor.*

#### ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ SEVEN. DISPUTE RESOLUTION

- 7.1 Талууд гэрээтэй холбоотой аливаа маргааныг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

*The Parties shall seek to resolve any disputes related to the Contract in an amicable manner.*

- 7.2 Талууд тохиролцсонд хүрч эс чадсан тохиолдолд маргааныг Монгол улсын хуулийн дагуу Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

*If the Parties fail to reach a resolution, the dispute shall be resolved by a court of Mongolia in accordance with the laws of Mongolia.*

#### НАЙМ. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ NICE. FORCE MAJEURE

- 8.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

*In case of any unforeseen or force majeure event occurs during the term of this Contract that causes the Parties to fail to perform their obligations under the Contract, the Parties shall be exempted from any responsibilities specified in this Contract.*

- 8.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, онцгой нөхцөл байдлын улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

*If the Parties are unable to fulfill their obligations under the Contract due to unforeseen or force majeure event, the term of the Contract may be extended for a period equivalent to the period affected by such unforeseen or force majeure event.*

#### ЕС. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ NINE. CONTRACT TERM AND AMENDMENT

- 9.1 Энэхүү гэрээ нь 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

*This Contract is valid for 2 years from May 15, 2023 to May 15, 2025.*

- 9.2 Талууд харилцан тохиролцож албан бичгийг үндэслэн гэрээнд бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

*The Parties shall mutually agree to amend the Contract in writing based on the official letter. The amendment to this Contract shall constitute inseparable part of this Contract.*

- 9.3 Хүндэтгэн үзэх шалтгаанаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах санал гаргасан тал 30 хоногийн өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.


*The Party proposing early termination of the Contract due to valid reasons shall notify the other Party in writing 30 days in advance.*


АРАВ. БУСАД ЗААЛТ  
TEN. OTHER PROVISIONS

- 10.1 Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж, талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.  
*Amendments to the Contract shall enter into force only in writing and signed by the Parties.*
- 10.2 Гэрээний дагуу хийгдэх ажил, хамтын ажиллагааны зохион байгуулалт, гэрээний хэрэгжилтийг хангах чиглэлээр гарах аливаа мэдэгдэл, хүсэлт, зөвшөөрөл болон бусад баримт бичгийн боловсруулалтыг талуудаас томилогдсон дараах ажилтнууд хариуцна.  
*The following personnel appointed by the Parties shall be responsible for the preparation of any notifications, requests, approvals and other documents arising in connection with the work to be performed under the Contract, the organization of cooperation and the implementation of the Contract.*

<p>"Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК-ийг төлөөлж: Худалдан авалтын хэлтсийн мэргэжилтэн Д.Шийлэгцэрэн Утас: +976-9901639 Хаяг: Төв аймаг, Сэргэлэн сум, 4-р баг, Эрдэнэ-Уул /41090/ И-мэйл: shiilegtseren.d@nubia-llc.mn On behalf of the "New Ulaanbaatar International Airport" LLC: D. Shiilegtseren, Officer, Planning and Coordination Department, Procurement Service Division Phone: +71287425 Address: Tuv aimag, Sergelen soum, 4th bag, Erdene-Uul / 41090 / Төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Э.Барсболд Утас: 88087180 И-мэйл хаяг: barsbold.e@nubia-llc.mn Officer of Airport Planning Division E.Barsbold Phone: 88087180 Email address: barsbold.e@nubia-llc.mn</p>	<p>"Элемент Медикал" ХХК -ийг төлөөлж: Ерөнхий нягтлан Б.Загир Утас: 88813554 General Accountant B.Zagir Phone: 80410044 И-мэйл: medicalsankhuu@gmail.com Утас: Санал гомдлын утас: 75050044, 99099944, 88057656 Дуудлагын утас: 75050044, 88057656 Хаяг: СХД, 36-р хороо, 6-69 И-мэйл хаяг: elementmedical44@gmail.com Representing "Element Medical" LLC: Phone: Complaint phone: 75050044, 99099944, 88057656 call phone 75050044, 88057656 Address: Songinokhairkhan district, 36th khoroo, 6-69 E-mail address: info@emedical.mn</p>
--	---

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:  
*Contract made by and between:*

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн Гүйцэтгэх захирал  
REPRESENTATING THE CUSTOMER:  
"New Ulaanbaatar International Airport" LLC CEO  
  
КИТАНАКА ТАКЭФУМИ  
TAKEFUMI KITANAKA

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
"Элемент Медикал" ХХК-ийн Гүйцэтгэх захирал  
REPRESENTING THE CONTRACTOR:  
Element Medical LLC  
CEO  
  
П.ПҮРЭВСҮРЭН  
PUREVSUREN.P

**Үйлчилгээний төлбөрийн жагсаалт**  
**List of Service Fee**

№	Энгийн хог хаягдал <i>Waste management</i>	<i>Element medical LLC</i>		
		Давтамж /1сар/ <i>Frequency (Monthly)</i>	Нэг удаагийн тээвэрлэх үнэ <i>Unit price /per 1 time/</i>	Нэг сард тээвэрлэх үнэ <i>Total price /per 1 monthly/</i>
1	Ангилагдахгүй хог хаягдал <i>Not categorized waste</i>	12	328,900	3,946,800
2	Дахивар хог <i>Recyclable waste</i>	8	140,415	1,123,320
3	Хүнсний хог хаягдал <i>Food waste</i>	30	140,415	4,212,450
4	Техникийн шингэн, ашигласан тос, масло, сэлбэг <i>Used oils, lubricants and spare</i>	1	321,310	321,310
<i>Total price /per 1 monthly/ VAT included</i>				9,603,880

Төвлөрсөн хогийн цэг / Waste integrated bin

Ангилал, тээвэрлэх хуваарь/ Scheduling and transporting	Захирааны барилга/ ЗУБ Admin building	Аэродромын ЗУ-ний барилга Aerodrome building	Цахилгаан дэд өртөө Main sub station	Керго терминал Cargo terminal	Цэвэр усны байгууламж Water treatment	Дулаан зогсоол Heated garage	Цэвэрлэх байгууламж Treatment plant	Дулааны станц Heating plant
Ангилагдахгүй Хог хаягдал not categorized waste	Даваа, Пүрэв, Бямба Mon, Thu, Sun	Даваа, Пүрэв, Бямба Mon, Thu, Sun	Даваа, Пүрэв, Бямба Mon, Thu, Sun	Даваа, Пүрэв, Бямба Mon, Thu, Sun	Даваа, Пүрэв, Бямба Mon, Thu, Sun	Даваа, Пүрэв, Бямба Mon, Thu, Sun	Даваа, Пүрэв, Бямба Mon, Thu, Sun	
Дахивар Recycle	Даваа, Мянгар Mon, Thu	Даваа, Мянгар Mon, Thu	Даваа, Мянгар Mon, Thu	Даваа, Мянгар Mon, Thu	Даваа, Мянгар Mon, Thu	Даваа, Мянгар Mon, Thu	Даваа, Мянгар Mon, Thu	
Хүнсний хог хаягдал Food waste	Өдөр бүр Every day							
Тос масло, сэлбэг Used oil, spare	Дуудлагаар On demand							



"ЭЛЕМЕНТ МЕДИКАЛ" ХХК

## НУБИЭ-Н ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

2023/12 сар

“Элемент медикал” ХХК нь 2023 оны 12 сарын 01 өдрөөс 2023 оны 12 сарын 25-ны өдрийг дуустал НУБИЭ-н барилга байгууламжаас ахуйн болон хоол хүнсний хог хаяг хаягдал тээвэрлэх, Хог хаягдлын түр хадгалах цэгүүдэд ариутгал халдваргүйтгэлийг 1 удаа хийсэн.

Нийт 28 удаагийн татан авалтаар 92,910 кг хог хаягдал тээвэрлэсэн. Үүнд:

- Хүнсний хог хаягдал – 30,292 кг
- Ангилагдахгүй хог хаягдал /бусад/- 49,073 кг
- Дахивар хог хаягдал - 13,544 кг
- Ашигласан моторын тос – 0 тн
- Техникийн сэлбэг, тосны сав – 1,200кг

**НУБИЭ ХХК-н барилга байгууламжаас тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээ**

Огноо	Хог хаягдлын нэр төрөл				
	Хүнсний хог хаягдал /кг/	Ангилагдахгүй хог хаягдал /кг/	Дахивар хог хаягдал	Техникийн үйлчилгээнээс гарсан хог хаягдал /кг/	Тухайн өдрийн нийт хэмжээ/кг/
1	1,277.5	1,825.0	547.5		3,650.0
2	1,253.0	1,790.0	537.0		3,580.0
3	1,186.5	1,695.0	508.5		3,390.0
4	1,155.0	1,650.0	495.0		3,250.0
5	1,183.0	1,690.0	507.0		3,380.0
6	1,256.5	1,795.0	538.5		3,590.0
7	1,277.5	1,825.0	547.5		3,650.0
8	1,207.5	1,725.0	517.5		3,450.0
9	1,141.0	1,630.0	489.0		3,260.0
10	1,218.0	1,740.0	522.0		3,480.0
11	1,186.5	1,695.0	508.5		3,390.0
12	1,172.5	1,675.0	502.5		3,350.0
13	1,168.2	4,543.0	778.8		6,490.0
14	1,309.0	1,870.0	561.0		3,740.0



"ЭЛЕМЕНТ МЕДИКАЛ" ХХК

Нью-Улаанбаатар Иньернейшн Эйрпорт ХХК-н  
Барилга байгууламжаас хог хаягдал тээвэрлэсэн  
тайлан

15	1,239.0	1,770.0	531.0		3,540.0
16	1,242.5	1,775.0	532.5		3,550.0
17	1,176.0	1,680.0	504.0		3,360.0
18	1,260.0	1,800.0	540.0		3,600.0
19	1,246.0	1,780.0	534.0		3,560.0
20	1,188.0	4,620.0	792.0		6,600.0
21	1,155.0	1,650.0	495.0		3,300.0
22	1,246.0	1,780.0	534.0		3,560.0
23	1,186.5	1,695.0	508.5		3,390.0
24	1,190.0	1,700.0	510.0		3,400.0
25	1,172.0	1,675.0	503.0	1,200.0	4,550.0
26					
27					
28					
29					
30					
31					
<b>12-р сарын нийт хэмжээ/кг /</b>	<b>30,292.7</b>	<b>49,073.0</b>	<b>13,544.3</b>	<b>1,200.0</b>	<b>92,910.0</b>

2023 ОНЫ 12 САР



The image shows a large, mostly blank table with a grid structure, possibly a ledger or inventory sheet. The table has several columns and rows, but the content is very faint and illegible. There are some faint lines and text visible, but they do not form a readable table.

2023 ОНЫ 12 САР

### 1. Ариутгал халдваргүйтгэл 2023/12/13

**Зорилго:** Төрөл бүрийн хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.

**Зорилт:**

- ✓ Халдварт өвчин түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдал цуглуулах цэгт ариутгал халдваргүйжүүлэлт хийх.

**Заавар:**

- ✓ Халдваргүйжүүлэлтийн бодисыг цэвэр саванд зааврын дагуу найруулна.
- ✓ Уусмалын үлдэгдэл дээр шинээр уусмал нэмж найруулахыг хориглоно;

Халдваргүйжүүлэх зүйлийн нэр	Халдваргүйжүүлэх аргачлал	Халдваргүйжүүлэх бодисын нэр	Халдваргүйжүүлэх бодисын үйлчлэх хугацаа	Зарцуулах хэмжээ
Хог хаягдлын цэгийн халдваргүйжүүлэлт	--Шурших (Агаарт мананцартуулан шурших)	0.03%-ийн жавелион 0.06%-ийн жавелион	1-2 цаг	-1м <sup>2</sup> талбайд 100 мл байхаар тооцож шуршина. -1м <sup>2</sup> талбайд 500 мл байхаар тооцож шуршина

#### Жавелионыг халдваргүйтгэлд хэрэглэх:


- Жавелион нь шахмал хэлбэртэй савлагдсан байх ба гол үйлчилгээ үзүүлэгч бодис нь натрийн давс, дихлорцианурийн хүчил. Шахмал нь усанд сайн уусдаг бөгөөд уусмал нь тунгалаг, бага зэрэг хлорлог үнэртэй байна.
- Жавелионы ажлын уусмалыг дараах хэмжээгээр бэлтгэнэ.

№	Уусмалд агуулагдаж буй идэвхтэй хлорын хэмжээ	10 литр усанд орох шахмалын тоо
1.	0.015	1
2.	0.03	2
3.	0.06	4
4.	0.1	7
5.	0.2	14
6.	0.3	20


- Жавелионыг паалантай, шилэн эсвэл хуванцар саванд найруулж бэлтгэнэ.

Тухайн байгууламжийн бүх хог хаягдал түр хадгалах цэгүүдэд ариутгал халдваргүйжүүлэлт хийснээр халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх юм. Хог хаягдал цугларч байгаа хэсэгт, гадаргуу болон хүрээлэн буй орчны эмгэг төрүүлэгч бичил биетийг устгах буюу багасгахад ариутгал халдваргүйтгэл хийгдэх шаардлагатай. Хог хаягдлын цэгт, ариутгалын бодис болох жавелионыг 0.06%-ийн процентоор найруулан, агаарт шүрших болон мананцар үүсгэн ариутгал халдваргүйтгэл хийгдсэн.









2023 ОНЫ 12 САР



---

2023 ОНЫ 12 САР



2023 ОНЫ 12 САР

## 2. Нэмэлт татан авалт

2023 оны 12 сарын 13 нд каргоны хог хаягдал багтаагүй тул нэмэлт татан авалт хийсэн.



2023 ОНЫ 12 САР

2023 оны 12 сарын 20-нд каргоны хог хаягдал багтаагүй тул нэмэлт татан авалт хийсэн.





"ЭЛЕМЕНТ МЕДИКАЛ" ХХК

Нью-Улаанбаатар Иньернейшн Эйрпордт ХХК-н  
Барилга байгууламжаас хог хаягдал тээвэрлэсэн  
тайлан


**2023 оны 12 сарын 25 өдөр техникийн үйлчилгээнээс гарсан ашигласан агаар шүүтч болон хаягдал дугуй бусад ангилагдахгүй хог хаягдал, Дуудлагаар тээвэрлэсэн.**



---

2023 ОНЫ 12 САР

**3. 2023 оны 12 сарын 01 өдрөөс 2023 оны 12 сарын 27-ны өдрийн  
хооронд тээвэрлэсэн хог хаягдлын түүвэр зураг**



2023 ОНЫ 12 САР



2023 ОНЫ 12 САР



2023 ОНЫ 12 САР

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**  
**SERVICE CONTRACT**

2023 оны 05 сарын 31 өдөр  
Date: ... 31.05... 2023

№ 151/23

Төв аймаг  
Tuv aimag

Нэг талаас "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК (РД:3874095) (цаашид Захиалагч гэх)-ийг төлөөлөн Гүйцэтгэх захирал Китанака Такэфуми, нөгөө талаас "Төв аймгийн Хот тохижуулах газар" РД:9061231 (цаашид Гүйцэтгэгч гэх)-ийг төлөөлөн Хот тохижуулах газрын дарга А.Шаравнямбуу нар (цаашид хамтад нь талууд гэх) Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

*This Service Contract (the "Contract") is made by and between: New Ulaanbaatar International Airport LLC with its registration number 3874095 represented by Takefumi Kitanaka, Chief Executive Officer (hereinafter referred to as the Customer), and Department of Urban Development of Tuv province with its registration number 9061231 represented by Sharavnyambu. A, Head of Department of Urban Development (hereinafter referred to as the), (hereinafter referred to each as the "Party" and together as the "Parties") in accordance with Clause 343-358 of Civil Code of Mongolia and Laws on Waste.*

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**  
**GENERAL PROVISIONS**

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Ажил гүйцэтгэгч нь дулааны станцын "Үнс" тээвэрлэх ажлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байхаар тээвэрлэлтийг зохион байгуулах ажлыг (хавсралт-1)-д заасны дагуу хийж гүйцэтгэнэ.  
*The purpose of this Contract is that the Contractor shall transport the heating plant "ashes" in accordance with (Appendix-1) without causing any adverse impact to the environment.*
- 1.2 "Гүйцэтгэгч" нь "Үнс" тээвэрлэх ажлыг гэрээний хугацаанд ачиж тээвэрлэх "Захиалагч" тал нь гэрээний үүргийн биелэлтийн дагуу гүйцэтгэлийг үнэлж төлбөр тооцоог төлөх үйл ажиллагааг зохицуулахад оршино.  
*The Contractor is responsible for carrying out the transportation of "ashes" during the contract period, and the Customer is responsible for evaluating the performance and paying the service fee according to the fulfillment of the contractual obligations.*
- 1.3 Энэхүү гэрээний хавсралт-1 нь гэрээний салшгүй хэсэг байна.  
*Annex-1 to this Contract shall form an integral part of this Contract.*

**ХОЁР. ТӨЛБӨР ТООЦОО**  
**TWO. Payment of the Contract**

- 2.1 Захиалагчийн зүгээс төлбөр тооцоог гүйцэтгэлээр гэрээний хавсралтад заасан үнээр тооцож гүйцэтгэгчээс ирүүлсэн тайлан нэхэмжлэхийн эх хувийг үндэслэл болгон төлнө.  
*The Customer shall pay the work fee based on the invoice submitted by the Contractor in accordance with the performance specified in the Appendix-1 to the Contract. / List of Work Fee/.*
- 2.2 Гүйцэтгэгч нь тухайн сарын ажлын гүйцэтгэлийн тайлан, нэхэмжлэхийг дараа сарын ажлын 5 хоногт багтаан ирүүлнэ. Захиалагч ажлын гүйцэтгэлийн тайлантай танилцаж, баталгаажуулснаар Гүйцэтгэгчид ажлын хөлсийг ажлын 5 хоногийн дотор нэхэмжлэхийн эх хувийг үндэслэн төлнө.



#### ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

#### FOUR. RIGHTS AND OBLIGATIONS OF THE CONTRACTOR

- 4.1 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт, ажилтнуудын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг ханган ажиллах бөгөөд, түүнийг баримтлаагүйгээс үүссэн аливаа хохирлыг гүйцэтгэгч бүрэн хариуцна.  
*To ensure the compliance of the Law on Traffic Safety, Traffic Rules, Law on Labor Safety, legal regulations, Labor protection and all damages caused by violations of these laws/regulations by the Contractor shall be borne by the Contractor.*
- 4.2 Ажил гүйцэтгэхийн өмнө Гүйцэтгэгчийн Ажилтнуудад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг заавал өгнө.  
*Occupational safety instructions must be provided to employees of the Contractor before implementation of the work.*
- 4.3 Хог хаягдлын үйлчилгээнд байгууллагын нэр, лого, таних тэмдэг, хариуцсан нутаг дэвсгэрийн мэдээлэл бүхий хог тээврийн автомашин, техникийг ашиглана.  
*Garbage trucks and equipment with the organization's name, logo, identification mark, and area of responsibility shall be used for waste service.*
- 4.4 Үнсийг зориулалтын тээврийн хэрэгсэлээр ачиж тээвэрлэх ба машины тэвш өндөрлөгөөтэй, унаж асгахаас сэргийлсэн бүтээлэгтэй байх ба үнс ачиж тээвэрлэх явцад асгарсан үнсийг цэвэрлэж, тухайн орчны цэвэр байдлыг хангасан байна.  
*The ash shall be loaded and transported by special purpose vehicles, and the vehicle body shall be high, covered with a blanket to prevent spillage, and the area to be cleaned and disinfected during the transportation of ash.*
- 4.5 Гүйцэтгэгчийн ажилчдыг *Инэн ялангуяа жолооч, ачигч* Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, үйлчилгээний болон харилцааны соёл, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулна.  
*Employees of Contractor (especially drivers and loaders) shall be trained in occupational safety, health, service, and communication skills.*
- 4.6 Гэрээнд зааснаас бусад тохиолдолд захиалагчийн эзэмшил, ашиглалт, өмчлөлийн эд зүйлийг ачиж тээвэрлэхгүй байх, хохирол учруулахгүй байх.  
*Not to load or transport the items owned, used by the Customer except as agreed in the Contract, and not to cause damage.*
- 4.7 Захиалагчаас Ажлын хөслыг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах  
*Require the Customer to pay Work fee within the time specified in the Contract*
- 4.8 Захиалагчаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах  
*Require the Customer to fulfill its contractual obligations*

#### ТАВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

#### FIVE. LIABILITIES OF PARTIES

- 5.1 Гүйцэтгэгч нь үүргээ гэрээний хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгээр тооцон хоног тутам 0,3 хувийн алдангийг Захиалагчид төлөх үүрэгтэй. Энэ нь гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.  
*If the Contractor fails to perform its contractual obligations within the contract period, it shall be obliged to pay a penalty of 0.3 percent per day to the Customer based on the amount of unperformed Work fee for each day until completion of such unperformed work. This shall not be a ground for exemption from performance of contractual obligations.*

- 5.2 Захиалагч Ажлын үр дүнг хүлээн авч, хөлсийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,3 хувийн алданги тооцож, Гүйцэтгэгчид төлнө.  
*If the Customer fails to pay Work fee on time, a penalty of 0.3 percent shall be paid to the Contractor for each day of delay on unpaid work fee.*
- 5.3 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бол нөгөө тал нь гэрээг нэг талын санаачлагаар цуцалж, учирсан хохирол, зардлаа төлөхийг буруутай талаас шаардах эрхтэй.  
*If one of the Parties violates its obligations under the Contract, the other Party has the right to terminate the Contract on the initiative of one of the Parties and claim any damages and expenses caused by the violation to the defaulting Party .*

#### ЗУРГАА. ТУСЛАН ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ SIX. APPOINTMENT OF SUBCONTRACTOR

- 6.1 Гүйцэтгэгч нь Захиалагчтай урьдчилж зөвшилцсөн тохиолдолд гэрээнд заасан ажлын зарим хэсгийг гүйцэтгүүлэх зорилгоор туслан гүйцэтгэгч сонгож түүнтэй гэрээ байгуулж болно. Гэрээний нэг хувийг захиалагчид хүргүүлэх  
*The Contractor, in consultation with the Customer, may appoint subcontractor to enable the implementation of the work specified in the Contract . The Contractor shall submit the copy of the contract to the Customer*
- 6.2 Гүйцэтгэгч нь гэрээний зарим хэсгийг гүйцэтгүүлэхээр туслан гүйцэтгэгч сонгосон тохиолдолд туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын чанар, үр дүнг Захиалагчийн өмнө бүрэн хариуцна.  
*If the Contractor appoints subcontractor to perform certain parts of the Contract, the Contractor shall be fully responsible to the Customer for the quality and results of the work performed by the subcontractor.*

#### ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ SEVEN. DISPUTE RESOLUTION

- 7.1 Талууд гэрээтэй холбоотой аливаа маргааныг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.  
*The Parties shall seek to resolve any disputes related to the Contract in an amicable manner.*
- 7.2 Талууд тохиролцоонд хүрч эс чадсан тохиолдолд маргааныг Монгол улсын хуулийн дагуу Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.  
*If the Parties fail to reach a resolution, the dispute shall be resolved by a court of Mongolia in accordance with the laws of Mongolia.*

#### НАЙМ. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ NICE. FORCE MAJEURE

- 8.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги/ чөлөөлөгдөх үндэслэл болно.  
*In case of any unforeseen or force majeure event occurs during the term of this Contract that causes the Parties to fail to perform their obligations under the Contract, te Parties shall be exempted from any responsibilities specified in this Contract.*
- 8.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, онцгой нөхцөл байдлын улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

*If the Parties are unable to fulfill their obligations under the Contract due to unforeseen or force majeure event, the term of the Contract may be extended for a period equivalent to the period affected by such unforeseen or force majeure event. .*

ЕС. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ  
NINE. CONTRACT TERM AND AMENDMENT

- 9.1 Энэхүү гэрээ нь 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.  
*This Contract shall retroactively effective from May 15, 2023 and valid until May 15, 2025.*
- 9.2 Талууд харилцан тохиролцож албан бичгийг үндэслэн гэрээнд бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.  
*The Parties shall mutually agree to amend the Contract in writing based on the official letter. The amendment to this Contract shall constitute inseparable part of this Contract.*
- 9.3 Хүндэтгэн үзэх шалтгаанаар Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах санал гаргасан тал 30 хоногийн өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.  
*The Party proposing early termination of the Contract due to valid reasons shall notify the other Party in writing 30 days in advance.*

АРАВ. БУСАД ЗААЛТ  
TEN. OTHER PROVISIONS

- 10.1 Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж, талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.  
*Amendments to the Contract shall enter into force only in writing and signed by the Parties.*
- 10.2 Гэрээний дагуу хийгдэх ажил, хамтын ажиллагааны зохион байгуулалт, гэрээний хэрэгжилтийг хангах чиглэлээр гарах аливаа мэдэгдэл, хүсэлт, зөвшөөрөл болон бусад баримт бичгийн боловсруулалтыг талуудаас томилогдсон дараах ажилтнууд хариуцна.  
*The following personnel appointed by the Parties shall be responsible for the preparation of any notifications, requests, approvals and other documents arising in connection with the work to be performed under the Contract, the organization of cooperation and the implementation of the Contract.*

<p>"Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК-ийг төлөөлж: Худалдан авалтын хэлтсийн мэргэжилтэн Д. Шийлэгцэрэн Утас: +976-9901639 Хаяг: Төв аймаг, Сэргэлэн сум, 4-р баг, Эрдэнэ-Уул /41090/ И-мэйл: shiilegtseren.d@nubia-llc.mn</p> <p>On behalf of the "New Ulaanbaatar International Airport" LLC: D. Shiilegtseren, Officer, Planning and Coordination Department, Procurement Service Division Phone: +71287425</p>	<p>"Төв аймгийн Хот тохижуулах газар"-ыг төлөөлж: Б.Мөнхзаяа Утас: Санал гомдлын утас: 88084936 Дуудлагын утас: 70272562 Хаяг: Төв аймаг Зуунмод сум И-мэйл хаяг: HTGazar@gmail.com, zayaa98@yahoo.com On behalf of Department of Urban Development of Tuv province: Munkhzaya.B:</p>
---	---

Address: Tuv aimag, Sergelen soum, 4th bag,  
Erdene-Uul / 41090 /

Төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Э.Барсболд  
Утас: 88087180

И-мэйл хаяг: barsbold.e@nubia-llc.mn  
Officer of Airport Planning Division E.Barsbold

Phone: 88087180

Email address: barsbold.e@nubia-llc.mn

Phone: Complaint phone:  
88084936

call phone: 70272562,

Address: Zuunmod soum Tuv  
province

E-mail address:

HTGazar@gmail.com,  
zayaa98@yahoo.com

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**Contract made by and between:**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**


"Нью Улаанбаатар Интернэйшнл

Эйрпорт" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

REPRESENTATING THE CUSTOMER:

"New Ulaanbaatar International Airport"

LLC CEO

  
КИТАНАКА ТАКЭФУМИ  
TAKEFUMI KITANA

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"Төв аймгийн Хот тохижуулах газрын" дарга

REPRESENTING THE CONTRACTOR:

Head of Department of Urban

Development of Tuv province

  
А.ШАРАВНЯМБУУ  
SHARAVNYAMBUU.A

Үйлчилгээний төлбөрийн жагсаалт  
List of Service Fee

15/23

№	Энгийн хог хаягдал Waste management	Давтамж /1сар/ Frequency (Monthly)	TUV province	
			Нэг удаагийн тээвэрлэх үнэ Unit price /per 1 time/	Нэг сард тээвэрлэх үнэ Total price /per 1 monthly/
5	Үнс тээвэрлэх Ash	15	216,000	3,240,000
Total price /per 1 monthly/				3,240,000

\*1m<sup>3</sup> transportation price is 12,000mnt, 18 m<sup>3</sup> is per 1 time transportation .

1m<sup>3</sup> Үнсийг 12,000 төгрөгөөр ачиж тээвэрлэнэ. 1 Удаа тээвэрлэхэд 18m<sup>3</sup> үнс тээвэрлэнэ .

Ангилал, тээвэрлэх хуваарь/ Scheduling and transporting	Төвлөрсөн хогийн цэг / Waste integrated bin
	Дулааны станц Heating plant
Үнс /ash	Дуудлагаар /on demand

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**  
**WORK PERFORMANCE CONTRACT**

2023 оны 05 сарын 31 өдөр  
Date: ... 31.../05... 2023

№ 150/23

Төв аймаг  
Tuv aimag

**Нэг. Нийтлэг үндэслэл**  
**One. General Provisions**

- 1.1 Энэхүү Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, халдваргүйжүүлэх, устгах, шатаах, ландфиллдэх ажил гүйцэтгэх гэрээ (цаашид "Гэрээ" гэх-г) нэг талаас (РД:2100061) "Элемент" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх)-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Баярсайхан;

нөгөө талаас "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК (цаашид "Захиалагч" гэх) (РД:3874095)-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Китанака Такэфуми нар харилцан тохиролцож Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, "Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар" болон Эрүүл мэндийн сайдын /цаашид ЭМС/А/505 тоот тушаал, ЭМС-ын 605 тоот тушаал, байгаль орчны холбогдох хууль, дүрэм журмыг үндэслэн гэрээг байгуулав.

*This contract for transportation of hazardous waste, disinfection, disposal, incineration, and landfilling work (hereinafter referred to as "Contract") was made by and between: B.Bayarsaikhan, Chief Executive Officer, representing "Element" LLC (RD:2100061) (hereinafter referred to as "Contractor"); and*

*Kitanaka Takefumi, Chief Executive Officer, representing "New Ulaanbaatar International Airport" LLC (RD: 3874095) (hereinafter referred to as the "Client")*

*(hereinafter collectively referred to as the "Parties" and separately as "Party") upon mutual agreement of the Parties with terms and conditions set forth below based on the Civil Code of Mongolia, Waste Law, "Guidelines for Classification, Collection, Storage, Transportation, Processing and Disposal of Medical Waste" and Minister of health Orders No. A/505 and 605 and relevant environmental laws and regulations,*

- 1.2 Гэрээний зорилго нь Гүйцэтгэгч нь аюултай болон эрсдэлтэй хог хаягдал, лагийг Гэрээний Хавсралт-1-д заасан үнэ, давтамжийн дагуу ачиж тээвэрлэх, халдваргүйжүүлж устгах (цаашид "Ажил" гэх), Захиалагч нь Гэрээний хугацаанд Ажлын хөлс төлөх, Ажлын үр дүнг хүлээн авах, Талууд хоорондын ажлын уялдааг сайжруулах, Талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тогтооход оршино.

*The purpose of this Contract is to specify the scope of work to be implemented by the Contractor such as transportation, disinfection and disposing of hazardous wastes and sludge (hereinafter referred as "Works"), to specify payment conditions during the term of the Contract specified in the Appendix 1, to specify the procedure of receiving Work result and to improve coordination between the Parties and determine the rights, obligations and responsibilities of the Parties.*

**Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг**

## Two. Rights and obligations of the Client

Захиалагч нь дараах эрх, үүрэгтэй:

*The Client shall have following rights and obligations:*

- 2.1 Гэрээний дагуу Гүйцэтгэгчээс Ажлын үр дүнг шаардаж авах эрхтэй;  
*Have the right to demand the Works results specified in the Contract;*
- 2.2 Гүйцэтгэгчээс Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй;  
*The Client shall have the right to demand to fulfill its contractual obligations from the Contractor;*
- 2.3 Гүйцэтгэгч нь аюултай хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх, аюулгүй болгох зааварчилгааг зөрчсөн тохиолдолд Захиалагч шаардлага тавих эрхтэй;  
*The Client shall have the right to demand in case of breaches of the instructions on collection, transportation and safe disposal of hazardous waste by the Contractor;*
- 2.4 Гэрээний дагуу хог хаягдлаа хугацаанд нь ачаагүй, ариутгал, устгалыг хийгээгүй зэрэг зөрчил илэрсэн тохиолдолд, зөрчлийг арилгуулах хугацаатай шаардлага тавих, шаардлагыг биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй;  
*In case of non-compliance according to the Contract by the Contractor, such as untimely loading, disinfection or disposal of waste, shall have the right to demand elimination of the violation and demand compliance with the requirements based on given term notice submitted to the Contractor;*
- 2.5 Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, ариутгах, устгах үйл ажиллагааны тайланг сард 1 (нэг) удаа болон жилийн эцэст Гүйцэтгэгчээс шаардаж авах эрхтэй;  
*Have right to request operation report of hazardous waste transportation, disinfection, and disposal once (1) a month and on a yearly basis;*
- 2.6 Гэрээний Хавсралт 2-т заасан Аюултай хог хаягдлыг тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн маягт ажилласан цаг, рейсийг бичиж, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулах эрхтэй;  
*The right to write, sign and stamp the hours and route of the waste transportation specified in the Appendix 2 "Form of delivery of hazardous waste to the Contractor" to the Contract;*
- 2.7. Хог хаягдал тээвэрлэж устгасны хөлсийг Гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэгтэй;  
*Obligated to pay for waste transportation and disposal within the term specified in the Contract;*
- 2.8. Хог хаягдал ачиж тээвэрлэх захиалга өгсөн үед Захиалагч томилсон ажилтнаа байгууламж дээрээ байлцуулж, хог ачилтад хяналт тавих үүрэгтэй;  
*The Client shall be responsible for the presence of its contact points at the facility to monitor waste collection;*
- 2.9. Аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг хариуцах нэгжээс нэг цэгт цуглуулан, зориулалтын байранд хадгалан хүлээлгэн өгөх үүрэгтэй;  
*Obligated to handover the hazardous and hazardous waste from relevant unit and store it in a designated place;*
- 2.10. Гүйцэтгэгчийн устгал хийх явцтай танилцаж, хяналт тавих эрхтэй;  
*Right to get familiarized of the Contractor's disposal process and monitoring;*

- 2.11. Гүйцэтгэгчийн цуглуулсан/тээвэрлэсэн хог хаягдлыг хүлээлгэж өгөхдөө хэмжээг бодитоор хэмжих, хяналт тавих үүрэгтэй;  
*Obligated to monitor for measuring of the amount of waste collected/transported by the Contractor;*
- 2.12. Захиалагч тусгай устгалын комисстой устгал хийлгэх хүсэлт гаргахдаа ажлын 3 (гурав) хоногийн өмнө Гүйцэтгэгчид мэдэгдэх үүрэгтэй;  
*The Client shall notify the Contractor three (3) business days in advance of the disposal plan with the special disposal commission.*

### **Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг** **Three. Rights and obligations of the Contractor**

Гүйцэтгэгч нь дараах эрх, үүрэгтэй:

*The Contractor shall have following rights and obligations:*

- 3.1. Захиалагчаас Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,  
*The Contractor shall have the right to demand fulfillment of its contractual obligations from the Client;*
- 3.2. Хог хаягдал тээвэрлэсний хөлсийг Гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй;  
*The right to demand payment for waste transportation within the period specified in the Contract from the Client;*
- 3.3. Ачиж тээвэрлүүлэх хог хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой байхыг шаардах эрхтэй;  
*The right to demand the Client that the waste to be transported be specially packed;*
- 3.4. Гэрээний дагуу хог хаягдлаа ачуулаагүй, хог шатаасан, бусад тээврийн хэрэгсэлд дайж явуулсан, ЭМС-ын А/505 тоот тушаалуудыг биелүүлээгүй зөрчсөн, зөрчлийг арилгуулахаар тус тус шаардлага тавьж биелүүлээгүй тохиолдолд хог хаягдлыг татан авахгүй байх эрхтэй;  
*The right not to collect waste in case of non-shipment of waste, incineration of waste, evasion of other vehicles, non-compliance with Minister Order No. A/505, failure to comply with the requirements to eliminate the violation;*
- 3.5. Хог хаягдал ачиж тээвэрлэх, тээврийн хэрэгслийг ажилд бэлэн байлгаж, Захиалагчийн хог хаягдлыг Гэрээний хугацаанд саадгүй тээвэрлэх үүрэгтэй;  
*Obligated to load and transport waste, keeping the vehicle ready for work, and transporting the Client 's waste without hindrance during the term specified in the Contract;*
- 3.6. Эмнэлгийн хог хаягдлыг зориулалтын устгалын төвд аваачиж устгах, аюулгүй болгох үүрэгтэй;  
*Obligated to dispose of medical waste at designated disposal centers.*
- 3.7. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас тээвэрлэлт саатсан, хог хаягдал ихээр хуримтлагдсан, эмгэг хог хаягдал ихээр гарсан тохиолдолд Гэрээний хуваарьт зааснаас бусад хугацаанд нэмэгдэл хүч гарган тээвэрлэж, халдваргүйжүүлж устгах үүрэгтэй;

*In the event of delays in transportation, accumulation of waste, or large amounts of hazardous waste due to the Contractor's misconduct, the Contractor shall be obliged to transport, disinfect and dispose of additional waste any time other than those specified in the Contract;*

- 3.8. Гүйцэтгэгчийн байгууллагад онцгой нөхцөл байдлын улмаас ажиллах тохиолдолд Гэрээнд заасны дагуу үүргээ биелүүлэх үүрэгтэй.

*In the event of an emergency situation in the Contractor's organization it shall be obliged to fulfill his/her duties in accordance with the Contract.*

- 3.9. Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, устгах, шатаах үйл ажиллагааны тайланг Захиалагчид сард 1 (нэг) удаа болон Гэрээний хугацаа дуусахаас ажлын тав (5) хоногийн өмнө Гэрээ дүгнэсэн актаар баталгаажуулах үүрэгтэй;

*Obligated to submit reports on hazardous waste transportation, collection, disposal, and incineration once a month (1) and prior five (5) business days before expiration of this Contract to conclude a Contract completion act.*

#### **Дөрөв. Ажлын хөлс Four. Contract Amount**

- 4.1 Захиалагчийн зүгээс төлбөр тооцоог гүйцэтгэгчийн тээвэрлэсэн хог хаягдлын бодит тоо хэмжээгээр Гэрээний Хавсралт 1-д заасан үнээр тооцож Гүйцэтгэгчээс ирүүлсэн тайлан нэхэмжлэхийн эх хувийг үндэслэж төлнө. Энэхүү дүнд НӨАТ болон бусад зардал багтсан.

*The Client shall pay the fee based on the original copy of the invoice submitted by the Contractor at the price specified in the Appendix 1 to the Contract and actual quantity of waste transported by the Contractor. This fee for transportation of waste includes VAT and other expenses*

- 4.2 Гүйцэтгэгч нь дараа сарын эхний долоо (7) хоногт эх хувиар нэхэмжлэхийг Захиалагчид хүргүүлж, Захиалагч нь ажлын тав (5) хоногт багтаан Гэрээний 4.5-д заасан Гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ.

*The Contractor shall submit invoice in original copy within seven (7<sup>th</sup>) day of the following month to the Client, and Client shall transfer the monthly fee to the Contractor account specified in the Article 4.5 of the Contract within five (5) business days.*

- 4.3 Захиалагч нь зөвхөн гүйцэтгэсэн ажлын хөлсийг Гүйцэтгэгчид төлөх үүрэгтэй.

*The Client shall pay the Contractor only for the work performed.*

- 4.4 Захиалагч Гэрээнд тусгагдаагүй нэмэлт захиалгыг Гүйцэтгэгчид өгөх тохиолдолд ажлын хөлсийг Гүйцэтгэгчээс эх хувиар ирүүлсэн нэхэмжлэлийг үндэслэн гүйцэтгэлээр нэмж төлнө.

*If the Client requests the Contractor for an additional order not specified in the Contract, the Client shall pay additional payment based on the original invoice and performance implemented by the Contractor.*

- 4.5 Гүйцэтгэгчийн дансны мэдээлэл:  
Contractor bank account information:

Хүлээн авагч банк /Name of bank/

Худалдаа хөгжлийн банк /TDB/

Хүлээн авах нэр /Name of account/	Элемент" ХХК /Element LLC/
Хүлээн авах дансны дугаар /Account number/	404054323

### Тав. Талуудын хүлээх хариуцлага

#### Five. Liabilities of Parties

- 5.1. Захиалагч нь Гүйцэтгэгчээс ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэхийн үнийн дүнгийн дагуу Гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд, төлөгдөөгүй үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.3 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг Гүйцэтгэгчид төлөх үүрэгтэй.

*If the Client fails to pay the amounts due under the invoices submitted by the Contractor within the period specified in this Contract, the Client shall pay default interest payments that is equal to 0.3% per day on the outstanding unpaid amount.*

- 5.2. Аль нэг Тал Гэрээний нөхцлийг зөрчсөний улмаас нөгөө Талд хохирсон, хохирол учруулсан тохиолдолд түүнээс шалтгаалсан бүх зардал, хариуцлага, алдагдал, хохирол, торгууль, зардлыг хариуцагч Тал хариуцна.

*In case of loss or damage caused to the other Party due to breach of the terms of the Contract and conditions by one Party, the defaulting Party shall be liable for all relevant costs, liabilities, loss and damages penalties and expenses.*

- 5.3. Талууд Гэрээ хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар мэдсэн, олж авсан, харилцан солилцсон бизнесийн нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээлэл эсхүл баримт бичгийг нөгөө Талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүй еерийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхол эсхүл нөгөө Талын эсрэг ашиглахгүй, дамжуулахгүй задруулахгүй байх, олон нийтэд нийтлэх, нийтэд мэдээлэхгүй байх үүргийг хугацаагүй хүлээх бөгөөд хэрэв Талуудын аль нэг уг нөхцөлийг зөрчсөн тохиолдолд Байгууллагын нууцын тухай Монгол Улсын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

*The Parties shall bear an obligation not to use any information, data or documents which are related to business confidentiality and were directly or indirectly known or obtained, for its own or a third party's interest without prior written consent of the other Party or use transmit, and/or transfer against the other Party, not to publish and disclose to public, which contains confidential information termless period. If one of the Parties breaches any of the conditions set hereto shall be liable for responsibility according to Organizational secrecy Law of Mongolia and other relevant laws and legislations.*

### Зургаа. Бусад

#### Six. Miscellaneous

- 6.1. Талуудын хооронд Гэрээтэй холбоотой маргаан гарвал харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд хэрэв Талууд 30 (гуч) хоногт шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийг баримтлан харьяалагдах шүүхэд шийдвэрлүүлнэ.

*Disputes between the Parties related to this Contract shall be resolved amicably and if the Parties fail to resolve the dispute within 30 (thirty) calendar days, it shall be resolved*

*by the relevant court in Mongolia in accordance with the laws of Mongolia.*

- 6.2. Гэрээг хоёр (2) хувь үйлдэх бөгөөд Талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

*This Contract shall be made in two (2) copies and shall be effective upon signing by the Parties authorized persons.*

- 6.3. Энэхүү гэрээ нь 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийг дуустал байгуулав.

*This Contract is effective from May 15, 2023, to May 15, 2025.*

- 6.4. Талууд Гэрээний нэмэлт, өөрчлөлтийг бичгээр, гарын үсгээр баталгаажуулж байгуулна. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь Гэрээний салшгүй хэсэг болно.

*Amendments to the Contract shall be made in writing and signed by the Parties. This Amendment shall be an inseparable part to the Contract.*

- 6.5. Гэрээний дагуу хийгдэх ажил, хамтын ажиллагааны зохион байгуулалт, гэрээний хэрэгжилтийг хангах чиглэлээр гарах аливаа мэдэгдэл, хүсэлт, зөвшөөрөл болон бусад баримт бичгийн боловсруулалтыг талуудаас томилогдсон дараах ажилтнууд хариуцна.

*The following contact persons shall be appointed by the Parties and shall be responsible for the preparation of any notifications, requests, approvals and other documents arising in connection with the work to be performed under the Contract, the organization of cooperation and the implementation of the Contract.*

<p>“Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийг төлөөлж: Худалдан авалтын хэлтсийн мэргэжилтэн Д.Шийлэгцэрэн Утас: +976-9901639 Хаяг: Төв аймаг, Сэргэлэн сум, 4-р баг, Эрдэнэ-Уул /41090/ И-мэйл: shilegtseren.d@nubia-llc.mn <i>On behalf of the “New Ulaanbaatar International Airport” LLC: D. Shiilegtseren, Officer, Planning and Coordination department, Procurement Service Division</i> Phone: +71287425 Address: Tuv aimag, Sergelen soum, 4th bag, Erdene-Uul / 41090 / Төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Э.Барсболд Утас: 88087180 И-мэйл хаяг: barsbold. e@nubia-llc.mn <i>Specialist of Planning division officer E.Barsbold</i> Phone: 88087180 Email address: barsbold. e@nubia-llc.mn</p>	<p>“Элемент” ХХК -ийг төлөөлж: Санхүү хариуцсан захирал: Б.Энхбадрал Ерөнхий нягтлан бодогч: А.Энхтуяа Утас: Санал гомдлын утас: 99107745 Дуудлагын утас 86113790, 99193790 Хаяг: БЗД, 26-р хороо, Нийслэл хүрээ өргөн чөлөө 404, Санрайс оффис центр И-мэйл хаяг: <a href="mailto:info@element.mn">info@element.mn</a> <i>Representing “Element” LLC: Chief Financial Officer: B.Enkhbadral / Chief Accountant: A.Enkhtuya / Phone: Complaint phone: 99107745 call phone 86113790, 99193790</i> Address: Bayanzurkh district, 26th khoroo, Niislel khuree avenue 404, Sunrise office center E-mail address: <a href="mailto:info@element.mn">info@element.mn</a></p>
--	---

Гэрээ байгуулсан:

Signed By:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


"Нью Улаанбаатар Интернэйшнл  
Эйрпорт" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

REPRESENTATING THE CLIENT:

"New Ulaanbaatar International Airport"

LLC

CEO



КИТАНАКА ТАКЭФУМИ  
TAKEFUMI KITANA

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


"Элемент" ХХК-ийн Гүйцэтгэх  
захирал

REPRESENTING

THE CONTRACTOR:

Element LLC

CEO



З.БАЯРСАЙХАН  
BAYARSAIKHAN.Z

Хог хаягдлын устгал, тээвэрлэлтийн үнийн тооцоо, ажлын давтамж –нэг сараар (төгрөг)

№	Аюултай хог хаягдлын төрөл	Хэмжээ /давтамж/	Устгалын үнэ	Тээвэрлэлтийн 1-рейсийн үнэ
1	Эмнэлгийн хог хаягдал	4-5 удаа		195,000
2	Шатамхай болон зэвсгийн чанартай хог хаягдал (хурц үзүүртэй хутга мэс, тамхины асаагуур/	кг 10-15 кг	3,000 төгрөг	
3	Химийн хог хаягдал	кг 15-20	5000-50000	
4	Лаг	Дуудлагаар сард 1-3 удаа		950,000
5	Механик хог хаягдал	Дуудлагаар сард 2-4 удаа		500,000

Appendix 1 to the Contract № ...

Waste disposal, calculation of transportation cost, work frequency - per month (MNT)

№	Waste type	Frequency (Monthly)	The cost of dissolution /MNT/	Fee per one time transportation
1	Medical waste	4-5 times a month		195,000
2	Combustible and weapons waste (sharp knives, cigarette lighters)	kg /10-20/	3,000	
3	Call each time laboratory hazardous waste is generated	kg /15-20/	5000-50000	
4	Sludge	1-3 times a month On Demand		950,000
5	Mechanical waste	1-4 times a month On Demand		500,000



ELEMENT LLC

### ЭЛЕМЕНТ ХХК

Хаяг: 13311-Улаанбаатар хот, Бичигдэх дүүрэг 26-р хороо,  
Шийбэлтэ хүртээгдэнт төлөв 404, Сэлэнгэ оффис центр 805 тавь  
Утас: 77173131, 77073790  
И-мэйл: info@element.mn Web: www.element.mn

## НЬУ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ ХХК-ИЙН ХОГ ХАЯГДАЛЫГ УСТГАСАН АРГА АРГАЧЛАЛ

№	Аюултай хог хаягдлын нэр	Устгасан арга
1	Цэвэрлэх байгууламжийн лаг	Зориулалтын шатаах зууханд цельсийн 800 градуст шатааж хаягдал үнсийг зөвшөөрөл бүхий хог хаягдал булах талбайд булшилсан.
2	Халдвартай хог хаягдал	Байгууллагаас гарч байгаа халдвартай хог хаягдлыг 100-120 градус цельсийн уурын автоклавын тусламжтайгаар халдваргүйжсний дараа буталж ландфиллын аргаар устгасан.
3	Механик хог хаягдал	Зориулалтын шатаах зууханд цельсийн 800 градуст шатааж хаягдал үнсийг зөвшөөрөл бүхий хог хаягдал булах талбайд булшилсан.

Тайлан гаргасан Химич

*Халиун*

Э.Халиун



**НЬЮ УЛАНБААТАР ИНТЕРНЕЙШНЛ ЭЙРПОРТ ХХК-ААС 2023 ОНЫ 1 САР ААС 2023 ОНЫ 12 САР ХҮТГЛЭХ  
ТЭЭВЭРЛЭН ҮСТГАСАН ХОГ ХАЙГДЛЫН ТАЙЛАН МЭДЭЭ**

№	Огноо	Дар-ын	Механик	Халдвартай	Хурц үзүүр	Шатамхай	Химийн хог	Нийт
		хэмжээ	хог хаягдал	хог хаягдал	ирмэгтэй хог хаягдал	хог хаягдал	хаягдал	
		кг	кг	кг	кг	кг	кг	кг
1	2023.01	3000	320	56.7	46.4	-	-	3428.1
2	2023.02	6000	640	24.6	12	5	5	6681.6
3	2023.03	3000	2000	28.5	45	5	5	5081.5
4	2023.04	3000	6000	34.8	44.9	8	8	9088.7
5	2023.05	3000	1000	49	45.6	9	9	4118.6
6	2023.06	-	1000	32.9	32	24	24	1068.9
7	2023.07	6000	-	26	44.2	4	4	6077.2
8	2023.08	3000	1000	26.5	161	7	7	4194.3
9	2023.09	3000	1000	37.1	68.6	6.8	6.8	4105.7
10	2023.10	-	6000	43.7	21.4	7	7	6072.1
11	2023.11	3000	3000	53.8	47.8	7	7	6108.6
	<b>Нийт</b>	<b>33000</b>	<b>21960</b>	<b>413.6</b>	<b>568.9</b>	<b>87.8</b>	<b>87.8</b>	<b>50025.3</b>

Мэдээ гаргасан Элемент ХХК-ийн Хиймич:



Э.Халиун



# АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАЛЫН АКТ

Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, шатаах, устгах төвлөрсөн байгууламж  
Хаяг: НД, 3-р хороо Бүс нуур 12610 гудамж 77 тоот Утас: 7707-3790, 7717-3131

2023 оны 12 сарын 13 өдөр

Актын дугаар: 23/248

Улаанбаатар хот

Аюултай хог хаягдал үүсгэгч: Нью Улаанбаатар Интернейшнл Эйрпорт

Устгалд оруулсан аюултай хог хаягдлын жагсаалт

№	Хаягдлын нэр, төрөл	Хэмжээ	Нэгж /тн/	Аюулын ангилал
1	Хурц үзүүр ирмэгтэй хог хаягдал	3.4	кг	Аюултай
2	Асаагуур	21.6	кг	Шатамхай
3	Батерей	2.2	кг	Хортой
Нийт		27.2	кг	-

## Устгасан аргачлал:

Дээрхи 27.2 кг хортой хог хаягдлыг "Элемент" ХХК-ийн аюултай хог хаягдал хүлээн авах, устгах комисс хүлээн авч зориулалтын шатаах зууханд 1200°C -т бүрэн шатааж хаягдал үнсийг ландшафтанд устгав.

Жич: Устгалд орсон бодисын нэр төрөл, жагсаалт, устгалын зураг хавсаргав.

## Устгал хийсэн

Химийн мэргэжилтэн



/Э.Халиун/

Хянасан

Ерөнхий менежер

/Б.Ундармаа/

Акт хүлээн авсан

.....

/...../



ELEMENT LLC

“Нью Улаанбаатар Интернейшл Эйрпорт”-нас 2023 оны 12 дугаар сарын 13 -ны өдөр ирсэн хортой хог хаягдал устгалд оруулж буй байдал. Устгалын актыг хавсралт зураг.

Актын дугаар: 23/248





ELEMENT LLC

# АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАЛЫН АКТ

Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, шатаах, устгах төвлөрсөн байгууламж

Хаяг: НД, 3-р хороо Бүс нуур 12610 гудамж 77 тоот

Утас: 7707-3790, 7717-3131

2023 оны 12 сарын 19 өдөр

Актын дугаар: 23/258

Улаанбаатар хот

Аюултай хог хаягдал үүсгэгч: "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт"

*Устгалд оруулсан аюултай хог хаягдлын жагсаалт*

№	Хаягдлын нэр, төрөл	Хэмжээ	Нэгж /кг/	Аюулын ангилал
1	Хурц үзүүр ирмэгтэй хог хаягдал	2.4	кг	Аюултай
2	Асаагуур	7.8	кг	Шатамхай
Нийт		10.2	кг	-


### Устгасан аргачлал:

Дээрхи 10.2 кг аюултай болон шатамхай хог хаягдлыг "Элемент" ХХК-ийн аюултай хог хаягдал хүлээн авах, устгах комисс хүлээн авч зориулалтын шатаах зууханд 1200°C -т бүрэн шатааж хаягдал үнсийг лангфиллдэж устгав.

**Жиш:** Устгалд орсон бодисын нэр төрөл, жагсаалт, устгалын зураг хавсаргав.

### Устгал хийсэн

Химийн мэргэжилтэн



/Э.Халиун/

Хянасан

Ерөнхий менежер

/Б.Ундармаа/

Акт хүлээн авсан

.....

/...../



ELEMENT LLC

“Нью Улаанбаатар Интернейшнл Эйрпорт”-оос 2023 оны 12 дугаар сарын 19 –ны өдөр ирсэн тэсрэх аюултай, хурц үзүүр, иртэй материалын хаягдал устгалд оруулж буй байдал. Устгалын актыг хавсралт зураг.

Актын дугаар: 23 / 158



Аюултай хог хаягдал хариуцсан мэргэжилтэн

Химич: Халиун

Э. Халиун

## WORK PERFORMANCE CONTRACT

### АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Date:

No. 117/23

Tuv province

Огноо: 2023/05/15

Төв аймаг

This **WORK PERFORMANCE CONTRACT** (the "Contract") was made by and BETWEEN: "New Ulaanbaatar International Airport" LLC, its registered address at 41090 Takhilt Tolgoi, Erdene-Uul 4<sup>th</sup> bag, Sergelen soum, Tuv aimag (Registration number: 3874095) represented by its Chief Executive officer Takefumi Kitinaka (the "Client"); and

"Ulaanbaatar Ariutgal" LLC with its registered address 1508 Union Building, 62 Namii zam, 1<sup>th</sup> khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar (Registration number 5585511) represented by its Director Otgonjargal.Ch (the "Contractor"), (hereinafter referred collectively as "Parties" and individually as "Party") with the following terms and conditions in accordance with the Civil Code and other relevant legislative acts of Mongolia.

Энэхүү **АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ** (цаашид "Гэрээ" гэх)-г:

Нэг талаас 41090 Төв аймаг, Сэргэлэн сум, Эрдэнэ -Уул 4-р баг, Тахилт толгой албан ёсны хаягт байрлах "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК (Регистрийн дугаар: 3874095)-ийг төлөөлж, Гүйцэтгэх захирал Китанака Такэфуми (цаашид "Захиалагч" гэх); болон

Нөгөө талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн, 1-р хороо нарны зам 62-р байр Юнион бюлдинг 1508 тоот албан ёсны хаягт байрлах "Улаанбаатар Ариутгал" ХХК /РД:5585511/-ийг төлөөлж, Захирал Ч.Отгонжаргал (цаашид "Гүйцэтгэгч" гэх) (цаашид тус бүрд нь "Тал", хамтад нь "Талууд" гэх) нар Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжийг үндэслэн дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

## ONE. GENERAL PROVISION

### НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1. This Contract shall regulate the rights and obligations to be arisen between the Parties during the term of the Contract, regarding the Contractor's performing the work requested by the Client to perform the "Rodenticide and pesticide" (the "Work") specified in Appendix 1 and 2 in the protected area of Aerodrome, restricted area and protected area of Airport and its Buildings in accordance with the work assignment, design, construction materials, and dimension by using its own technical equipment, machinery, materials and workforce, and to hand over the performed Work result to the Client by making the Completion act and Client's payment for the Work and schedule.

Энэхүү Гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагчийн хүсэлтийн дагуу Гэрээний Хавсралт 1 заасан "Мэрэгчгүйтгэл", Хавсралт 2-т заасан "Шавьжгүйтгэл, (цаашид "Ажил" гэх)-ийг Аэродромын хамгаалагдсан бүс, нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүс, гадна орчин болон барилга байгууламжийн дотор, мэрэгч устгал болон шавьжгүйтгэлийн ажил гүйцэтгэхтэй холбоотой өөрийн техник тоног төхөөрөмж, машин механизм, материал, ажиллах хүчээр гүйцэтгэж, Ажлын үр дүнг Захиалагчид Гэрээ дүгнэсэн актаар хүлээлгэн өгөх, Захиалагч Ажлын хөлсийг төлөх, Ажлын хуваарь гаргахтай холбоотой Гэрээний хугацаанд Талуудын хооронд үүсэх эрх, үүргийг зохицуулна.

## TWO. CONTRACT TERM

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1. The Contract shall come into force and effect with the signatures and seals of the authorized representatives of the Parties and remain valid until the expiry date of the warranty period stated in Article 6.1 of the Contract.

Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Гэрээний 6.1-т заасан баталгаат хугацаа дуусах өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

- 2.2. The Contractor shall perform the Work from May 15, 2023 and Work shall be carried out in May and October, 2023 and hand over the Work results to the Client and concluding the Completion act by the Parties in November 2023.

Гүйцэтгэгч нь 2023 оны 05 дугаар сарын 15-ний өдрөөс эхлэх бөгөөд 2023 оны 5 дугаар сар 10-р сард ажлыг гүйцэтгэж, Ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгч, Талууд Гэрээ дүгнэсэн актыг 2023 оны 11 дүгээр сард үйлдэнэ.

### THREE. CONTRACT AMOUNT AND PAYMENT TERMS ГУРАВ. АЖЛЫН ХӨЛС БОЛОН ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 3.1. The total amount of the Contract (the "Work Fee") shall be MNT 34,227,800 (thirty-four million two hundred twenty-seven thousand eight hundred tugriks). This amount shall include the wage of workers, prices of all the required products and, transportation expense, equipment, other related expenses, and value added tax necessary to perform Work. The Client shall transfer Work Fee to the Contractor in the following stages:

Гэрээний нийт үнийн дүн (цаашид "Ажлын хөлс" гэх) нь **34,227,800** (гучин дөрвөн сая хоёр зуун хорин долоон мянга найман зуу) төгрөг байна. Энэхүү үнэд ажилчдын цалин, Ажил гүйцэтгэхэд шаардагдах бүх бүтээгдэхүүн, тээвэрлэлтийн зардал, тоног төхөөрөмж, бусад бүх зардал болон НӨАТ багтсан болно. Захиалагч нь Ажлын хөлсийг дараах үе шатаар Гүйцэтгэгчид шилжүүлнэ:

- 3.1.1. The Client shall transfer of the Work Fee by performance of the Work to the following account of the Contractor after receiving the original invoice and work report, within 5 (five) working days.

Ажлын хөлсийг гүйцэтгэлээр буюу ажил гүйцэтгэсний дараа нэхэмжлэхийн эх хувь, ажлын тайлан үндэслэн ажлын 5 (тав) хоногт багтаан Гүйцэтгэгчийн доорх дансанд шилжүүлнэ;

- 3.1.2. Bank account details: Khaan Bank  
Account number : 5624215627 UB Ariutgal LLC  
Банкны мэдээлэл: Хаан банк  
Харилцах данс: 5624215627 "Улаанбаатар ариутгал ХХК"

- 3.2. The Parties shall discuss and agree the additional cost if there is any supplemental work which is not included in this Contract or there is any change in the quantity of the agreed Work during the performance of the Contract, such amendment to the Contract shall be made in writing and shall consist an inseparable part of the Contract.

Ажил гүйцэтгэх явцад Гэрээнд тусгагддаггүй нэмэлт ажил гүйцэтгүүлэх эсхүл Ажлын хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд Талууд нэмэлт зардлыг харилцан тохиролцож тогтоох бөгөөд тухайн нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэх ба Гэрээний салшгүй хэсэг болно.

- 3.3. During the Contract term, the Work Fee set forth in Article 3.1 of the Contract shall not be increased except for the additional cost specified in Article 3.2. In the event of an increase in the price due to factors such as, but not limited, an increase of inflation, an increase in the prices of materials to be used to perform the Work, a sharp increase in the exchange rate, and increase in the wage of worker, or increase in taxes and fees, all the unpredicted costs shall be borne by the Contractor.

Гэрээний хугацаанд Гэрээний 3.1-т заасан Ажлын хөлсийг Гэрээний 3.2-т заасан нэмэлт зардлаас өөр үндэслэлээр нэмэгдүүлэхгүй. Тухайлбал дараах хүчин зүйлээс шалтгаалсан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй үнийн өсөлт тухайлбал инфляцын өсөлт, Ажил гүйцэтгэхэд хэрэглэгдэх материалын үнийн өсөлт, валютын ханшийн огцом өсөлт, ажилчдын цалингийн өсөлт, татвар, хураамж зэрэг урьдчилан тооцоолоогүй бүх зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

**FOUR. RIGHTS AND OBLIGATIONS OF THE CLIENT  
ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 4.1. In order to perform the Work at a high level of quality and technology during the Contract term, the Client has the right to require qualified personnel and equipment from the Contractor.  
*Гэрээний хугацаанд Ажлыг чанар, технологийн өндөр түвшинд гүйцэтгүүлэхээр Захиалагч нь шаардлага хангасан ажиллах хүч, тоног төхөөрөмжийг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.*
- 4.2. Review whether the materials and equipment used by the Contractor for the Work meet the requirements and offer its proposals on procurement and selection of the materials to be used for the Work.  
*Ажил гүйцэтгэхэд Гүйцэтгэгчийн ашиглаж байгаа материал болон тоног төхөөрөмж нь Захиалагчийн шаардлагад тохирч байгаа эсэхэд хяналт тавих, Ажилд ашиглагдах материал худалдан авах, сонголт хийхэд өөрийн саналыг Гүйцэтгэгчид гаргах эрхтэй.*
- 4.3. Demand the Contractor to eliminate the breaches and defects revealed during the warranty period.  
*Баталгаат хугацаанд гарсан зөрчил, доголдлыг арилгахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.*
- 4.4. Appoint its authorized representative to get acquainted with the Work process and performance of the Contractor at any time.  
*Өөрийн эрх бүхий төлөөлөгчийг томилж, хэдийд ч Гүйцэтгэгчийн Ажлын явц болон гүйцэтгэлтэй танилцах эрхтэй.*
- 4.5. Claim compensation from the Contractor in the event if the Client's authorized representative/employee got injured or damage caused by the Contractor's negligence or irresponsibility in the course of reviewing the progress and performance of the Work as specified in this Contract.  
*Захиалагчийн эрх бүхий төлөөлөгч/ажилтан нь Гэрээнд заасны дагуу Ажлын явц болон гүйцэтгэлтэй танилцах явцад Гүйцэтгэгчийн болгоомжгүй, хариуцлагагүй байдлын улмаас гэмтэж бэртсэн, хохирол учирсан тохиолдолд Гүйцэтгэгчээс нөхөн төлбөр шаардана.*
- 4.6. During the performance of the Work, the Client has the right to request the Contractor to perform additional work which is not specified in the Contract, in which case the amendment to the Contract shall be made in writing with the Contractor on the scope and amount of the additional work.  
*Ажил гүйцэтгэх явцад Захиалагч нь Гэрээнд тусгаагдаагүй нэмэлт ажлыг гүйцэтгүүлэхээр Гүйцэтгэгчид хүсэлт гаргах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд нэмэлт ажлын цар хүрээ, үнийн дүнг тогтоосон Гэрээний нэмэлт өөрчлөлтийг Гүйцэтгэгчтэй бичгээр байгуулна.*
- 4.7. If the Work was considered as performed within the period set forth in Article 2.2, obliged to transfer the payment within the specified period to the Contractor.  
*Ажлыг Гэрээний 2.2-т заасан хугацаанд гүйцэтгэсэн гэж үзвэл Гүйцэтгэгчид Ажлын хөлсийг тогтоосон хугацааны дотор шилжүүлнэ.*
- 4.8. Obligated to receive the Work results within the period specified in this Contract and shall not refuse or delay the acceptance of the Work without reasonable grounds.  
*Гэрээнд заасан хугацаанд Ажлын үр дүнг хүлээн авах үүрэгтэй бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Ажлыг хүлээн авахаас татгалзах, хойшлуулах эрхгүй.*
- 4.9. Exercise the rights and bear the obligations set forth in the Civil Code of Mongolia and other relevant legislations.

Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

- 4.10. *The Client undertakes to enter the Contractor's premises if necessary.*  
*Захиалагч нь шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэгчийн ажлын байранд нэвтэрнэ.*

## **FIVE. RIGHTS AND OBLIGATIONS OF THE CONTRACTOR**

### **ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 5.1. *Obligated to organize the workforce, machinery and equipment in accordance with the relevant Laws, norms and standards of Mongolia and its work methods in order to perform the Work at a high level of quality and technology within the Contract term.*  
*Гэрээнд заасан хугацааны дотор Ажлыг чанар, технологийн өндөр түвшинд гүйцэтгэхийн тулд ажиллах хүч, машин механизм, техник, тоног төхөөрөмжийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, норм, стандарт болон өөрийн ажлын арга барилд нийцүүлэн зохион байгуулна.*
- 5.2. *Demand the payment from the Client by handing over the Work result to the Client's authorized representative by submitting a report which confirms the full performance of the Work within the period specified in this Contract.*  
*Гэрээнд заасан хугацааны дотор Ажлыг бүрэн гүйцэтгэсэн болохыг баталгаажуулсан тайланг гаргах замаар Ажлын үр дүнг Захиалагчийн эрх бүхий төлөөлөгчид хүлээлгэн өгснөөр Захиалагчаас үлдэгдэл төлбөрийг шаардана.*
- 5.3. *According to the work assignment approved by the Client, the qualified materials are confirmed by certificates and conclusions, and the relevant norms, rules and standards are fully executed within the period specified in Article 2.2 of the Contract, and the Work results are delivered to the Client without any defects.*  
*Захиалагчийн баталсан ажлын даалгаврын дагуу гэрчилгээ, дүгнэлтээр баталгаажсан, чанарын шаардлага хангасан материалаар Гэрээний 2.2-т заасан хугацаанд холбогдох норм, дүрэм болон стандартад нийцүүлэн Ажлыг гүйцэтгэх баямар нэг доголдолгүй Ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгнө.*
- 5.4. *The Contractor is responsible for keeping a daily record of the Work performance.*  
*Гүйцэтгэгч нь Ажлын гүйцэтгэлийн талаар өдөр тутмын тэмдэглэл хөтөлнө.*
- 5.5. *Obligated to let the Client's authorized representatives access to the site, explain to them about the progress and performance of the Work, and provide them with accurate information about the Work.*  
*Захиалагчийн эрх бүхий төлөөлөгчийг ажлын талбайд саадгүй нэвтрүүлэх, Ажлын явц болон гүйцэтгэлийн талаар тайлбарлаж, Ажлын талаар үнэн зөв мэдээллээр хангана.*
- 5.6. *Obligated to comply with the requirements of the Client's authorized representatives and related experts in a timely manner and to follow any instructions, guidelines and procedures approved by the Client.*  
*Захиалагчийн эрх бүхий төлөөлөгчид болон холбогдох мэргэжилтний тавьсан шаардлагыг хугацаанд нь биелүүлэх, Захиалагчийн баталсан заавар, удирдамж болон журмыг дагаж мөрдөнө.*
- 5.7. *Obligated to be fully liable for any issue pertaining to the quality of materials used for the Work and indemnify the Client.*  
*Ажилд ашигласан материалын чанартай холбоотой аливаа асуудлыг бие даан хариуцаж, Захиалагчийг хохиролгүй болгоно.*
- 5.8. *Obligated to not to transfer its contractual obligations to others and may hire a subcontractor only based on the prior consent of the Client.*

*Гэрээний үүргээ бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй бөгөөд зөвхөн Захиалагчийн урьдчилан өгсөн зөвшөөрлийг үндэслэн Туслан гүйцэтгэгч ажиллуулж болно.*

- 5.9. Obligated to use the machinery, equipment and tools meeting the Work quality and safety requirements and be solely responsible for issue to be arisen due to non-compliance.

*Ажил гүйцэтгэхдээ чанар болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах бөгөөд энэ үүргээ биелүүлээгүйгээс үүсэх аливаа асуудлыг дангаар хариуцна.*

- 5.10. Obligated to ensure fire safety, occupational safety and health of the staff working on the site, safety of the work site (damage to be caused to health and life of the workers and the inspectors and damage to machinery and property etc) from the date of commencement of the Work to the date of handing over the Work result to the Client and removing its equipment from the worksite and be solely responsible for any risks arising from non-compliance with occupational safety instructions.

*Ажил гүйцэтгэж эхлэх өдрөөс эхлэн Захиалагчид Ажлын үр дүнг хүлээлгэн өгч, өөрийн тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах хүртэлх хугацаанд галын аюулгүй байдал, ажлын талбай дээр ажиллаж байгаа ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ажлын талбайн аюулгүй байдал (ажилтнууд болон хяналт шалгалтын хүмүүсийн эрүүл мэнд, амь насанд хохирол учрах, машин механизм, эд хөрөнгөнд эвдрэл гэмтэл учрах гэх мэт)-ийг бүрэн хариуцах үүрэгтэй бөгөөд хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг хангаж ажиллаагүйгээс үүсэх аливаа эрсдэлийг дангаар хариуцна.*

- 5.11. Obligated to hire a qualified occupational safety and health (the "OSH") officer from the date of commencement of the Work to the date of handing over the Work result to the Client and removing its equipment from the worksite, introduce OSH instructions at all levels to the staff and confirm the activities with signatures and be solely responsible for any issues arisen from non-fulfillment of this obligation.

*Ажил гүйцэтгэж эхлэх өдрөөс эхлэн Захиалагчид Ажлын үр дүнг хүлээлгэн өгч, өөрийн тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах хүртэлх хугацаанд мэргэшсэн Хөдөлмөр хамгааллын мэргэжилтэн ажиллуулах үүрэгтэй бөгөөд бүх шатны хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчлгааг ажилчдад танилцуулж, уг ажиллагааг гарын үсгээр баталгаажуулах бөгөөд уг үүргээ бүрэн биелүүлээгүйгээс үүсэх аливаа асуудлыг дангаар хариуцна.*

- 5.12. Obligated to eliminate the defects identified in the performed Work at its own expense (wage, material cost, transportation cost, machinery cost etc).

*Гүйцэтгэсэн Ажилд илэрсэн доголдлыг өөрийн зардал (ажлын хөлс, материалын зардал, тээврийн зардал, машин механизмын зардал г.м)-аар арилгана.*

- 5.13. Fully repair the damage at its own expense in the event that the damage caused to the building (warehouse) and other related properties during the removal of the equipment and machinery used in connection with the performance of the Work.

*Ажил гүйцэтгэхэд ашиглаж байсан тоног төхөөрөмж, машин механизмыг гаргах явцад барилга (агуулах) болон бусад эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд тухайн хохирлыг өөрийн зардгаар бүрэн сэргээн засварлана.*

- 5.14. Obligated to take all necessary measures to ensure the personal discipline of its employees (public disorder, theft, use of alcohol and drugs, smoke, being idle at the work site, and prohibition of littering at the workplace etc). Any liability arising from failure to fulfill this obligation shall be borne by the Contractor.

*Өөрийн ажилтнуудын хувийн сахилга бат (танхайрах, хулгай хийх, согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэх, тамхи татах ажлын талбайд дураараа сэлгүүцэх, ажлын байран дээр хог хаяхыг хориглох гэх мэт)-ыг сахиулах бүх талын арга хэмжээг авна. Гүйцэтгэгч нь энэ үүргээ биелүүлээгүйгээс үүсэх аливаа хариуцлагыг дангаар хариуцна.*

- 5.15. Observe the occupational safety and security procedures on performance of the Work, provide instructions to the workforce, and provide them with necessary uniforms.  
*Ажил гүйцэтгэхдээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж, ажилчдадаа зааварчилгаа өгч, ажлын хувцас хэрэглэлээр хангана.*
- 5.16. Exercise the rights and bear the obligations set forth in the Civil Code of Mongolia and other relevant legislations.  
*Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.*
- 5.17. The Contractor shall dispose of the waste from the Work at the landfill specified by the Client.  
*Гүйцэтгэгч нь Ажлаас гарсан хог хаягдлыг Захиалагчийн заасан цэгт устгана.*

#### **SIX. WARRANTY ЗУРГАА. БАТАЛГААТ ХУГАЦАА**

- 6.1. The Contractor shall issue a 1 (one) monthly quality warranty to the Work from the date of completing the Work and handing over by Completion act to the Client by making a report.  
*Гүйцэтгэгч нь Ажлаа дуусгаж, тайлангийн хамт Гэрээ дүгнэсэн актаар Захиалагчид Ажлын үр дүнг хүлээлгэн өсгөн өдрөөс хойш Ажилд 1 (нэг) сар чанарын баталгаат хугацаа олгоно.*
- 6.2. In the event, if defects were identified to the Work during the period of warranty specified in Article 6.1 of this Contract, the Client shall notify the Contractor immediately in writing or by e-mail. The Contractor shall review the defects within 3 (three) working days after receipt of such notification.  
*Гэрээний 6.1-т заасан баталгаат хугацаанд Ажлын үр дүнд доголдол илэрсэн тохиолдолд энэ тухай Захиалагч нь Гүйцэтгэгчид бичгээр эсхүл и-мэйлээр нэн даруй мэдэгдэнэ. Гүйцэтгэгч нь тухайн мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 3 (гурван) хоногт багтаан доголдлыг шалгана.*
- 6.3. The Parties shall reach a mutual agreement on the period to eliminate the identified defects after the Contractor reviewed the defects in accordance with Article 6.2 of this Contract.  
*Гүйцэтгэгч нь Гэрээний 6.2-т зааснаар доголдлыг шалгасны дараа Талууд уг доголдлыг арилгах хугацааг харилцан тохиролцож тогтооно.*
- 6.4. The Contractor shall not be liable for any defects caused by the Client's improper operations such as intentional or unintentional damage to the Work.  
*Гүйцэтгэгч нь Ажлын үр дүнд санаатай болон санамсаргүйгээр хохирол учруулсан Захиалагчийн буруу ашиглалтын улмаас үүссэн доголдлыг хариуцахгүй.*

#### **SEVEN. RESPONSIBILITY ДОЛОО. ХАРИУЦЛАГА**

- 7.1. In case if the Contractor failed to complete the Work within the period set forth in Article 2.2 of this Contract and failed to hand over it within the period specified in Article 6.2 of the Contract, the Contractor shall pay an undue loss equal to 0.3% of the outstanding Work to the Client for each overdue day. The Client shall deduct the undue loss from the outstanding balance due to the Contractor.  
*Гүйцэтгэгч нь Гэрээний 2.2-т заасан хугацаанд Ажлыг хийж дуусгаагүй, Гэрээний 6.2-т заасан хугацаанд хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувьтай тэнцэх алдангийг Захиалагчид төлнө. Захиалагч нь алдангийг Гүйцэтгэгчид төлөх үлдэгдэл төлбөрөөс суутган авна.*

- 7.2. In the event, if the Client failed to pay to the Contractor within the period set forth in this Contract, it shall pay an delayed penalty equal to 0.3% of the outstanding payment to the Contractor for each overdue day.  
*Захиалагч нь төлбөрийг Гэрээнд заасан хугацаанд Гүйцэтгэгчид төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй төлбөрийн 0.3 хувьтай тэнцэх алдангийг Гүйцэтгэгчид төлнө.*
- 7.3. In case if the Contractor failed to perform the Work specified in this Contract without any good reasons since the commencement date of the Work, or if the Contract was cancelled at the Client's initiative due to the conditions specified in Article 8.2 of this Contract, the Contractor shall reimburse the advance payment set forth in Article 3.1.1 to 3.1.2 of this Contract and a fine equal to 0.3 % of the total cost of the Contract to the Client.  
*Гүйцэтгэгч нь Ажил эхэлсэн өдрөөс хойш хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Гэрээнд заасан Ажлыг хийж гүйцэтгээгүй эсхүл Гэрээний 8.2-т заасан нөхцөл байдал үүссэний улмаас Захиалагчийн санаачилгаар Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч Гэрээний 3.1.1-3.1.2-т заасан урьдчилгаа төлбөрийг Захиалагчид буцаан төлөх ба Гэрээний нийт үнийн дүнгийн 0.3 хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг Захиалагчид нэмж төлнө.*
- 7.4. In case if the Contractor caused damage to the Client or a third party due to its failure in fulfilling its obligations set forth in the Article 5 of this Contract, the Contractor shall solely be responsible for the damage.  
*Гүйцэтгэгч нь Гэрээний 5-р зүйлд заасан үүргээ биелүүлээгүйгээс Захиалагч болон гурвадагч этгээдэд ямар нэгэн хохирол учруулсан тохиолдолд энэхүү хохирлыг дангаар бүрэн хариуцна.*
- 7.5. Replacement of the authorized representatives of the Parties shall not be a ground for non-performance of their obligations specified in this Contract, to be exempted from the liabilities arisen under this Contract, to cancel or termination.  
*Талуудын эрх бүхий төлөөлөгчид өөрчлөгдөх нь Гэрээнд заасан үүргээ үл биелүүлэх, Гэрээнээс үүсэх үүрэг хариуцлагаас чөлөөлөгдөх, Гэрээг цуцлах, дуусгавар болгох үндэслэл болохгүй.*

## **EIGHT. COMPLETION OF THE WORK AND TERMINATION OF THE CONTRACT** **НАЙМ. АЖИЛ ДУУСГАВАР БОЛОХ, ГЭРЭЭ ЦУЦЛАХ**

- 8.1. The Contractor shall perform the Work within the period specified in Article 2.2 of this Contract and notify the Client of it. The Client's authorized representatives shall review the Work performed and accept the Work results within 72 (seventy two) hours by considering it as fully completed.  
*Гүйцэтгэгч Ажлыг Гэрээний 2.2-т заасан хугацаанд гүйцэтгэх бөгөөд Ажил дууссан тухай Захиалагчид мэдэгдэнэ. Захиалагчийн эрх бүхий төлөөлөгчид гүйцэтгэсэн Ажлыг шалгаж, Ажил бүрэн дууссан гэж үзвэл Ажлын үр дүнг 72 (далан хоёр) цагийн дотор хүлээн авна.*
- 8.2. The Contract shall be terminated at the Client's initiative in the following cases:  
*Гэрээг дараах тохиолдолд Захиалагчийн санаачилгаар цуцална:*
- 8.2.1 The Contractor got bankrupted or was liquidated for purposes other than reorganization;  
*Гүйцэтгэгч нь өөрчлөн байгуулагдахаас бусад зорилгоор дампуурсан эсхүл татан буугдсан;*
- 8.2.2. The Contractor has committed particular breaches and defects and failed to eliminate the breaches and defects within the period specified by the Client.  
*Гүйцэтгэгч нь зөрчил, доголдол гаргасан бөгөөд Захиалагчийн тогтоосон хугацаанд уг зөрчил, доголдлыг арилгаагүй;*

- 8.2.3. If the Client has determined that the Contractor has failed to perform the Work with quality materials and high quality performance;  
*Гүйцэтгэгч нь Ажлыг чанартай материалаар, өндөр чанартай гүйцэтгэж чадаагүйг Захиалагч тогтоосон бол;*
- 8.3. If the Client terminates the Contract in accordance with Article 8.2 of this Contract, it shall evaluate the Work performed by the Contractor until the termination date. In case if the advance payment exceeded the payment amount of the Work performed during the period until termination of the Contract, the Contractor shall reimburse the amount of excess payment to the Client within five (5) working days.  
*Захиалагч нь Гэрээний 8.2-т заасны дагуу Гэрээг цуцлах тохиолдолд уг өдөр хүртэлх хугацаанд Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн Ажлыг үнэлнэ. Хэрэв урьдчилгаа төлбөр нь Гэрээ цуцлах хүртэлх хугацаанд гүйцэтгэсэн Ажлын үнэлгээнээс илүү гарсан тохиолдолд Гүйцэтгэгч илүү гарсан төлбөрийг ажлын тав (5) хоногт багтаан Захиалагчид буцаан төлнө.*
- 8.4. In the event if the Contractor failed to reimburse the excess payment within the period specified in Article 8.3 of this Contract, it shall pay delayed interest equal to 0.3% of the outstanding payment to the Client for each overdue day.  
*Гүйцэтгэгч нь Гэрээний 8.3-т заасан төлбөрийг Захиалагчид буцаан төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам 0.3%-ийн алдангийг Захиалагчид төлнө.*
- 8.5. The Contract shall be terminated at the Contractor's initiative in the following cases:  
*Гэрээг дараах нөхцөлд Гүйцэтгэгчийн санаачилгаар цуцална:*
- 8.5.1 The Client delayed the date of making the advance payment to the Contractor by 5 (five) or more working days from the date specified in this Contract;  
*Захиалагч урьдчилгаа төлбөр төлөх хоногийг Гэрээнд заасан хугацаанаас ажлын тав (5) болон түүнээс дээш хоног хэтрүүлсэн;*
- 8.5.2 The Client delayed the Work for more than 5 (five) working days due to failure in Article 4.8 of this Contract without reasonable grounds;  
*Захиалагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Гэрээний 4.8-д заасныг биелүүлээгүйгээс ажлын тав (5) болон түүнээс дээш хугацаагаар Ажлыг саатуулсан бол;*
- 8.6. In the event if this Contract was terminated at the initiative of either Party or the Work was completed, the performed Work and all the goods, materials purchased by the Contractor shall be transferred to the Client's ownership.  
*Гэрээг аль нэг Талын санаачилгаар цуцалсан эсхүл Ажлыг бүрэн гүйцэтгэсэнээр Гэрээ дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэсэн Ажил болон Гүйцэтгэгчийн худалдан авсан бүх бараа, материал нь Захиалагчийн өмчлөлд шилжинэ.*
- 8.7. In the event of termination of this Contract at the initiative of either Party or the Work was completed, the Contractor's Work shall be suspended immediately upon termination of the Contract and the work site shall be vacated within 2 (two) calendar days by ensuring the safety of the work site and removal of waste.  
*Гэрээг аль нэг Талын санаачилгаар цуцалсан, Ажлыг бүрэн гүйцэтгэсэнээр Гэрээ дуусгавар болсон тохиолдолд Гүйцэтгэгч Ажлыг Гэрээг цуцалсан даруйд зогсоож, ажлын талбайн аюулгүй ажиллагааг хангаж, хог хаягдлыг устгаж, ажлын талбайг хуанлийн хоёр (2) хоногт багтаан чөлөөлөх үүрэгтэй.*
- 8.8. After completing the Work or upon cancellation, the Contractor shall hand over the Work Results Report to the Client within 14 calendar days, certified by a photograph or as requested by the Client, along with operational instructions and manuals.

*Гүйцэтгэгч нь Ажлыг гүйцэтгэж дууссан эсхүл Гэрээг цуцалсны дараа хуанлийн 14 хоногийн дотор Ажлын үр дүнгийн тайланг фото зургаар баталгаажуулж эсхүл Захиалагчийн шаардсанаар үйл ажиллагааны заавар, гарын авлагын хамт Захиалагчид хүлээлгэн өгнө.*

#### **NINE. FORCE MAJEURE ЕС. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

- 9.1 If either Party was unable to fulfill its obligations due to an unforeseen event or force majeure (earthquake, flood, fire, storm, epidemic and other natural disasters, government decision etc), it shall be considered as a ground of the exemption from the contractual liability.  
*Гэрээний аль нэг Тал гэнэтийн эсхүл давагдашгүй хүчин зүйл (тухайлбал газар хөдлөлт, үер, гал түймэр, шуурга, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, төрийн шийдвэр гэх мэт)-ийн улмаас Гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд Гэрээний хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно.*
- 9.2. The Parties shall immediately notify in writing about the start and ending of circumstances of any event specified in Article 9.1 of the Contract.  
*Гэрээний 9.1-т заасан нөхцөл байдал үүссэн болон дууссан талаар Талууд нэн даруй харилцан бичгээр мэдэгдэнэ.*

#### **TEN. DISPUTE SETTLEMENT АРВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

- 10.1 The Parties shall make their best efforts to settle any dispute arisen during the implementation of this Contract in an amicable manner and in case of a failure to reach a resolution within thirty (30) days the dispute shall be submitted to the applicable court of Mongolia.  
*Талууд Гэрээний хэрэгжилттэй холбоотой үүссэн маргааныг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд гуч (30) хоногийн дотор маргааныг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд маргааныг Монгол Улсын харьяалах шүүхээр шийдвэрлүүлнэ.*

#### **ELEVEN. MISCELLANEOUS АРВАН НЭГ. БУСАД**

- 11.1 This Contract shall be executed in number of counterparts each of which is deemed original, in the case of any discrepancy between the Mongolian and English versions the English version shall prevail.  
*Энэ Гэрээг хувь тус бүр эх хувьд тооцогдох тоогоор үйлдэх бөгөөд Монгол болон Англи эхийн хооронд утга, агуулгын зөрүү гарвал Англи эхийг баримтлана.*
- 11.2. This Contract shall be governed and construed in accordance with Mongolian law.  
*Энэ Гэрээг Монгол Улсын хуулийн дагуу зохицуулж, тайлбарлана.*
- 11.3. The Parties shall bear an obligation of not to use, transfer, disclose any information, data, or documents (all types of contracts, agreements, transactions, quotations etc), which are related to the business secrets and were directly or indirectly known or obtained, for its own or a third party's interest without consent of the other party or use and transmit against the other party indefinitely.  
*Талууд шууд болон шууд бусаар мэдсэн, олж авсан, бизнесийн нууцад хамгаарах аливаа мэдээ, мэдээлэл, баримт (бүх төрлийн гэрээ, хэлцэл, гүйлгээ, үнийн санал гэх мэт) –ийг нөгөө Талын зөвшөөрөлгүйгээр өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлын төлөө эсвэл Гэрээний нөгөө талын эсрэг ашиглахгүй, дамжуулахгүй, задруулахгүй байх үүрэгтэй.*
- 11.4. Any amendment or modification to this Contract shall become effective only if the authorized representatives of the Parties have agreed in writing and affirmed with their signatures. Such amendment to the Contract shall become an inseparable part of the Contract.

Энэ Гэрээний аливаа нэмэлт, өөрчлөлтийг Талуудын эрх бүхий төлөөлөгчид бичгээр үйлдэж, гарын үсгээр баталгаажуулсан тохиолдолд хүчин төгөлдөр болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь Гэрээний салшгүй хэсэг болно.

**SIGNED BY:**

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт"  
ХХК-ийн Гүйцэтгэх захирал  
REPRESENTATING THE CLIENT:  
"New Ulaanbaatar International Airport" LLC  
CEO

КИТАНАКА ТАКЭФУМИ  
TAKEFUMI KITANAKA

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
"Улаанбаатар Ариутгал" ХХК-ийн  
Захирал  
REPRESENTING THE CONTRACTOR:  
"Ulaanbaatar Ariutgal" LLC  
DIRECTOR

Ч.ОТГОНЖАРГАЛ  
OTGONJARGAL.Ch

## Барилга байгууламжууд /Facilities/; Rodenticide /Мэрэгч устгал/

№	Name of facility	Area /sq.m/	Total area /sq.m/	Frequency	Work fee		Total price / VAT included/
					May 2023	Oct 2023	
1	Admin building	800m <sup>2</sup>	22,713m <sup>2</sup>	2	2,500,000	2,500,000	5,000,000
2	Aerodrome building	4423m <sup>2</sup>					
3	Fire station	1136m <sup>2</sup>					
4	GSE building	4250m <sup>2</sup>					
5	Sewage Treatment Plant	1474m <sup>2</sup>					
6	Heating Plant	650m <sup>2</sup>					
7	Heated Garage	6015m <sup>2</sup>					
8	Cargo Terminal building	3125m <sup>2</sup>					
9	Main substation	170m <sup>2</sup>					
10	Water treatment Plant	670m <sup>2</sup>					
<b>Total price</b>							<b>5,000,000</b>

## Гадна талбай Airside; Rodenticide

№	Name of facility	Total area /hectares/	Chemicals to be used	Frequency	Total price / VAT included/	Months
1	Airside	600	Poisoned food	1	7,800,000	May 2023
		600	Poisoned food	1	7,800,000	Oct 2023
<b>Total</b>				<b>2</b>	<b>15,600,000</b>	

Мэрэгч амьтны устгалыг гадна талбайд - 2 удаа /устгал хийгдсэнээс хойш 14 хоногийн дараа ирж цэвэрлэгээ хийх/ Хийгдэх газрууд: Авто зогсоолын орчмын талбай, Перрон орчмын талбай, Авто зам дагасан ногоон байгууламж. Нийт 600 га газар.

Rodent extermination in the airside area - 2 times (come and clean up 14 days after the extermination). A total of 600 hectares of land.

## Барилга байгууламжууд /Facilities/; Pesticide /Шавж устгал/

№	Name of facility	Area /sq.m/	Total area /sq.m/	Frequency	Work fee		Total price / VAT included/
					May 2023	Oct 2023	
1	Admin building	800m2	22,713m 2	2	6,813,900	6,813,900	13,627,800
2	Aerodrome building	4423m2					
3	Fire station	1136m2					
4	Ground handling building	4250m2					
5	Sewage Treatment Plant	1474m2					
6	Heating Plant	650m2					
7	Heating Garage	6015m2					
8	Cargo Terminal building	3125m2					
9	Main substation	170m2					
10	Water treatment Plant	670m2					
<b>Total price</b>							<b>13,627,800</b>

10 сард хийсэн шавжгүйтгэл  
устгалын тайлан

Тайлан бичсэн: ..... /"Улаанбаатар Ариутгал" ХХК-ны  
биологич Б.Төрболд /

Захиалагч: ..... /"Улаанбаатар хотын олон улсын нисэх  
онгоцны шинэ буудал" /

Улаанбаатар хот 2023 он

## Агуулга

### Шавжгүйтгэл, УСТГАЛ

- |                 |   |
|-----------------|---|
| 1. Ажлын тайлан | 2 |
| 2. Хавсралт     | 6 |

Манай “Улаанбаатар ариутгал” ХХК /5585511/ нь нийслэлийн эрүүл мэндийн газрын №АҮХ-17/22/3594 тусгай зөвшөөрөлтэйгээр ISO 9001:2015, ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлэн зөвшөөрөгдсөн шинжилгээний бичигтэй бодисоор халдваргүйтгэл хийдэг. Бид ахуйн хортон шавж, мэрэгч, халдваргүйтгэл хийх, хөрсний бохирдол болон орчны бохирдлыг бууруулах чиглэлээр эрүүл ахуйн чанарын шаардлагийг ханган үйлчилсээр байна.

Бид үйлчилгээндээ Монгол улсад хэрэглэхийг зөвшөөрсөн бодисын ангилалд багтсан хор бодисыг ашиглаж, МУ-ын MNS-51-61-3-2002, MNS-51-61-1-2002 стандарт арга аргачлалын дагуу үйлчилгээгээ чанартай, тогтмол гүйцэтгэдэг.

Чингис Хаан Олон Улсын Нисэх Буудал-тай хамтран ажиллах гэрээний дагуу **2023 оны 10-р сарын 21-ны өдөр шавьжгүйтгэлийн үйлчилгээг хийж гүйцэтгэлээ.**

**Шавьжгүйтгэлийг:** - Ариутгагч Г.Ган-Од, Д.Ганзориг Г.Тамир , нарын бүрэлдэхүүнтэйгээр, үйлчилгээндээ жилью 5% бодис, уусмал ашиглан хийж гүйцэтгэсэн болно.

Шавьжгүйтгэлийн үйл ажиллагаанд оролцсон багийн гишүүд хэрэглэсэн хамгаалах хувцас, цэвэрлэгээний материал, хог хаягдал зэргийг зориулалтын “BIOHAZARD” буюу тусгай хог хаягдал цуглуулах шар уутанд хийж, савны гадна талыг халдваргүйжүүлэлтийн уусмалаар шүршиж, зөөвөрлөж, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар”-ын дагуу устгасан болно.

## Ажлын тайлан

Шавжгүйтгэлийг нийт 22713м<sup>2</sup> газарт дараах газруудад хийж гүйцэтгэлээ.

1. Admin building
2. Aerodrome building
3. Fire station
4. Ground handling building
5. Sewage treatment plant
6. Heating plant
7. Heating garage
8. Cargo terminal building
9. Main substation
10. Water treatment plant

### Ашигласан бодис:

“Жилью” шавж устгах бодис

5% өндөр үр ашигтай Ветацеперметрины агууламжтай. Хүний эрүүл мэндэд хор нөлөө багатай, химийн 4-р зэрэглэлийн бодис

**Онцлог:** Бүх төрлийн шавж устгалд хэрэглэнэ. Энэ бүтээгдэхүүн зочид буудал ресторан, эмнэлэг, албан контор, айл гэр болон олон нийтийн газар ялаа, бясаа, жоом зэрэг шавж устгалд хэрэглэхэд нэн тохиромжтой.

### Анхаарах зүйл:

- Хэрэглэхийн өмнө нэг бүрийн хамгаалах хэрэгсэл өмсөх
- Мэдрэмтгүй болон харшилтай хүмүүс хэрэглэхгүй байх
- Хоол хүнсний зүйлийг битүүмжлэнэ. Хоол хүнс сав суулганд хүрвэл даруйсайтар урсгал усаар угааж цэвэрлэнэ
- Бодис хэрэглэсэн газар 7-14 хоногийн дараа угааж цэвэрлэх
- 2 цагийн дараа 20-30 минут өрөө тасалгаанд агаар сэлгэлт хийгээд оржболно.

Арьс салстад хүрсэн болон нүдэнд орсон тохиолдолд урсгал усаар зайлна. Хэрвээ хорсох, загатнах шинж илэрч байвал эмчид хандана



## Хавсралт

Үйлчилгээ үзүүлж буй зурган тайлан







10 сард хийсэн мэрэгч тандалт  
судалгаа, устгалын тайлан

Тайлан бичсэн: ..... /"Улаанбаатар Ариутгал"  
ХХК-ны биологич Б.Төрболд /

Захиалагч: ..... /"Улаанбаатар хотын олон улсын  
нисэх онгоцны шинэ буудал"/

Улаанбаатар  
2023 он

## Агуулга

### МЭРЭГЧИЙН ТАНДАЛТ СУДАЛГАА, УСТГАЛ

1. Тандалт судалгааны тайлан	2
2. Үр дүн	5
3. Хавсралт	6

## Тандалт судалгааны тайлан

Улаанбаатар ариутгал 8 хүний бие бүрэлдхүүнтэйгээр мэрэгчгүйтгэлийг 2023,10 сарын 16 ны өдөр хийж эхлэв. Ажлын аюулгүй ажилгааны дүрэм, хамгаалалт журмыг баримталсан болно.



**Зураг 1. Ажилсан баг бүрэлдэхүүн**

Шинэ нисэхийн буух зурваснаас өмнө Аэродром доторх 2 барилга дээр мөн мэрэгчгүйтлгэл хийсэн.





Аэродинам доктор мэрэгчийн үл мэр олдоон ба хорыг шаардлагатай бүх газар тавьж өгсөн


Шинэ нисэх онгоцны буудлын буух зурвасын орчинд мэрэгчний судалгааг явганаар явж, хээрийн бичиглэлийг шугаман трансектийн аргаар хийсэн ба талбайн нийт мэрэгчийг илэрхийлж чадахуйц 3 цэгийг сонгож ажиглалт хийсэн. Мэрэгчийн эсрэг устгалыг өглөөний 11:00 цагт эхэлсэн бөгөөд энэ хугацаанд бага зэргийн салхитай үүлэрхэг 10 хэмийн дулаантай байв. Талбайд гарсан 8 ажилтан хорыг цацахдаа хүн хооронд 10м зай барьж хорыг цацсан (зураг 2) ба тухайн үед таарсан үлийн цагаан оготны үүр байршил тоог тоолж авсан.



**Зураг 2. Тандалтын зохион байгуулалт**



Устгалын явцад таарсан үлийн цагаан оготны тоо толгойн нягтшил 428 байв.(Хавсралт 1) Мэрэгч амьтан нэг га талбайд 40-100 тоо толгойгоор байх юм бол тухайн бэлчээрийг доройтолд оруулахгүй, харин ч экологийн үүргээ гүйцэтгээд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх боломжтой гэж үздэг.



**Зураг 3. Ажилласан талбай**

Устгал тандалтаар явж үзэхэд үлийн цагаан оготны нүүдэл 1, 4, 5-р хэсгээр ихээр бүл үүсгэн амьдарч байна. Бусад хэсгээр өмнө үүрэлсэн үүрнүүд бүгд устгагдсан байна. Учир нь энэ хэсэг бусад хэсгээс хөл хөдөлгөөн ихтэй учраас мэрэгч булан хэсгээр үүрлэсэн.

## Үр дүн


Устгалын үр дүнг үзэх зорилгоор 2023 оны 11 сарын 9 нд талбай дээр ажиллав. Тандалтыг мөн шугаман маршрутаар талбайгаар явж үлийн цагаан оготны тоог гаргав. 1 га дахь цагаан оготны тоо толгойн нягтшил 5 болж буурсан нь өмнөх жилүүдтэй харьцуулахад үр дүнтэй байна гэж үзэж байна.

Өмнө идэвхитэй хор цацаж байсан нүхнүүд бөглөрч тухайн орчинд мэрэгч байхгүй өвсөөр битүүрсэн байдалтай байна. Мөн сая хор тавьсан нүхнүүд дахь хорыг мэрэгчүүд идсэн байдалтай олдсон ойр хавиар мэрэгчийн ул мөр байхгүй.



**Зураг 3. Өвсийг хадсан хадаагүй талбай**

Мэрэгч ихээр үржсэн хэсэг нь хашааны булан хэсгээр хадаагүй үлдсэн өвс ихтэй газар байршиж энэ нь мэрэгч амьтдын хоол тэжээлийн хангалттай нөөц болж үлдсэн байна. Харин хадсан хэсэгт мэрэгчийн бүл цөөн байна.



**Зураг 4. Өмнө тавьсан хулганы хорыг идсэн байдал**

Идэвхитэй үүрнүүдэд тавьсан хор идэгдсэн байдалтай олдсон ба ойр хавьд мэрэгчийн ул мөр олдоогүй нь үр дүнтэй гэж үзэж байна.

№	Газрын нэр	Амьдрах орчин	Он сар өдөр	Амьтны зүйл	Дош үлийн тоо
	1р талбай	Тал хээр	2023.10.17	Үлийн цагаан оготно	105
	2р талбай	Тал хээр	2023.10.17	Үлийн цагаан оготно	20
	3р талбай	Тал хээр	2023.10.17	Үлийн цагаан оготно	35
	4р талбай	Тал хээр	2023.10.17	Үлийн цагаан оготно	120
	5р талбай	Тал хээр	2023.10.18	Үлийн цагаан оготно	80
	6р талбай	Тал хээр	2023.10.18	Үлийн цагаан оготно	41
	7р талбай	Тал хээр	2023.10.18	Үлийн цагаан оготно	10
	8р талбай	Тал хээр	2023.10.18	Үлийн цагаан оготно	5
	9р талбай	Тал хээр	2023.10.18	Үлийн цагаан оготно	12
Нийт					428

**Хавсралт 1. Тооллогын дүн**

Олон салаа ерөөндөө гэр бүл 30-лаа амьдарна. Гэртээ унтлагын өрөөг үүрнээс доош 1м гүнд байрлуулдаг. Өвөл идэх өвсөө намар нөөцөлдөг. Муудаж ялзардаггүй агь өвсийг нөөцлөх дуртай. Үлийн цагаан оготно жилд хоёр удаа, тав болон долдугаар сард гөлчгий гаргадаг. Эрэгчин нь эмэгчинүүдээ хурааж, үржлийн үедээ 3-4 эм оготныг хээлтүүлдэг. Нэг удаа



дунджаар найман гөлчгий төрүүлнэ. Шилийн сар идлэг шонхор, хээрийн бүргэд болон хээрээр дамжин өнгөрдөг томоохон шувууд бүгд үлийн цагаанаар хооллодог. Мөн хярс, үнэг, өмхий хүрэн, мануул, хээрийн солонго, бамбай хоншоортын хоол болно. Ялгадас нь хөрсөнд нэн хэрэгтэй бордоо болж өгдөг.

Тоо толгойг цөөлж өгдөг жигүүртэн амьтдыг хашаан дотор оруулж ирээгүйн улмаас тоо толгой ихсэх нөхцөл болж өгч байна.



**Зураг 5. Хашаа завсартай**

Үлийн цагаан оготны тоо толгойг үргэлжлүүлэн энэ аргаар устгасан ч гадаад талбайгаас нэмж орж ирэх аюултай тул газраас дээш битүүлэх.



“НУБИЭ” ХХК

Хавсралт - 3

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн  
биелэлт

3/92-151

Шинжилгээний хариу, дүгнэлт



# ТЕХНИКИЙН ХЯНАЛТ



## Эрүүл ахуйн үнэлгээний дүгнэлт

Дугаар: INSP-2309110

Хэвлэсэн огноо: 2023-09-21

### I. Үйлчлүүлэгчийн мэдээлэл

Нэр **Нью Улаанбаатар Интернэйшл Эйрпорт ХХК**  
Хаяг **Төв аймаг, Сэргэлэн сум, Эрдэнэ-Уул 4-р баг, Тахилт толгой**  
Харилцах албан тушаалтан **Л.Аминаа, Байгаль орчны мэргэжилтэн**  
Утас:99150051 Имэйл: [aminaa.l@nubie-lc.mn](mailto:aminaa.l@nubie-lc.mn)

### II. Техникийн хяналт гүйцэтгэсэн байгууллагын мэдээлэл

Нэр **Хэлт энд Сэфти Солушинс ХХК**  
Хаяг **Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, УБ Тауэр барилга, 705 тоот**  
Итгэмжлэл **Үндэсний итгэмжлэлийн төвөөс ISO/IEC 17020, ISO 17025 стандартын итгэмжлэлтэй.**  
Хяналт гүйцэтгэсэн **Б.Төгсцогт, Эрүүл ахуйн техник хяналтын мэргэжилтэн**  
**Г.Магсармаа, Эрүүл ахуйн техник хяналтын мэргэжилтэн**  
Хөндлөнгийн ажиглагч **Л.Аминаа, Байгаль орчны мэргэжилтэн**

### III. Стандарт

Хэмжилтийн стандарт арга **MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага**  
**MNS 7000-1:2023 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Лабораторийн шинжилгээнд агаараас тоосонцорын сорьц цуглуулах арга. 1-р хэсэг: Нийт тоосны сорьц цуглуулалт**  
Тохирлын үнэлгээний стандарт **MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага**

### IV. Хэмжилтийн багаж

Загвар **Casella Sound Level Meter, CEL-62x**  
Багажны сериал дугаар **2078561**  
